

Лиахона



**Өнөө үед Сионыг барьж
байгуулах нь, х. 4, 20**

Ахлагч Рэнландтай танилц, х. 14

Өсвөр үеийнхэнд болон
хүүхдүүдэд заах 8 арга х. 28, 30

Гэрээ болон ариун сүмийн шүтлэг
бишрэл: Бурхантай харилцаагаа
гүнзгийрүүлэх нь х. 32, 36



*“Бүх зүйл Бурхан
байдгийг үзүүлдэг;
тийм ээ, бүр газар
дэлхий, мөн үүний
гадаргуу дээрх бүх
зүйл, тийм ээ, мөн
үүний хөдөлгөөн,
тийм ээ, мөн
түүнчлэн өөрсдийн
байнгын замаар
хөдлөх тэр бүх
гарагууд Эрхэм дээд
Бүтээгч байдгийг
гэрчилдэг юм.”*

Алма 30:44

АНУ-ын Виоминг мужийн
Жаксон нуураас авсан
тэнгэрийн заадсын зураг.

4



24 Зарифатын бэлэвсэн эмэгтэйн адил: Мацгийн өргөлийн гайхамшиг

По Ниэн (Филиппин) Чоу болон Петра Чоу нар

Бид ядууст болон гачигдагсдад туслахыг хүсэж байв. Мөн гэр бүлээрээ хувиа хичээх хандлагаа ялан дийлэхийг хүсэж байлаа. Бид шийдлээ мацгийн өргөлөөс олсон юм.

36 Гэрээндээ хүндэтгэлтэй хандсанаар Бурханыг дээдлэх нь

Ахлагч Жозеф В.Ситати

Бид авралын бүх гэрээ, ёслолыг хийж, сахин, Түүнтэй харилцах харилцаагаа улам бүр гүнзгийрүүлэхийн хэрээр Тэнгэрлэг Эцэгээ дээдэлж байдаг.

ЗАХИАСУУД

4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Өвөг дээдсийнхээ итгэлд үнэнч бай
Ерөнхийлөгч Томас С.Монсон

7 Айлчлагч багшийн захиас бичиг: Бидний эцэг эх байх чадамж

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

12 Багш нарын зөвлөлийн хурал юугаараа ялгаатай вэ?
Сандра Каттэлл

Багш нарын зөвлөлийн хурал дээр хэлсэн нэгэн санал түүний заах арга барилыг хэрхэн сайжруулсан тухай

14 Ахлагч Дэйл Г.Рэнланд: Дуулгавартай үйлчлэгч

Ахлагч Квинтин Л.Күк

Амьдралынхаа турш үйлчилж, шинээр дуудагдсан төлөөлөгч, ахлагч Рэнланд Их Эзэн дууддаг хүмүүсээ тэнцэхүйц болгодог гэдгийг мэддэг.

20 Энэтхэгийн анхдагч миний туулсан аян зам

Мангал Дан Диптигийн Жон

Сантош Муралд ярьсан түүх

Энэтхэгийн ширэнгэн ойд өсөж торнисон цагаасаа эхлэн төлөөлөгчөөр баптисм хүртээлэн, түүнтэй найз болох хүртэлх миний амьдралд зориулан хатгасан Их Эзэний хатгал мал төсөөлж байснаас ч илүү үзэсгэлэнтэй сайхан байлаа.

БУСАД ӨГҮҮЛЭЛ

8 Бошиглогч, төлөөлөгчид өнөөдөр ч үгээ хэлдэг: Шашны эрх чөлөөг дэмжих нь

10 Бид Христийн тухай ярьдаг: Өөр үнэт зүйлсийг эрхэмлэдэг хүмүүсийг хайрлах
Нэрийг нууцлав


28 Аврагчийн арга барилаар заах: Зааж байгаа өсвөр үеийнхнээ ойлгох нь

30 Аврагчийн арга барилаар заах: “Бяцхан үрсээ болгоогтун” Хүүхдүүдэд заахад суралцах нь

32 Сайн мэдээний сонгодог бүтээл: Ариун сүмд шүтэн бишрэх нь Бурханыг таньж мэдэх түлхүүр
Ахлагч Марион Д.Хэнкс

40 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой

80 Биднийг дахин уулзтал: Сүнслэг матрууд
Ерөнхийлөгч Боид К.Пакэр



ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: *Ганцаараа биш*, Минерва Тейчерт. Дотор талын хавтасны гэрэл зургийг Ронс Бэйр. Арын хавтасны дотор талын гэрэл зургийг Гай Коэн.



48

44 Гэртээ хугацаанаасаа өмнө эргэж ирсэн асуудлаа шийдэх нь Жэнни Роллинс


Номлолын хугацаанаасаа өмнө гэртээ эргэж ирсэн минь сэтгэл гонсойлгосон үйл явдал байсан. Надад болон миний хайртай хүмүүст тэр үед мэддэг ч байсан болоосой гэж бодогдсон зарим зөвлөгөөг дурдав.

48 Залуучуудын тухай хөрөг өгүүлэл: Францад хүчтэй хэвээр үлдэх нь

Минди Анне Сэлү
Францын армид байхдаа Пьер итгэлийнхээ үлгэр жишээ нь байхын тулд залбирч, судар судлахад тулгуурласан юм.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Дөхүүлэх санаа: Кат-ормон гэж юу вэ?



54

50 Сүмийн удирдагчдын хариулт: Ариун сүмийн адислалаас хэрхэн хүртэх вэ?

Ахлагч Роналд А.Расбанд

51 Нүдээ олсон хариулт

Романтик мэдрэмж гэж юу вэ? Өнөөдөр гайхамшигууд тохиолдож байна уу?

52 Үе тэнгийнхний шахалт ба писто

Киара Бланко

Би эцэг эхээсээ найзуудтайгаа үдэшлэгт явах зөвшөөрөл өгөхийг хүсэж шалсаар байв. Эцэст нь тэд намайг явуулсан боловч би тэднийг хурдан ирж, намайг аваасай гэж залбирч билээ.

54 Шинжлэх ухаан болон бидний үнэний эрэл хайгуул

Алисия К.Стантон

58 Бэлтгэ, тэгээд хий

Ахлагч Хьюго И.Мартинез

Их Эзэний зорилго бол гэр бүлийн түүх, ариун сүмийн болон номлогчийн ажлыг та нараар хийлгүүлэхэд оршдог.

60 Аврагчийг дурсан санах нь

Эрик Б.Мөрдок

Есүс Христийг үргэлж дурсан санах амлалтаа сахиснаас ирдэг таван адислал

64 Зурагт хуудас: Анхаарлаа дутуу хандуулж байна уу?

65 Би хэрхэн мэдсэн бэ?: Дэлхийд гэрэл нь байхад суралцах

Виктор Де Хэсүс Круз Варгас



Сайн уу!
Намайг Ивана гэдэг.

70

66 Чи хэн ч бай

Линда Дэйвийс

"Өө, үгүй ээ! Би гэр бүлтэйгээ лацдан холбогдоогүй болохоор яах болж байна вэ?" гэж Энди бодов.

68 Кларэнс ба Аварга

Лори Фүллэр

Хүн бүр Кларэнсийн уралдааныг үзэхээр мөн мэргэн ухааны үг үнэхээр үнэн эсэхийг мэдэхээр ирсэн байв.

70 Нэр төрөө өндөрт өргөн авч яваа хүүхдүүд: Найзууд ба итгэл

Мэлисса Харт

72 Төлөөлөгчийн хариулт: Номлогчдыг хэрхэн дууддаг вэ?

Ахлагч М.Рассэлл Баллард

73 Асуух булан

Аав, ээж хоёрыгоо маргалдах үед би санаа зовж, гунигладаг. Би юу хийж чадах вэ?

74 Мормоны Номын баатрууд: Ахмад Моронай зоригтой байсан

75 Би Мормоны Ном уншиж чадна

76 Мормоны Номын түүх: Ахмад Моронайн туг

79 Дуу хөгжим: Анхдагч хүүхдүүдийн түүхийг сонсоод

Жэнис Кэпп Пэрри

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Рассэлл М.Нэлсон,
Даллин Х.Өүкс, М.Рассэлл Баллард, Роберт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд
А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд

Эрхлэгч: Иосеф В.Ситати

Туслах редакторууд: Жэймс Б.Мартино, Кэрол Ф.Макконки

Зөвлөхүүд: Бризан К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт,
Крэг А.Кардон, Шэрил А.Эсплин, Кристоффэл Голдэн,
Даглас Д.Холмэс, Ларри Р.Лорэнс, Кэрол М.Стэфэнс

Удирдах захирал: Питэр Ф.Эванс

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:

Винсэнт А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Мэган Вэрхөф Сэйч

Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон,
Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Жилл Хакин,
Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мардок,
Салли Жонсон Одажөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу,
Ричард М.Ромни, Минди Аннэ Салу, Пол Вандэнбэрг,
Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тэдд Р.Петрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй
П.Андрус, С.Кимбалл Ботт, Том Чойлд, Нэйт Гайнс, Коллийн
Хинкли, Эрик П.Жонсэн, Смит Лофгрэн, Скотт М.Моой,
Марк В.Робисон, Рачэл Сюзан, Брэд Тиэри, К.Никол
Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Конни Вауторл Бриж, Жоли Бардэтт, Кэти
Данкан, Брайан В.Гайги, Жинни Ж.Нилсон, Гэйл Тэйт
Раффэрти

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жэфф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэвдик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн.

Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон
үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон
тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”
буюу “залагч”) албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд,
испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш,
маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш,
португали, румын, свахили, самоа, себуано, солонгос,
тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фикжи,
фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех,
швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх
дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2016 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиран олшруулж
болдохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

July 2016 Vol. 17 No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake
City, UT 84150. USA subscription price is \$5.00 per year;
Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid
at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue; old and
new address must be included. Send USA and Canadian
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2).

NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to
Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаа

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг оруулав.
Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



24-р хуудасны **“Зарэфатын бэлэвсэн эмэгтэйн адил: Мацгийн өргөлийн гайхамшиг”** өгүүллгийг гэр бүлээрээ уншсаныхаа дараа Хаадын Дээд 17 дээрх Зарэфатын бэлэвсэн эмэгтэйн түүхийг судал. Та дараа нь дараах асуултад хариулж болно. Мацаг барих нь хувь хүний болон гэр бүлийн хувьд биднийг хэрхэн адисалдаг вэ? Бидний мацгийн өргөл хэнийг адисалж болох вэ? Бид мацгийн өргөлийг илүү өгөөмөр өгснөөр гэр орон маань хэрхэн адислагдсаныг олж харах вэ? Та гэр бүлийнхэнтэйгээ мацгийн өргөлөө илүү өгөөмөр өгөх боломж болон ядуус, гачигдагсдад туслах бусад арга замын талаар ярилцаж болно.

Та 76-р хуудасны **“Ахмад Моронайн туг”** өгүүллээс ахмад Моронайн тухай гэр бүлээрээ хамтдаа уншиж болно. Дараа нь Алма 46:11–14-ийг уншаад, ахмад Моронайг “Бурхан, . . . шашин шүтлэг, эрх чөлөө, энх амгалан, эхнэр, хүүхд[ээ]” мөн хүмүүсээ хамгаалахад юу нөлөөлсөн болохыг ярилцаж болно. Эдгээр нь одоо ч чухал хэвээр бөгөөд өнөө үед ч гэсэн хурцаар шүүмжлэгдсээр байгаа билээ. Та гэр бүлийнхээ “эрх чөлөөний тугийг” босгож, өөрсдийн хамгийн чухал хэмээн үздэг зүйлсийг хамгаалах арга замыг ярилцах талаар бодоорой.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИНТЕРНЭТЭЭС ҮЗЭЖ БОЛНО

Лиахона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр languages.lds.org хаягаар орж үзэж болно. Сүнслэг захиас, гэр бүлийн үдшийн санаа, найзуудтайгаа болон гэр бүлийнхэнтэйгээ хуваалцаж болох зүйлийг олж мэдэхийг хүсвэл [facebook.com/liahona.magazine](https://www.facebook.com/liahona.magazine) хуудас руу орно уу (англи, португаль, испани хэл дээр байгаа).

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа болно.

Авралын төлөвлөгөө, 66

Анхдагчид, 4, 20, 79

Ариун Сүнс, 41

Ариун сүмийн ажил, 32, 43, 50, 58, 66, 70

Ариун явдал, 51

Ариун явдлын хууль, 51

Ариун ёслол, 36, 60, 64

Бурханлаг шинж чанар, 7

Гайхамшиг, 51

Гэр бүл, 7, 10, 66, 73, 76

Гэр бүлийн түүх, 42, 43, 58

Гэрээнүүд, 32, 36

Дуудлагууд, 41

Дуулгавартай байдал, 80

Есүс Христ, 4, 32, 60

Ёслолууд, 32, 36, 43

Заах, 8, 12, 28, 30

Залбирал, 24, 48, 68

Золиослол, 4

Зориг, 74, 75

Итгэл, 4, 44

Мацаг барих, 24

Мацгийн өргөл, 24

Мэргэн ухааны үг, 52, 68

Номлолын ажил, 40, 44,

58, 65, 70, 72

Өсвөр үеийнхэн, 28

Семинар, 58

Судраас судлах, 44, 48, 75

Тэнгэрлэг Эцэг, 36

Үе тэнгийнхний

шахалт, 52

Хайр, 10, 44

Хувь хүний үнэ цэн, 42

Хүүхдүүдэд, 7, 30

Хөрвөлт, 20

Цагаатгал, 10

Шинжлэх ухаан, 54

Эцэг эх байх, 7, 28, 30



Ерөнхийлөгч
Томас С.
Монсон

ӨВӨГ ДЭЭДСИЙНХЭЭ ИТГЭЛД ҮНЭНЧ БАЙ

Жон Линфорд эхнэр Мариа, гурван хүүгийн хамт Английн Гравели дахь гэр орноо орхин, агуу Солт Лэйкийн хөндий дэх гэгээнтнүүдтэй нэгдэхийн тулд олон зуун бээр аялах шийдвэр гаргах үедээ 43 настай байсан юм. Тэд номлолд үйлчилж байсан дөрөв дэх хүүгээ үлдээн, эд хогшлоо зарж, *Торнтон* нэртэй усан онгоцоор Ливерпулээс аян замдаа гарсан байна.

Тэдний Нью Йорк хот руу далайгаар, дараа нь Айова руу газраар хийсэн аялал гойд юмгүй хэвийн байв. Гэхдээ *Торнтон* усан онгоцоор ирсэн Линфордынхон болон бусад хожмын үеийн гэгээнтэн 1856 оны 7-р сард Жэймс Г.Виллигийн золгүй гар тэрэгний багт хамрагдан, Айова хотыг орхих үеэс гай зовлон тохиолдож эхэлсэн юм.

Хатуу ширүүн цаг агаар, хүнд бэрх аялал нь Жонд болон багийн олон гишүүнд муугаар нөлөөлж байв. Эцэст нь тэрээр хүндээр өвчилж, сульдаж туйлдсан тул түүнийг гар тэргэн дээр авч явахаас өөр аргагүй болсон билээ. Гар тэрэгний баг Вайомингт очих үед түүний биеийн байдал улам бүр доройтсон байв. Солт Лэйк хотоос аврах багийнхан 10-р сарын 21-нд Жоныг нас барснаас хэдхэн цагийн дараа ирсэн юм. Тэрээр өглөө эрт Свийтвотэр голын эргийн ойролцоо нас баржээ.

Жон гэр бүлээ Сионд авчрахын тулд ая тухтай, амар тайван амьдралаа зовлон зүдгүүр, гачигдал, хүнд сорилтоор сольсондоо харамссан болов уу?

Тэр нас барахынхаа өмнө “Үгүй ээ, Мариа. Өөрсдийгөө энд ирсэнд би баяртай байна. Би Солт Лэйкт хүрч чадахгүй ч чи хөвгүүдтэйгээ хүрч чадна. Хэрэв хөвгүүд минь Сионд өсөж торнин, гэр бүлээ өсгөн өндийлгөж чадвал би туулсан бүхэндээ харамсахгүй”¹ гэж хэлжээ.

Мариа хөвгүүдийнхээ хамт аялаа дуусгаж чадсан юм. Мариа 30-аад жилийн дараа өөд болох үед Жон тэр хоёр итгэл, үйлчлэл, үнэнч байдал, золиослолын өвийг үр хүүхдүүддээ өвлүүлэн үлдээж чадсан.

Анхдагч байна гэдэг бол “бусдын явах замыг бэлдэж эсвэл нээхээр бусдын урд явдаг хүнийг хэлдэг”² тул хожмын үеийн гэгээнтэн байх нь анхдагч байна гэсэн үг юм. Түүнчлэн анхдагч байна гэдэг нь золиослол гэж юу болохыг танин мэдэхийг хэлнэ. Хэдийгээр одоо Сүмийн гишүүдээс Сион руу аялахын тулд гэр орноо орхин явахыг шаардахгүй байгаа ч ихэнхдээ тэдэнд хуучин зуршил, урт удаан хугацаанд дагаж ирсэн уламжлал, хайрт найз нөхдөө орхих шаардлага гардаг. Зарим нь Сүмийн гишүүнчлэлийг нь эсэргүүцсэн гэр бүлийн гишүүдээ орхих хүндхэн шийдвэрийг гаргадаг. Гэхдээ хожмын үеийн гэгээнтнүүд хайрлаж явдаг, юунаас ч эрхэм хүмүүс нь тэднийг хэзээ нэгэн цагт ойлгож, хүлээн авна гэдэгт итгэн залбирсаар урагшилдаг юм.

Анхдагч байх зам амаргүй ч гэсэн бидний урд явж, дагах замыг үзүүлсэн хамгаас агуу анхдагч Аврагчийн зам мөрийг бид дагадаг.



олон сорилт бэрхшээлийг даван гарсан ч хэзээ ч итгэл алдарч байгаагүй.

1937 онд ахлагч Жорж Албэрт Смит (1870–1951) Мариагийн дурсгалд зориулсан булшны дэргэдэх ёслол дээр түүний үр садаас: “Та нар өвөг дээдсийнхээ итгэлд үнэнч амьдрах уу? хэмээн асуугаад, . . . [Тэдний] та нарын төлөө хийсэн бүх золиослолд зохистой байхыг хичээгээрэй”⁷ хэмээн хүсжээ.

Бид зүрх сэтгэл, гэр орон, нийгэм, улс орондоо Сионыг байгуулахаар эрэлхийлэх үедээ, сэргээгдсэн сайн мэдээний адислалыг Есүс Христийн Цагаатгалаар дамжин ирэх найдвар, амлалттай хамт хүртэх боломжийг олж авахын тулд байгаа бүхнээ зориулсан хүмүүсийн эрс шийдэмгий эр зориг, өөрчлөгдөшгүй итгэлийг үргэлж санаж байх болтугай. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Анджо Д.Олсэн, *The Price We Paid* (2006), 45–46, 136–137-г үзнэ үү.
2. *The Compact Edition of the Oxford English Dictionary* (1971), “pioneer.”
3. Лук 18:22
4. Иохан 14:6
5. Иохан 7:37; 3 Нифай 9:22-ыг үзнэ үү.
6. “Ирцгээ, ирцгээ гэгээнтнүүд ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 2.
7. Олсэн, *The Price We Paid*, 203–474-ийг үзнэ үү.

“Ирж, Намайг дага”³ хэмээн Тэрээр урьсан.

Тэр “Би бол зам, үнэн, амь мөн”⁴ хэмээн тунхаглаж,

“Над уруу ир”⁵ гэж урин дуудсан байдаг.

Энэ замаар алхахад хэцүү байж болно. Зарим хүнд ариун журмыг сахих, үнэнч шударга байх, Бурханы зарлигуудад дуулгавартай байх талаар болчимгүй нэгний дооглон тохуурхаж хэлсэн, эвгүй үгсийг тэвчиж өнгөрөөхөд хэцүү байж болно. Зарчмыг дагаж мөрдөх явдлыг дэлхийнхэн үргэлж дорд үзсээр ирсэн. Ноа хөвөгч авдар барих заавар хүлээн авах үед мунхаг хүмүүс бороо орон ортол үүлгүй тэнгэр өөд харан, дооглон, тохуурхаж байсан юм.

Олон зуун жилийн өмнө Америк тивд Зарахемла хот түймэрт шатан, Моронайха хот газарт булагдаж, Моронай хотыг усанд автах хүртэл хүмүүс эргэлзэн, маргалдаж, дуулгаваргүй хэвээр байсан. Харин энэ бүхэн болж өнгөрсний дараа элэглэл,

тохуурхал, хараал зүхэл, нүгэл үгүй болсон юм. Тэдгээр нь дүнсгэр нам гүм байдал, түнэр харанхуйгаар солигдсон байв. Бурханы тэвчээр барагдаж, төлөвлөснийхөө дагуу гүйцэлдүүлсэн билээ.

Мариа Линфорд Англид шашин шүтлэгийнхээ улмаас хавчигдан гадуурхагдаж, “Бурханы бэлдсэн нутагт”⁶ хүрэхээр аялах замдаа хүнд хэцүүг даван туулж, улмаар Сүмийнхээ мөн гэр бүлийнхээ төлөө

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Өөрсдийнх нь өмнө алхан, амьдралд нь анхдагч болсон хүмүүсийн тухай бодож үзэхийг зааж байгаа хүмүүсээсээ хүс. Дараа нь тэднээс хэзээ анхдагч болж, бусдын замыг бэлдэж өгч байсан талаар асуу. Тэднийг золиослуулах шаардлага гарч байсан цаг үеэ, яагаад үүнийг хийх нь зөв байсан талаар тунгаан бодоход урь. Дараа нь та тэднээс “хамгаас агуу анхдагч” болох Аврагчийн тухай гэрчлэлээ бичиж тэмдэглэхийг хүсэж болно.

Итгэлдээ үнэнч байх нь

Ерөнхийлөгч Монсон нэгэн анхдагч гэр бүлийн түүхийг өгүүлж, дараа нь ерөнхийлөгч Жорж Албэрт Смитийн: “Та нар өвөг дээдсийнхээ итгэлд үнэнч амьдрах уу? . . . [Тэдний] та нарын төлөө хийсэн бүх золиослолд зохистой байхыг хичээгээрэй” хэмээн хэлсэн үгийг эш татав. Та анхдагч өвөг дээдэстэй юу эсвэл Сүмийн эхэн үеийн гишүүн үү гэдгээс үл хамааран удирдамж, хүч чадал хүлээн авахын тулд итгэлийн үлгэр жишээг хардаг уу? Та үүнийг дараах арга замаар хийж эхлэх боломжтой.

1. Та хүндэлдэг хүмүүсийнхээ жагсаалтыг гарга. Тэдгээр нь гэр бүлийн тань гишүүд (нас барсан эсвэл амьд байгаа), найз нөхөд, Сүмийн удирдагчид, судар дээрх хүмүүс байж болно.

2. Танд таалагддаг тэдний зан чанарыг бич. Ээж тань үнэхээр тэвчээртэй юу? Магадгүй найз тань бусдад сайхан сэтгэлээр ханддаг байж болно. Эсвэл та ахмад Моронайн эр зоригийг хүндэлдэг байж болох юм.

3. Та жагсаалтаасаа нэг зан чанарыг сонгож аваад, “Би энэ чанарыг хэрхэн хөгжүүлж болох вэ? Би үүнийг хөгжүүлэхийн тулд амьдралдаа юу хийх хэрэгтэй вэ?” гэж өөрөөсөө асуугаарай.

4. Энэ зан чанарыг хөгжүүлэх төлөвлөгөө бичээд, үүнийгээ байнга харагдах, зорилгыг тань сануулж байх



газарт байрлуул. Тэнгэрлэг Эцэгийн тусламжийг хүлээн авахаар залбирч, өсөлт хөгжлөө тогтмол шалгаж бай. Та өөрийгөө энэ зан чанарыг хангалттай хөгжүүлсэн гэж үзвэл үргэлжлүүлэн ажиллах өөр нэгэн зан чанарыг сонго.


Бид агуу зан чанарыг өөрсдөдөө хөгжүүлснээр зөвхөн өвөг дээдсийнхээ итгэл, золиослолыг хүндэтгээд зогсохгүй эргэн тойрныхоо хүмүүст нөлөөлж чадна гэдгийг санаж яв.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Та ч бас анхдагч!

Анхдагч гэдэг нь бусдын замыг бэлддэг хүмүүс юм.

Нэг өвөг дээдсийнхээ зургийг зур эсвэл хайж ол. Тэд таны замыг хэрхэн бэлтгэсэн тухай түүхийг та олж мэдэх боломжтой юу? Та өнөөдөр анхдагч байж болох хоёр арга замыг бич. Та өөрийн санааг дараагийн гэр бүлийн үдэш дээр хуваалцаж болно!



Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийг эрэлхийл. “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг ойлгох нь хэрхэн таны Бурханд итгэх итгэлийг нэмэгдүүлэн, айлчлагч багшаар дамжуулан харж ханддаг хүмүүсийг тань адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Бидний эцэг эх байх чадамж

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс: “Бурханы сүнсэн хүүхдүүдийн хувьд мөнх бус амьдралд төрж, мөнх амьдралыг олж авахын тулд өсөж хөгжих боломжтой болох нь чухал байсан юм. Аз жаргалын агуу төлөвлөгөөний эцсийн зорилгыг авч үзвэл дэлхий болон тэнгэр дээрх хамгийн агуу эрдэнэс бол бидний үр хүүхэд, хойч үе гэдэгт би итгэдэг”¹ хэмээн заажээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн:

“Бид гэр бүл, үр хүүхэдтэй байхад итгэдэг. . . .

‘. . . Бурхан [Адам, Ева хоёрт], Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ’ [Эхлэл 1:28] гэжээ. . . .

Энэ зарлиг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд мартагдаагүй мөн орхигдоогүй юм”² хэмээн хэлсэн.

Бид бүтдээрээ энэ амьдралд эцэг эх болохгүй ч бүх насны



хүүхдүүдийг асран халамжилж чадна. Бид Тэнгэрлэг Эцэгийн гэр бүлийн нэг хэсэг байснаас ирдэг адислалуудыг хүлээн авч, дэлхий гэсэн нэгэн гэр бүлийн хэсэг байснаас ирэх баяр баясгалан, сорилт бэрхшээлийг амсдаг. Олон хүний хувьд эцэг эх байх үүргээ мөнх амьдралд хүлээн авах болно.

Нэмэлт судрууд

Дуулал 127:3; Матай 18:3–5;
1 Нифай 7:1; Мосе 5:2–3

ЭШЛЭЛҮҮД

1. Даллин Х.Өүкс, “The Great Plan of Happiness,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 72, 75.
2. Нийл Л.Андэрсэн, “Хүүхдүүд,” *2011 оны 10-р сарын Ерөнхий Чуулган*, 33.
3. Нийл Л.Андэрсэн, “Хүүхдүүд,” 33.



Итгэл, гэр бүл, халамж

Бодит түүх

Ахлагч Андэрсэн “Өнөөгийн дэлхий дээрх олон дуу хоолой хүүхэдтэй болохын ач холбогдлыг үл тоомсорлон, хойшлуулж, хүүхдийн тоог хязгаарлахыг уриалж байна. Манай охин саяхан вэб хуудсан дээр тавигдсан таван хүүхэдтэй Христийн шашинтай (манай шашны бус) нэгэн ээжийн бичсэн зүйлийг над руу явуулсан юм. Тэр эмэгтэй ‘Энэ соёл иргэншилд библид заасан шиг ээж байж, хүүхдүүдээ өсгөж хүмүүжүүлэх хэцүү болжээ. . . . Хүүхэдтэй болохоос илүүтэйгээр коллежид сурахыг хүсдэг болсон байна. Хүүхэдтэй байхын оронд дэлхийгээр тойрон аялж, чөлөөт цагаараа орой үдэш зугаалахыг илүүд үздэг болжээ. Хүүхэдтэй болох нь дасгалын танхимд биеэ чийрэгжүүлж, хүссэн ажлаа хийхээс доор зүйл болон хувирчээ’ гээд, ‘Эх байх нь сонирхол биш, харин дуудлага юм. Та нар маркнаас илүү эгдүүтэй гэж хүүхэд цуглуулдаггүй шүү дээ. Энэ нь завгүй хуваарийнхаа хооронд цаг гарган хийчихдэг зүйл биш, харин Бурханы танд хий хэмээн цаг хугацаа гарган өгсөн зүйл юм”³ гэжээ.

Үүнийг эргэцүүлэн бод

Бидний дэлхий дээрх гэр бүл тэнгэрлэг гэр бүлтэй юугаараа адил вэ?



Шашны эрх чөлөөг дэмжих нь

Сүмийн удирдагчид бүх үндэстний хүмүүс шашны эрх чөлөөг хөхиүлэн дэмжихэд хамтарч ажиллах ёстой хэмээн нэг бус удаа хэлж байсан.

2015 оны 4-р сард Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф АНУ-ын Калифорнийн Лос Анжелес дахь Өмнөд Калифорнийн Их Сургуулийн Жон А.Видцөгтийн нэрэмжит шашны симпозиум дээр “Сүмийн гишүүд бүх шашин шүтлэг, улс төрийн үзэл бодолд болон үндэстэн бүрийн хүмүүсийн дунд эе эвийг эрэлхийлдэг.

Хардаж сэрдэх, шалихгүй зан гаргах хуучин заншлаа орхин, нэг нэгнээ өөр өнцгөөс, харь хүн эсвэл

дайсан бус, харин хамтран аялагчид, ахан дүүс, Бурханы хүүхдүүд гэдэг талаас нь харахаар хичээх нь хүн төрөлхтний оршин тогтнох хүнд хэцүү боловч хамгийн үр ашигтай, эрхэм туршлага байдаг” гэж хэлсэн. Түүний энэ урилга бол сүүлийн үед бошиглогч, төлөөлөгчдийн бие биеэ хүндэлж, ойлгохыг уриалан дуудаж хэлсэн үгсийн нэг юм.

2015 оны 10-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс АНУ-ын Калифорнийн Сакраменто дахь Б'най Израиль цуглааны шашны удирдлагын буюу санваарын бага хурал дээр хэлсэн үгэндээ “Шашин, засгийн газар хоёрын хооронд дайсагнал байх ёсгүй.

Бид уур хилэн, дайсагнал, зөрчлөдөөний уур амьсгалд автсан үедээ бүгд хохирол амсдаг” гээд,

“Засгийн газар, тэдний хууль тогтоомж нь итгэгчдийг болон шашны байгууллага, үйл ажиллагааг зүй ёсоор хамгаалж байх ёстой” гэж хэлсэн. Мөн шашны зарчим, сургаал, байгууллагууд бүх хүнд “хамтдаа аз жаргал, эв нэгдэлтэй, амар тайван амьдарч, “нийтийн хууль, засгийн газрын байгууллага, иргэд цэцэглэн хөгжиж болох нөхцөлийг бүрдүүлэхэд тусалж чадна” гэдгийг онцлон тэмдэглэсэн.

Түүнчлэн, ахлагч Өүкс Аргентин дахь цугларалтаар шашны эрх чөлөөний тухай үг хэлсэн юм (“News of the Church,” *Лиахона*, 2016 оны 1-р сар, 16-г үзнэ үү).

2015 оны 6-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Английн Лондонгийн Лордын танхимд бүх намын гадаад харилцаа хариуцсан парламентын бүлэгт хандан үг хэлсэн. Тэрээр “Хүмүүсийн хамгийн гүн гүнзгий үнэт зүйлсийг хөнддөг шашин ба шашны байгууллагууд хүмүүсийг өдөөхийн зэрэгцээ тэдэнд уучлах, эвлэрэх, хувийн амьдрал, нийгэмд сайн сайхны төлөө дахин зүтгэх гэсэн хандлагыг төлөвшүүлэх өвөрмөц хүчин чадалтай” гэжээ.

2015 оны 4-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон Сан Пауло дахь Бразилын лалын шашны сүм дэх шашин хоорондын бүлэгт



Ахлагч Холланд Английн Лондон дахь парламентын гишүүдтэй уулзахдаа шашин шүтлэгтэй хүмүүст нийгмийг хөдөлгөх хүч бий хэмээн хэлжээ.

АНУ-ын Калифорни дахь шашны чуулган дээр ахлагч
Өүкс сүм, төр засаг хоёрыг хоорондоо хүндэтгэлтэй
✚ хандахад уриалсан.



Бразилын итгэгчдийн цугларалтаар
ахлагч Кристоффэрсон “шашны эрх
чөлөө бол амар амгалан байдлын
тулгуур чулуу” хэмээн хэлсэн байна.



Ерөнхийлөгч Угдорф эхнэр
Харриетын хамт АНУ-ын
Калифорни дахь шашны
удирдагчидтай уулзсан юм.



Ахлагч Расбанд Бригам
Янгийн Их Сургуулийн оюут-
нуудад Христтэй адил хайр-
ла гэсэн Түүний сургаалыг
дагахыг зөвлөсөн юм. ✚

хандан, “Шашны эрх чөлөө нь өөр хоорондоо өрсөлдсөн олон янзын гүн ухаан оршин тогтнож буй дэлхийн амар амгалан байдлын тулгуур юм” хэмээн хэлсэн байна. Тэрээр улс үндэстний шашны эрх чөлөөний хүчирхэг үндсийг тэмдэглэсэн үйл ажиллагааны үеэр ислам, католик, адвентист, еврей, протестант, хожмын үеийн гэгээн-тэн, уугуул спиритуалист, тодорхой итгэл үнэмшилгүй болон бусад хүнд хандан португаль хэлээр үг хэлсэн билээ. Тэрээр “Бид сонгосон шашин, итгэлээ ганцаараа эсвэл нийтээрээ, гэр орондоо эсвэл гэрээсээ гадна, олон нийтэд нээлттэй эсвэл хувиараа шүтэн биширч, сахих, дагах, заах бүх хүний эрх чөлөөг хадгалан, хамгаалахын тулд хамтдаа ажиллаж, амар амгаланг эрэлхийлэх болтугай” хэмээн хэлсэн.

2015 оны 5-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч

Квинтин Л.Кук Австралийн Сидней дэх Австралийн Нотредамын Их Сургуульд жил болгон зохион байгуулагддаг шашны эрх чөлөөний лекцэн дээр “Шашин шүтлэгтэй хүмүүс бусад нэн чухал эрх чөлөөг салбарлуулдаг шашны эрх чөлөөг хамгаалахын тулд тэргүүн эгнээнд зогсдог байх ёстой. “Бид зөвхөн өөрийн шашныг илэрхийлэх боломжоо хамгаалаад зогсохгүй шашин болгоны сургаал, хуулиудыг хэрэгжүүлэх эрхийг хамгаалах ёстой” гэж хэлсэн юм.

2015 оны 9-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роналд А.Расбанд АНУ-ын Ютагийн Прово дахь Бригам Янгийн Их Сургууль дээр оюутнуудад хандан үг хэлж байхдаа Далин ахлах ерөнхийлөгчөөр үйлчилж байв.

“Та нарын насны зарим хүн шашны бүлгүүд яагаад улс төрд оролцдог юм бол гэж гайхдаг бөгөөд шашин шүтлэгтэй хүмүүсийн

оролцох гэсэн сэдэлд эргэлзсэн байдалаар ханддаг.” Сүүлийн жилүүдэд улс төрийн хэлэлцээрт шашин үүрэг гүйцэтгэх ёсгүй гэж үзэх бүлэглэлүүдийн нэгдмэл дуу хоолой чангарсаар, “та бидэн шиг итгэлтэй хүмүүсийн хохирогч ангийг бий болгох аюулыг” нэмэгдүүлж байна.

Ахлагч Расбанд дэлхийн хэмжээнд тэдний үеийнхнээс энэ сэдвээр идэвхтэй оролцох хэрэгтэй байгааг оюутнуудад хэлсэн. “Бидэнд танай үеийнхний өрөвч сэтгэл, хүндлэл, шударга байдлын бодит ойлголт хэрэгтэй байна. Бидэнд эдгээр нарийн түвэгтэй нийгмийн асуудлыг шийдэхэд та нарын өөдрөг үзэл, шийдэмгий байдал хэрэгтэй байна.” Энэ бүхний хариулт Аврагчийн “Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биеэ хайрлагтун” (Иохан 13:34) гэсэн зарлигаас эхэлнэ гэж тэр хэлсэн. ■

Сүмийн мэдээ, үйл явдлыг news.lds.org-оос үзнэ үү.

ӨӨР ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ЭРХЭМЛЭДЭГ ХҮМҮҮСИЙГ ХАЙРЛАХ

Нэрийг нууцлав

Би хүүхдүүдээ ёс суртахууны өндөр ухамсартай хүмүүс болгон өсгөн хүмүүжүүлэх гэж хичээдэг байлаа. Гэтэл тэдний үлгэр дуурайл болсон хүмүүсийн нэг нь буруу сонголт хийх үед миний хичээнгүйлэн заасан бүхэн замхран алга болох вий гэж би эмээж байв.

Миний хадам эгч Жэний (нэрийг нь өөрчилсөн) сайн мэдээнд өссөн, Сүмийн үнэнч гишүүн байсан. Түүний аз жаргалтай ариун сүмийн гэрлэлт төгсгөл болсны дараа, амьдардаг жижиг тосгоных нь хүмүүс цуурхал тарааж, түүнийг шүүмжилж эхлэв. Тэр олон найз нөхдөөсөө, эцэст нь Сүмээсээ холдсон юм.

Тэр Энди гэдэг залуутай болзож эхлэн, удалгүй хамт амьдрах болов. Би хүүхдүүддээ юу гэж хэлнэ дээ гэж санаа зовж байлаа. Гурван бяцхан охин минь авга эгч Жэнийдээ хайртай байв. Манай гэр бүлүүд ойр дотно байгаад зогсохгүй тэр охидын маань бүжгийн багш байсан учраас тэд долоо хоногт хэд хэдэн удаа уулздаг байсан юм.

Олон сарын турш тэд Эндиг дэндүү олон удаа айлчилж ирээд байна гэж боддог байв. Эцэст нь би Жэний, Энди хоёр хамт амьдарч байгаа гэдгийг тэдэнд хэлэхээс өөр аргагүй болов. Би тэдний хийсэн сонголт ноцтой нүгэл гэдгийг тэдэнд тайлбарлаж өгсөн юм. Охид ойлгож байх шиг санагдсан бөгөөд бидэнд сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахын ач холбогдлын тухай ярилцах гайхалтай боломж олдсон билээ.

Дараа нь байдал муугаар эргэв. Жэний, Энди хоёр хүүхэдтэй болох гэж байгаагаа гэр бүлийнхэндээ баяр хөөртэй зарлалаа. Би энэ мэдээ хүүхдүүдэд хэрхэн нөлөөлөх бол гэдэгт дахиад л санаа зовох болов. Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ дэлхий дээр авчрахыг хүсдэг арга зам энэ биш гэдгийг тэд ойлгож байгаа болов уу? Хэрэв тэд ийм орчинд байвал энэ нь хүлээн зөвшөөрч болох, энгийн зүйл гэж үздэг болох болов уу?

Би энэ шинэхэн мэдээг хүүхдүүдэд хэлэхийг хүсээгүй учраас хэдэн долоо хоног дотроо шаналсаар

явав. Сарын дараа Жэний, Энди хоёр гэрлэх шийдвэр гаргав. Тэд хүсэн хүлээж байсан жирэмслэлтийнхээ тухай яагаад гэрлэснийхээ дараа хэлж болоогүй юм бол?

Дургүйцсэндээ дотор минь буцлах шиг л болж байлаа. Би Жэнийн хийсэн зүйлийг нь биш, харин түүнийг хэрхэн хайрлаж болох вэ? Авга эгчийнхээ хийсэн сонголтыг нь биш, харин түүнийг өөрийг нь үргэлжлүүлэн хайрлахыг хүүхдүүдэд би хэрхэн заах вэ?

Нэгэн өдөр эгч маань тойргийнхоо жирэмсэн болсон залуу



ҮНЭНИЙГ ДАГАХ АМЛАЛТ

“Бусдад болон тэдний итгэл үнэмшилд гаргаж буй тэвчээр, үзүүлж буй хүндэтгэл нь биднийг ойлгосон үнэн, хийсэн гэрээнүүдээ зөрчихөд хүргэдэггүй. . . . Бид өөр итгэл үнэмшил, санаа бодолтой хүмүүст тэвчээртэй хандан, хүндлэл үзүүлж байхдаа ч гэсэн үнэний төлөө зогсох ёстой. . . .”

Бид хүүхдүүддээ болон бусдад заах үүрэг хүлээдэг шиг, үнэний өмнө бидний хүлээсэн үүрэг нэн чухал юм. Заахдаа гаргасан хүчин чармайлтын маань үр дүн зөвхөн бусдын сонгох эрх чөлөөн дээр тулгуурладаг учраас бид үргэлж хайрлаж, тэвчиж, ухуулан заах ёстой.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс, “Balancing Truth and Tolerance,” *Лиахона*, 2013 оны 2-р сар, 32, 33.



Авга эгчийнхээ хийсэн сонголтыг нь биш, харин түүнийг өөрийг нь үргэлжлүүлэн хайрлахыг хүүхдүүддээ би хэрхэн заах вэ?

эмэгтэйн тухай надад ярив. Тэр залуу эмэгтэй сүмдээ үргэлжлүүлэн явж байгаа бөгөөд удахгүй амьдралд нь тохиох гэж буй үйл явдалд аз жаргалтай, баяр хөөртэй байгаа мэт харагддаг байж. Харин залуу эмэгтэйчүүд түүний нөхцөл байдалд хэт хөнгөн хуумгай хандаж байгаа нь түвэгтэй байлаа.

Харин залуу эмэгтэйн ээжийнх нь айлчлагч багш байсан эгч тэрээр ийм хүнд байдалд хүргэсэн сонголт хийсэндээ хэчнээн олон шөнө шаналж, уйлдаг байсныг мэдэж авчээ. Уг залуу эмэгтэй олон долоо хоногийг зовж гарчлан өнгөрүүлсний дараа, хийсэн үйлдэлдээ гашуудсаар байх уу эсвэл урагш явж, аз жаргалтай байх уу гэдгээ шийдсэн байна. Тэр Христийн цагаатгагч золиослолын ачаар гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хүлээн зөвшөөрч, наманчлалаар дамжуулан дахин цэвэр болж чадсан юм.

Жэний үүнтэй адил зүйлийг туулсан байх даа гэж би бодов. Тэр хийсэн сонголтондоо харамсаж байгаа ч үр дагаврыг нь өөрчилж чадахгүй тул нөхцөл байдлаа хүлээн зөвшөөрч, урагш явахаар шийдсэн юм болов уу?

Би хатуурхаж шүүсэндээ мөн Есүс Христийн биднээс хүсдэг арга замаар хайрлаж чадаагүйдээ ичиж билээ. Би Аврагчийн амьдралыг эргэцүүлэн бодоход, Тэр үргэлж нүгэлтнүүдэд хүрч очин, Өөрийн үгээр болон үлгэр жишээгээр зааж, тэднийг хайрладаг байсныг санав. Энэ бол зүрх сэтгэлийг зөөллөж, хүмүүсийг өөрчилдөг хайр юм.

Би ихэнхдээ хүмүүсийг зөвхөн зөв гэж үзсэн арга замын маань дагуу үйлдэж байгаа үед л хайрладаг байснаа мөн тэднийг алдаа гаргангуут зүрх сэтгэлдээ буруутгадаг байснаа ойлгосон. Би ямар хоёр нүүртэй байсан юм бэ? Би наманчлах

хэрэгтэй гэдгээ ойлгож билээ. Би нүглийг хүлээн зөвшөөрөөгүй ч нүгэлтнийг хайрлаж сурах хэрэгтэй гэдгээ ухаарсан. Эцэст нь би Жэнийд уурлахаа больж, түүнийг дахин чин сэтгэлээсээ хайрлах болов.

Надад хүүхдүүдтэйгээ дахин нэг удаа сайхан ярилцах боломж гарч ирсэн. Би хүүхэдтэй болохоосоо өмнө гэрлэх нь чухал талаар онцлон ярьж билээ. Бид гэр бүлд маань шинэ хүүхэд төрөхийг тэсэн ядан хүлээж байв. Бид Жэнийг дэмжиж, түүний амьдралын энэ онцгой цаг мөчийг хамтдаа хуваалцахыг хүсэж байлаа. Хүүхдүүд минь авга эгч Жэний нь буруу зүйл хийснийг ойлгосон ч түүнийг болон авга ах Эндийгээ хайрласан хэвээр байсан бөгөөд тэдний гайхалтай гэр бүл хэзээ нэгэн өдөр бидний Аврагч, Есүс Христийн дэлгэсэн мутарт эргэн ирэх шийдвэр гаргана гэдэгт итгэдэг. ■

Багш нарын ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ ЮУГААРАА ЯЛГААТАЙ ВЭ?

Багш нарын зөвлөлийн хурал дээр хэлсэн нэгэн зүйл миний багшлах арга барилыг төдийгүй амьдралыг маань өөрчилсөн юм.



Багш нарын зөвлөлийн хурал Сандра Каттэллд (голд буй) заах үр чадвараа дээшлүүлэхэд тусалж байна.

Сандра Каттэлл

Би нэлээн нас ахисан учраас Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт заах дуудлага өгөхөд нь “Ээ тэнгэр минь! Тэд яагаад намайг дуудсан юм бол?” гэж бодож билээ.

Би залуу эмэгтэйчүүдийнхээ хэрэгцээнд нийцсэн хичээл бэлтгэхийн тулд ихээхэн хичээж чармайсан бөгөөд тэднийг сурч мэдсэн, долоо хоногийн турш хийсэн зүйлээ хуваалцах байх гэж найдаж байлаа. Гэсэн ч тэд асуултад минь ихэнхдээ хариулдаггүй байв.

Тойргийн багш нарын зөвлөлийн анхны хурлуудын нэгэн дээр нэг багш өсвөр үеийнхэнтэй хичээлийн үеэр

харилцан ярилцахад хэцүү байгаа талаар дурдахад өөр нэгэн багш “Зүгээр ээ, нам гүм байх нь дажгүй зүйл” гэж хэлсэн юм. Заримдаа хүмүүст хариулахын өмнө бодох хугацаа хэрэгтэй байдаг.

Багш нарын зөвлөлийн хурал дээр хэлсэн дээрх зүйл миний заах арга барилыг төдийгүй суралцагчдыг маань өөрчилсөн. Би энэ талаар нэлээн бодов. Дараагийн Залуу эмэгтэйчүүдийн хичээл дээр ангийнхнаасаа долоо хоногийн турш ямар сайн мэдээний зарчмыг амьдралдаа хэрэгжүүлсэн талаар асуулаа. Нөгөө л нам гүм байдал үргэлжлэв. Харин би нам гүм байдлыг эвдэхээр шууд ярихын оронд багш нарын зөвлөлийн

ЯАГААД БАГШ НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫГ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Бид бүгд Бурханы хүүхэд учраас сайн мэдээний талаар суралцаж, үүний дагуу амьдрахыг хүссэн хэн боловч Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адилхан болох боломжтой. Биднийг сайн мэдээнээс суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэхэд багш нар чухал үүрэг гүйцэтгэдэг.

Багш нарт туслах үүднээс Тэргүүн Зөвлөл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас Сүмийн тойрог, салбаруудыг багшийн зөвлөлийн хурал хийдэг байхад уриалсан. Сар бүр хийгддэг энэ хурал багш, удирдагчдыг заах санаагаа харилцан солилцох явцдаа хамтдаа суралцах боломжийг олгоно.

Эдгээр хурал нь шинээр нэвтрүүлж байгаа хөтөлбөр бөгөөд багш, суралцагчдын аль алинд эергээр нөлөөлж эхэлсэн билээ. Багш нарын зөвлөлийн хурлын ач холбогдлыг ойлгосон, энэ хуралд суух дуртай хүмүүсийн сэтгэгдлийг доор дурдав.

- Прэстон Стратфорд: “Дэмжлэг туслалцаа үзүүлэх системтэй болсон нь надад их тус дэм болж байгаа. Багш бидний хувьд заримдаа багшлахыг ганц хүний хийдэг ажил гэж үздэг. Гэхдээ энэ дуудлагыг ойлгодог бүлэг хүмүүстэй асуудал, санал бодол, сэтгэгдлээ хуваалцан, хариу санал бодлыг нь сонсох зөвлөл эсвэл хэлэлцүүлэгтэй байх нь энэ байдлыг өөрчилж байгаа.”
- Маргарет Түллэр: “Багш нарын зөвлөлийн хурал надад суралцахуйг дэмжихэд гаргаж буй хүчин чармайлтынхаа ач холбогдлыг ойлгоход тусалдаг.”

хурал дээр ярилцсан зүйлээ санаад, дотроо “Яарал хэрэггүй” гэж хэлэв.

Намайг өөртөө ингэж хэлэнгүүт ярилцлага өрнөж эхлэх нь тэр. Нэг залуу эмэгтэйд ярьж эхэлсний дараа тэд сэтгэл хөдөлгөм туршлагаасаа хуваалцаж эхлэв. Би тэр даруй багш нарын зөвлөлийн хурал дээр нам гүм байдлын талаар энгийн санал хуваалцсан багшид талархахыг хүсэж билээ. Ганцхан зарчмаар дадлага хийхэд богинохон хугацаанд ийм их өөрчлөлтийг авчирсан нь гайхалтай байлаа.

Гэхдээ энэ болон миний мэдэж авсан өөр зарчмууд ямар их өөрчлөлт авчирч байгааг би хожим ойлгосон юм. Сүм тарсны дараа манай нэг залуу эмэгтэйн ээж



- Ричард Паттий: “Багш нар ‘хичээл хэрхэн заах’ гэхээсээ илүүтэй ‘хэрхэн хүмүүст заах’ тухай шинэлэг санаа олж авдагт би баяртай байдаг.”
- Кэн Соннэнбэрг: “Асуулт тавих, оролцоог дэмжих арга замаа хэрхэн сайжруулах талаар хэлэлцэх нь их өгөөжтэй байсан. Амжилт ололт, саад бэрхшээлээ ярилцах нь ч гэсэн надад гүн ойлголт өгдөг.”
- Брэнт Нэлсон: “Энэ зөвлөл бидэнд илүү сайн багш болгох ур чадварыг маш сайн зааж өгсөн. Ур чадвартай багш байх нь ангийн бүх хүнд ашигтай. Хэдийгээр энэ нь багш нарын зөвлөлийн хурал ч гэсэн сүнслэг байдлаараа өсөж хөгжиж байгаагаа би мэдэрдэг.”
- Камилл Фронк: “Заах арга барилаа сайжруулах талаар тархиа гашилгах нь сайн хэрэг.”

Багш нарын зөвлөлийн хурал болон Аврагчийн арга барилаар заах нь товхимлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг zaax.nylds.org вэбсайтаас авна уу.

охиноо намайг Бурханаар дуудагдсан гэдгийг мэднэ гэж хэлснийг надад хэлсэн.

Үүнийг сонсох нь надад хэчнээн сайхан байсныг үгээр илэрхийлэх аргагүй юм. Гэтэл би “Энэ залуу эмэгтэйчүүдэд би юугаа ч заах юм билээ?” гэж бодож байсан гээч. Харин би тэдэнд зааж байсан байна. Би ямар нэгэн зорилгын төлөө дуудагдсан байв. Харин багш нарын зөвлөлийн хурал надад уг зорилгоо биелүүлэхэд тусалж байгаа. ■

Зохиогч нь Шотландад амьдардаг.

Заах арга барилаа өөрчилснөөр бусдын амьдралыг хэрхэн өөрчилж болох талаарх дэлгэрэнгүй мэдээллийг zaax.nylds.org-оос авна уу.

Ахлагч Дэйл Г.Рэнланд ДУУЛГАВАРТАЙ ҮЙЛЧЛЭГЧ

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Квинтин Л.Кук

Тухайн үед Дэйл Рэнланд, Рут Рэнланд хоёроос илүү завгүй амьдралтай хүн байгаагүй байх.

Тэд гучин нас хүрээгүй байхдаа АНУ-ын Мэриланд мужийн Балтиморт амьдарч байв. Дэйл Ютагийн Их Сургуулийн Анагаахын сургуулийг төгссөн байлаа. Тэрээр шаардлага өндөртэй, нэр хүндтэй Жон Хопкинсийн Анагаахын сургуульд дадлагажихаар Руттай хамт улсын нэг захаас нөгөө зах руу нүүжээ. Тэд Ашлий гэдэг хөөрхөн бяцхан охинтой байв. Хайрт эхнэр Рут нь хорт хавдрын эмчилгээ хийлгэж байсан ч Дэйл бишпоор үйлчлэх дуудлагыг дуулгавартай хүлээн авсан байна.

Дэйл тойргийнхоо гишүүдийн гэрт айлчлахдаа заримдаа Ашлийгаа дагуулан явдаг байв. Нэгэн өдөр тэд идэвх султай гишүүний гэрт айлчлан очжээ. “Надтай хамт яваа энэ хөөрхөн охиныг хэн ч үүднээсээ буцаахгүй гэдгийг би мэддэг байлаа” хэмээн ахлагч Рэнланд дурсан байдаг. Өмнө нь бишоп Рэнландийн зөвлөхийг үүднээсээ ууртай хөөн явуулсан хүний хаалгыг тэрээр тогшжээ.

Хаалгаа бүхэлд нь тэгнэн, том биетэй эр үүдээ нээж, бишоп Рэнландийг

цоо ширтэв. Гэтэл дөрвөн настай Ашлий “Биднийг оруулах юм уу, үгүй юм уу?” гэж пал хийтэл хэлэх нь тэр.

Гайхалтай нь өнөөх эр “Тэгэхээс дээ. Дотогшоо орцгоо” гэв.

Тэднийг гэрт орж суусны дараа уг эр бишоп Рэнландад Сүм үнэн гэдэгт итгэдэггүй бас Есүс Христэд итгэдэггүй гэдгээ хэлжээ. Тэрээр Ашлийг тоглоом тоглож байх хооронд бухимдангуй ярьсаар байв. Эцэст нь Ашлий сандлаасаа босоод, гараа аавынхаа чихэн дээр тавин, “Аав аа, түүнд үнэнийг хэлж өг” гэж дууддахуйц шивнэлээ.

Бишоп Рэнланд ч охиныхоо хэлснээр хийж, уг эртэй гэрчлэлээ хуваалцсан байна. Тэр “Түүний хандлага зөөлөрч, Сүнс түүний гэрт орж ирсэн” хэмээн дурссан байдаг.

Одоо Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүний хувьд ахлагч Рэнланд бүх дэлхийд үнэнийг хэлэх боломжтой болж байна (С ба Г 107:23-ыг үзнэ үү). Ахлагч Рэнланд “Хамгийн агуу баяр баясал нь хаа газрын хүмүүсийн амьдралд Христийн Цагаатгалыг авчрахад туслах

үед ирдэг. Надад энэ дуудлага энэхүү ажлыг бүхий л дэлхийд, илүү өргөн хүрээнд, илүү олон газарт хүрч хийх боломжийг



Эсрэг талын хуудсанд: Ахлагч Рэнланд ба түүний шведээр ярьж, Ютад өсөж торнисон ах дүү нар (Анита, Линда, Гари). 1950 онд Скандинавын болон Европын орнуудад ариун сүм байгаагүй тул ариун сүмд лацдан холбогдохоор Шведээс Юта руу ирсэн түүний эцэг эх Акэ, Мариана нар. Баруун гар талд: Рэнланд ах эгч хоёр, охин Ашлийтайгаа АНУ-ын Мэриланд мужийн Балтиморт зургаан жил амьдарсан бөгөөд тэнд тэрээр Жон Хопкинсийн эмнэлэгт дадлагын болон зүрх судасны туслах эмч хийж, харин Рэнланд эгч Мэриландийн Их Сургуулийн Хуулийн сургуулийг төгсжээ.





сүм 1955 онд онцгойлон адислагдсан) хосууд Солт Лэйкийн ариун сүмд лацдан холбогдохын тулд Ютад ирсэн байна.

Ахлагч Рэнландийн дүү Линда С.Маурэр, түүнээс долоон насаар дүү бөгөөд аав ээжийнхээ талаар дурсахдаа дөрвөн хүүхэд нь өсөж том болохын хэрээр “эцэг эх нь сайн мэдээнээс болон ариун сүмийн гэрлэлтээс ирэх адислалаас хүртэхийн тулд ямар ч англи хэлний мэдлэггүй, бараг ямар ч дэмжлэг тусалцаагүйгээр өөр улсыг зорьсон нь тэдний ямар их гайхалтай, итгэлтэй байсныг ойлгуулсан” хэмээн хэлсэн байдаг.



Христийн гэрчийн хувьд олгож байна гэж бодож байна” гэж хэлсэн.

Скандинав хүмүүжил

Дэйл Гуннар Рэнланд нь 1952 оны 11-р сарын 3-нд АНУ-ын Юта мужийн Солт Лэйк хотод төржээ. Тэр ах, эгч, дүү нартайгаа швед хэлээр ярьж өссөн байна. Тэдний ээж Мариана Андэрссон нь Шведээс, харин аав Матс Акэ Рэнланд нь Финляндын баруун зүгт байх швед хэлтэй хотоос ирсэн байв. Тэд 1950 онд Шведээс Юта руу цагаачлан ирсэн байжээ.

Дэйлийн эцэг эх Стокгольмын сүмд танилцсан аж. Тэд гэрлэхээр шийдсэнийхээ дараа зөвхөн ариун сүмд гэрлэх болзол тавьсан байлаа. Тухайн үед Европт ариун сүм байгаагүй тул (Швейцарийн Берний ариун



Дэйлийг 11 настай байхад чадварлаг мужаан, барилгачин аав нь Шведэд барилгын номлогчоор гурван жил ажиллах болсон байна. Тэд гэр бүлээрээ Финляндын Хельсинкэд мөн Шведийн Готенбургт амьдарч байжээ. Тэд Сүмийн жижигхэн салбарт явж, хүүхдүүд нь Шведийн энгийн сургуульд сурдаг байлаа. Дэйлээс нэг насаар дүү Анита М.Рэнланд “Хэдийгээр бид гэртээ шведээр ярьдаг байсан ч хэл зүйн ба зөв бичгийн дүрэм мэддэггүй байсан болохоор энэ нь эхлээд бидэнд хүчтэй цохилт болсон юм” хэмээн шилжин суурьшихад ямар хэцүү байсан тухайгаа дурсжээ.

Бага насандаа Дэйл Мормоны Номыг уншсаныхаа дараа, гэрчлэлийг нь хүчирхэгжүүлсэн туршлагыг олж авсан ажээ. Швед дэх номлолын ерөнхийлөгч Аароны санваартан хөвгүүдийг Мормоны Номыг уншихад урьсан бөгөөд тухайн үед 12 настай байсан Дэйлийн ах Гари урилгыг хүлээн авсан байна. Арваннэгэн настай байсан Дэйл ч гэсэн урилгыг хүлээн авсан байлаа. Тэр Мормоны Номыг уншсаныхаа дараа, уг ном үнэн эсэхийг мэдэхээр залбиран асуужээ. Ахлагч Рэнланд энэхүү үйл явдлын талаар хэлэхдээ: “Би чамд үнэн гэдгийг энэ бүх



2016 онд ахлагч Рэнланд эхнэр, охин хоёртойгоо (дээр буй) Солт Лэйк хот дахь Рүүтстэк гэр бүлийн түүхийн чуулганд үг хэлсэн. Эсрэг талын хуудсанд: 1977 онд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн ахлагч Рэнланд, Рэнланд эгч хоёр хаана ч ямар ч үед дуудагдсан бай, Их Эзэнд үйлчилдэг байсан юм.



хугацаанд хэлээд л байсан шүү дээ' гэсэн маш тодорхой мэдрэмж надад төрсөн. Энэ нь миний хувьд гайхамшигтай үйл явдал байсан” хэмээн өгүүлжээ.

Гэр бүлээрээ Америкийн Нэгдсэн Улсад дахин очиж, нүүж ирснийхээ дараа ч гэсэн Дэйл болон түүний ах Гари, дүү Анита, Линда нар хоорондоо шведээр ярьж, залбирдаг байсан гэдгээ дурдсан байдаг. Түүнээс гадна тэдний эцэг эх судрын мэдлэгийг ихэд чухалчлан авч үздэг байсныг онцлон хэлжээ. Тэд “Аав ээжтэйгээ үзэл бодлоо илэрхийлэхдээ судар ашиглах нь хамгийн оновчтой арга зам байсан” хэмээн хэлсэн юм. Анита “Судрын мэдлэгтэй байх нь бидний хувьд сонголт байгаагүй бөгөөд гэр бүл дотроо амьд гарах цорын ганц арга зам байв” хэмээн хошигнон хэлжээ.

Хамгийн гайхалтай нь Гари, Дэйл хоёр хоёулаа Шведэд, хамтдаа үйлчлэхээр дуудагдсан байв. Тэд хамтрагчид байгаагүй ч хоёр жил гаруй хугацаанд швед хэлнийхээ чадварыг Их Эзэнд үйлчлэхэд ашиглах боломжтой байсан билээ. Номлолд хийх ажил их байсан ч гайхалтай туршлага болсон тухай ахлагч Рэнланд: “Энэ нь Христийн

шавь байхын тулд чадах бүхнээ хийх үүрэг амлаалт авч, шийдвэр гаргах тухайд миний амьдралыг орвонгоор нь өөрчилсөн зүйл байсан юм” хэмээн хэлсэн байна.

Хамгийн гайхамшигт адислал

Дэйл 1974 онд номлолоосоо буусныхаа дараа Ютагийн Их Сургуульд суралцжээ. Тэр сайн оюутан байсан бөгөөд химийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгсөв. Ах дүү нар болон найзууд нь түүнийг ямар ч зүйлд бүхий л чадавхаа дайчлан, анхаарлаа төвлөрүүлж, хичээнгүйлэн хөдөлмөрлөж, эцсийг нь хүртэл явдаг гээд одоо ч гэсэн үзүүлдэг зан чанарыг нь дурдсан байдаг. Гари “Тэр миний мэдэх хамгийн хөдөлмөрч хүн” хэмээн дуу алдан хэлсэн юм.

Тойрогтоо Дэйл Рут нэртэй бүсгүйтэй танилцсан байна. Тэр бүсгүй гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн, дараа нь Далын чуулгад үйлчилсэн Мэрлин Р.Либбэртийн охин байлаа. Дэйл зориг гарган, Рутыг болзоонд урихад, бүсгүй үгүй гэсэн хариу өгсөн ч хэдэн сарын дараа дахин урихад зөвшөөрсөн гэдэг. Харин Рутын санаж байгаагаар, үйл явдал арай өөрөөр өрнөжээ. Ариун ёслолын цуглаан дээр Дэйл номлолынхоо талаар ярьсан нь түүнд гүн сэтгэгдэл төрүүлсэн байв. Тэд дотносон танилцаж, улмаар тэр болзоонд урихад нь баярласан боловч үдэшлэг удирдан зохион байгуулах хэрэгтэй байсан тул зөвшөөрөөгүй байна. Харин дахин болзоонд урихад нь бүсгүй баяртайгаар зөвшөөрчээ.

1977 онд Дэйлийг Ютагийн Их Сургуулийн Анагаахын сургуульд сурч, Рут Солт Лэйк хотын Өмнөд дунд сургуульд багшилж байхад тэд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн юм. “Сүмд идэвхтэй байх шийдвэрээс гадна Руттэй гэрлэсэн нь миний амьдралын хамгийн гайхалтай үйл явдал байсан” хэмээн ахлагч Рэнланд ямар ч эргэлзээгүй хэлсэн билээ. Тэдний охин Ашлий 1980 онд буюу ахлагч Рэнландийг Анагаахын сургуулиа төгссөнөөс нэг долоо хоногийн дараа төржээ.

Ахлагч Рэнланд хамгийн эхний сонголт болох Жон Хопкинсийн эмнэлэгт дадлага

хийх ажилд тэнцэн, анагаахын боловсролоо үргэлжлүүлэх боломжтой болсондоо баяртай байв. Тэд гэр бүлээрээ Мэриландын Балтимор руу нүүсэн бөгөөд тэрээр тэндээ эмнэлэгт ажиллах болсон юм.

Сорилтууд дунд өсөж хөгжсөн нь

1981 онд Рэнланд эгч өндгөвчний хорт хавдартай гэж оношлогджээ. Тэр хоёр ч удаа мэс засал хийлгэж мөн есөн сарын турш химийн эмчилгээнд орсон байлаа. Рутыг төдийгүй охиноо халамжлан асрах гэж зүдэрч байсан үеийнхээ тухай ахлагч Рэнланд “Миний сэтгэл өвдөн шаналж байсан бөгөөд залбирал маань тэнгэрт хүрэхгүй байгаа мэт санагдаж байлаа” хэмээн дурссан юм.

Тэрээр Рутыг эмнэлгээс гэртээ авчрахад бие нь маш сул байсан ч тэд хамтдаа залбирахыг хүссэн байна. Тэр Рэнланд эгчээс залбирахыг хүсэв. “Түүний хэлсэн хамгийн эхний зүйл бол “Тэнгэрлэг Эцэг минь амьдралд юу ч тохиолдсон гэсэн мөнхөд хамтдаа байх боломжийг олгодог санваарын хүчинд баярлалаа” хэмээх талархлын үг байлаа.”

Тэр мөчид тэрээр эхнэртээ мөн Бурханд улам нягт ойртсон гэдгээ мэдэрсэн байна. “Би мөнхийн гэр бүлийн талаар ойлгосон зүйлээ одоо зүрх сэтгэлээрээ ойлгодог болсон” хэмээн ахлагч Рэнланд хэлсэн юм. “Рутын өвчин амьдралын маань зүг чигийг өөрчилсөн билээ.”

Өвчнөө бодохгүйн тулд Рэнланд эгч хуулийн сургуульд сурахаар шийджээ. “Бид энэ бүхний үр дүнд ямар нэгэн сайн зүйл гаргахгүй бол зүгээр л нэг муу туршлага болно шүү дээ” гэсэн бодол надад төрж байлаа. Намайг залуудаа хорт хавдар тусаж, ганцхан хүүхэдтэй болно гэж бид төлөвлөөгүй. Мөн миний амьд үлдэх эсэх нь ч эргэлзээтэй байв. Хэдий тийм ч бидэнд хуулийн сургуульд явах нь зөв гэсэн мэдрэмж төрсөн юм” хэмээн Рэнланд эгч хэлсэн юм.

Тэрээр эмчилгээ хийлгэж мөн нөхөр нь дадлагын ажлаа үргэлжлүүлэн хийж байсан ч суралцахаар болжээ.

Балтимор хотын төв хэсгийн бишоп

Ахлагч Рэнландийг гурван жил эмнэлгийн ажилтан байж байгаад зүрх судасны туслах эмч болох үед тэрээр Балтимор тойргийн бишпоор дуудагдах ярилцлагад орсон байна. Тухайн үед Мэриландийн



Балтимор гадасны нэгдүгээр зөвлөх байсан Брент Пэтти уг ярилцлагыг дурсан санадаг. Түүнийг гадасны ерөнхийлөгч Стэфэн П.Шиддийтэй ярилцах үед хоёулаанд нь “Ариун Сүнсний маш хүчтэй мэдрэмж” мэдрэгдсэн байна.

Пэтти ах “тэрээр ажил мэргэжлийн хувьд мөн гэр бүлийн хувьд асуудалтай байсан ч өөрийгөө гайхалтай сайн бишоп болохоо харуулсан” хэмээн дурсжээ.

Ахлагч Рэнландийг өнгөрсөн жил Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад дуудагдахад Балтимор тойргийн гишүүд болон ахлагч Рэнландтай эмнэлэгт хамт ажиллаж байсан хүмүүсийн ихэнх нь хожмын үеийн гэгээнтэн биш байсан ч үнэхээр их баярласан гэдгийг Пэтти ах онцлон тэмдэглэсэн билээ. Тэд түүнийг хайрладаг гэдгээ мөн түүний үйлчлэл, ёс суртахуунт онцгой зан чанарыг хэрхэн байдан биширдэг болохоо илэрхийлж байлаа.

Ажил мэргэжлийн амжилт ололт

1986 онд Рэнланд эгч Мэриландийн Их Сургуулийн хуулийн сургуулийг төгсөж, харин ахлагч Рэнланд гурван жилийн дотрын эмчийн дадлага, гурван жилийн зүрх судасны туслах эмчийн хөтөлбөрөө дуусган, Ютад эргэн иржээ. Рэнланд эгч Юта мужийн ерөнхий прокурорын газар хуульчаар, харин ахлагч Рэнланд Ютагийн Их Сургуулийн анагаахын багшаар ажилласан байна. Тэрээр 18 жилийн турш Юта мужийн эрхтэн шилжүүлэн



Ахлагч Рэнланд зүрх судасны эмчийн ажлынхаа оргил үед ерөнхий эрх мэдэлтнээр үйлчлэх дуудлага хүлээн авч, эхлээд Африкийн зүүн өмнөд бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд томилогдон ажиллаж байв. Эсрэг талын хуудсанд: Ахлагч Рэнландийг ерөнхийлөгч Монсоны ажлын ерөөнд байхад Хэнрик Хофманн зурсан Аврагчийн зураг түүний нүдэнд туссан бөгөөд тэрээр дараа нь уг зургийг ажлынхаа ерөөнд өлгөхөөр сонгосон байна.

суулгах эрх бүхий эмнэлгүүдийн зүрх шилжүүлэн суулгах хөтөлбөрийн удирдагчаар ажилласан билээ.

2000 онд тэр Солт Лэйк хотын Интэрмоунтан эрүүл мэндийн төвийн Зүрх судасны эмгэг ба эмчилгээний хөтөлбөрийн удирдагч болсон. Уг хөтөлбөрт шилжүүлэн суулгах боломжтой зүрхний шахуурга ба бүтэн хиймэл зүрх багтдаг байв. Олон улсад танигдсан зүрхний мэс засалч, анагаах ухааны доктор Доналд Б.Доти бол Рэнланд эмчийн найз бөгөөд ХҮГ эмнэлэгт хамт ажилладаг байжээ. Доти эмч “Тэрээр гайхалтай боловсролтой төдийгүй түүний гүн гүнзгий төвлөрч, удирдан зохион байгуулж, бусдыг өрөвдөн хайрлах чадвар хосгүй билээ” гэж хэлсэн.

Олон жилийн турш Рэнланд эмчтэй хамт ажилласан итгэлтэй католик шашинтан А.Г.Кфоури эмч түүнийг бүс нутгийнхаа урдаа барих зүрх шилжүүлэн суулгах мэргэжилтэн бөгөөд “түүний хүн чанар, чин шударга, даруу төлөв зан, өрөвдөх сэтгэлтэй эн тэнцэх хүн байхгүй” хэмээн тодорхойлжээ. Тэрээр “Рэнланд эмч бол бусдын хамгийн сайхан зан чанарыг гаргаж ирдэг бөгөөд энэ бүхнийг бусдын анхаарлыг таталгүй хийдэг байсан.

Тэр бусдыг сайн сонсож, тэдэнд санаа тавьдаг байсан бөгөөд хамтран ажиллагсдаа амжилтад хүргэхийн төлөө ихэд анхаарал тавин сонирхдог байсан” хэмээн хэлсэн билээ. Рэнланд эмч өөрийн үлгэр жишээгээр бусдыг чимээгүйхэн удирддаг байсан бөгөөд хамт ажилладаг хүмүүсийнхээ гэр бүлд үргэлж анхаарал халамж тавьдаг байв.


Рэнланд эмч өвчтөнүүдээ хэрхэн өрөвдөн хайрладаг байсныг Кфоури эмч онцлон тэмдэглэсэн байдаг. Жишээлбэл, өвчтөнд унаа байхгүй бол Рэнланд эмч хол зайг туулан өвчтөний гэрт очиж, түүнийг машиндаа өргөн суулгаж, эмнэлэг рүү авчирдаг байсан байна. Энэ нь хүн бүрийн хийгээд байдаг зүйл биш хэмээн Кфоури эмч хэлжээ.

Далын чуулгад үйлчилсэн нь

Ахлагч Рэнланд Солт Лэйкийн Их Сургуулийн нэгдүгээр гадасны ерөнхийлөгчөөр таван жил үйлчилснийхээ дараа 2000 онд Юта бүс нутгийн Бүсийн далд үйлчлэхээр дуудагдсан билээ. Дараа нь 2009 оны 4-р сард тэр Далын ерөнхий эрх мэдэлтнээр дуудагдсан юм. Түүний анхны дуудлагат ажил нь Сүмийн нэгж бүхий 25 өөр улс оронд Африкийн зүүн өмнөд бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчлэх ажил байв.

Рэнланд эгч энэ дуудлагад хэрхэн хариулсан тухайгаа: “Мэдээж гайхсан л даа. Хүмүүс ч гэсэн ‘Танар ажил мэргэжлийнхээ хамгийн оргил үед нь орхиод явж байна шүү дээ’ гэж хэлж л байсан. Энэ нь хэдийгээр үнэн байсан ч Их Эзэн биднээс ажлаа орхихыг хүсэж байгаа бол яг тэр үед бидний үйлчлэл хэрэгтэй байгаа л бол явах цаг нь болсон гэсэн үг” хэмээн хуваалцжээ.

Ахлагч Рэнланд эхнэрээ баатар хэмээн ярихдаа “Тэр минь агуу их золилол гаргасан” гэж хэлжээ. Рэнланд эгч түүнтэй хамт үйлчлэхийн тулд хуулийн





Онцгой гэрч болохоор дуудагдсан нь

2015 оны 9-р сарын 29-нд тэр Тэргүүн Зөвлөлийн албанаас гэнэтийн дуудлага хүлээн авчээ. Сүмийн удирдах албаны байранд “Намайг ерөнхийлөгч Томас С.Монсон болон түүний хоёр зөвлөх халуун дулаанаар хүлээн авсан. Биднийг

компанийн захирлын ажлаас гадна хэд хэдэн нэр хүндтэй хуулийн зөвлөлд хашиж байсан албаа орхисон. Ахлагч Рэнланд “Бид Африкт ирээд, гэгээнтнүүдээс юу чухал болохыг мэдэж авсан” гэж хэлсэн юм.

Нэгэн ням гарагт тэрээр Конго улсын төв хэсэгт орших гишүүдээс ямар саад бэрхшээл тулгарч байгаа талаар асуухад тэд ямар ч саад бэрхшээлийг бодоод бодоод олоогүй аж. Тэр дахин асуусан байна. Эцэст нь ерөөний арын суудалд сууж байсан нэгэн хижээл насны эр босоод, “Ахлагч Рэнланд аа, бидэнд ямар саад бэрхшээл байж болох вэ дээ? Бидэнд Есүс Христийн сайн мэдээ байгаа шүү дээ” гэж хэлжээ. Ахлагч Рэнланд энэ үйл явдлын тухай эргэцүүлэн бодохдоо “Би өдөр бүр идэх хоолны төлөө залбирдаг, өдөр бүр идэх хоолтой, гэр бүлтэй байгаадаа талархдаг Конго улсын гэгээнтнүүдийн адил болохыг хүсэж байна. Тэдэнд юу ч байхгүй ч гэсэн, тэдэнд бүх зүйл байсан юм” хэмээн тайлбарласан байдаг.

Ахлагч Рэнланд Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд таван жил ажиллахдаа Африкийн зүүн өмнөд хэсгийн өргөн уудам нутгаар хэдэн мянган удаа аялсан билээ. Уг бүс нутгийн хэд хэдэн улс орон францаар ярьдаг тул тэр франц хэл сурсан байна.

Тухайн үед Африкийн Зүүн өмнөд бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлтэй ажиллах үүрэгт ажил хүлээн авч байсан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн ахлагч Жэффри Р.Холланд “Уг бус нутагт болон хүмүүст мөн тэдний хэрэгцээг хангахын тулд ахлагч Рэнландаас илүү өөрийгөө зориулсан хүн байхгүй” гэж хэлжээ. Тэрээр хүмүүсийг таньж мэдэн, ёс заншлыг нь хайрлан хүндэлж, гэгээнтнүүдийг гэтэлгэгч гэрэл рүү очиход нь туслахын тулд асар их хөдөлмөрлөсөн билээ.

суусны дараа ерөнхийлөгч Монсон над руу хараад, ‘Рэнланд ах аа, бид танд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр үйлчлэх дуудлагыг өгч байна’ хэмээн хэлэв.”

Ахлагч Рэнланд гайхсан байна. Тэрээр дуудлагыг даруухнаар хүлээн авсан ба “Ерөнхийлөгч Монсон миний сандарч байгааг мэдэрсэн бололтой над руу хараад, ‘Бурхан таныг дуудсан бөгөөд Их Эзэн надад үүнийг мэдүүлсэн” хэмээн хэлсэн юм.


Ахлагч Рэнланд ажлынхаа өрөөнд эргэн ирж, хаалгаа хаагаад, өвдөг сөгдөн залбирчээ. Сайтар бодсоны эцэст тэрээр эхнэр рүүгээ утасджээ. “Тэр гайхсан хэдий ч Их Эзэнд, Түүний Сүмд болон надад үнэнч болохоо харуулсан юм” хэмээн тэр хэлэв.

Охин Ашлий нь “Аав маань тэнгэрийн адислалыг хүртсэн учраас амжилтад хүрч, бүхэл насаараа дуудлагад үйлчилснээр үүнд бэлтгэгдсэн билээ. Тэр сайхан сэтгэлтэй, хайраар дүүрэн хүн” хэмээн нотлон хэлсэн байна.

Үүнтэй адил ахлагч Рэнландийн ах Гари түүний талаар “тэрээр өөрт тохиолдсон саад бэрхшээлээр болон үйлчлэлээр дамжуулан эртнээс бэлтгэгдсэн юм. Энэ нь үүнээс ч том төлөвлөгөөний нэгээхэн хэсэг бөгөөд түүнийг дэмжин батлах шиг амархан зүйл надад байхгүй” гэж хэлжээ.

Ахлагч Рэнланд хүлээн авсан дуудлага нь ямар нүсэр том болохыг тунгаан бодож хэлэхдээ: “Би өөрийгөө Есүс Христ дэлхийн Аврагч гэдгийг мэдэхээс өөр бусад шалгуурт нийцэхгүй гэж бодож байна. Би Түүнийг амьд гэдгийг, Тэр миний болон та нарын Аврагч гэдгийг гэрчилж чадна. Мөн энэ бүхэн үнэн гэдгийг би мэднэ” гэсэн юм. ■

ЭНЭТХЭГИЙН Ө АНХДАГЧ
МИНИЙ ТУУЛСАН
АЯН ЗАМ



*Би Энэтхэгийн хөдөөний
“ширэнгэн ойн хүү”
байсан үеэс эхлээд
өнөөдрийг хүртэлх аян
замаа эргэн хараад,
амьдрал, итгэл маань
үнэн хэрэгтээ гайхамшиг
байсныг олж хардаг.*



**Мангал Дан Диптигийн
Жон Сантош Муралд
ярьсан түүх**

Би Энэтхэгийн Зүүн Гатын уул нуруудаар хүрээлүүлсэн жижигхэн ширэнгэн ойн тосгонд төрсөн. Намайг 18 сартай байхад гэрийнхэн маань Колаб голын эрэг дээр байрладаг Данграпалли тосгон руу нүүсэн билээ. Эцэг эх минь намайг сагсанд хийж үүрээд, явган явсан гэдэг. Тэр тосгон цахилгаангүй, жижиг урцанд амьдардаг 20–25 гэр бүлээс бүрддэг байсан юм. Сургууль, эмнэлэг, автобусны буудал ч байдаггүй байв. Бид голын голдрилыг ухаж, ундныхаа усыг гаргаж авдаг байлаа. Би хүүхэд насаа ширэнгэн ойд болон талбайд тоглон, намган дээгүүр модон хөлөөр явж, голд сэлэн өнгөрүүлсэн.

Өвөг дээдэс минь Жагдалпурын Бастарын Мажахарагийн (Хааны) удирдлага дор ажилладаг байсан Хиндү сүмийн прист байсан юм. Улс төрийн тогтворгүй байдал улам хурцдах үед өвөө гэр бүлийнхээ хамт Котпад руу дүрвэсэн байлаа. Германы Лютеран номлол тэндэнд толгой хоргодох байр гаргаж өгөхөд өвөө тэнд асрагчаар ажиллахын зэрэгцээ Аюурвэда (ургамлын гаралтай эм) эмчилгээний аргачлалыг хэрэглэдэг байв. Өвөө тэнд байхдаа Христийн шашинтан болох сонголт хийсэн юм.

Аав евангелийн санваартан болон гүрү (багш) болох сонголт хийснээрээ Христийн шашин шүтлэгийг үргэлжлүүлэн авч үлдсэн билээ. Намайг төрөхөд тэр надад Христийн шашны уламжлалаа өвлүүлэн, Мангал Дан Дипти (“сайн сайхан,” “бэлэг” болон “гэрэл” гэсэн утгатай) гэсэн нэр өгсөн юм.

Би хүүхэд байхдаа Германы Лютеран сүмд байнга явдаг байв. Бид хамтдаа залбирахаар уул руу үргэлж явдаг байлаа. Нэгэн бороотой өдөр залбирч байсан бүх хүнийг шалбаа норход номлогчдын нэг нь бороог зогсоож өгөхийг Их Эзэнээс гуйж, чин сэтгэлээсээ залбирч билээ. Гайхалтай нь бороо тэр даруй зогсов. Энэ явдал миний Бурханд болон залбиралд итгэх итгэлийн эхлэлийг тавьсан юм.

Мормоны шашныхан Христэд итгэгчид мөн үү?

Би наймдугаар ангиа төгссөнийхөө дараа Котпадад гурван жилийн шашны семинарт хамрагдахын тулд

сургуулиа орхиж, завьныхаа нэгэн адил евангелистэд томилогдов. Котпад орчимд хэдэн жил цуглаан удирдан зохион байгуулсныхаа дараа хойд Энэтхэг рүү нүүж, тэндээ Евангелист Христийн шашны уран зохиолын нийгэмлэгийн номуудыг зарж эхэлсэн юм. Тэгэхэд *Мормоны шашныхан Христэд итгэгчид мөн үү?* гэсэн нэртэй нэгэн номыг олж харав. Энэ ном миний сонирхлыг татаж, би уншиж үзэхээр шийдлээ.

Уг номон дээр мормончуудын тухай мөн тэдний итгэл үнэмшлийн талаар олон шүүмжлэл бичсэн байв. Гэсэн хэдий ч номон доторх олон хэсэг, ялангуяа Бурхан Тэргүүтэний талаарх тэдний ойлголт, зан үйл болон олон эхнэртэй байх ёсын талаар өгүүлсэн түүх миний сонирхлыг ихэд татаж байлаа. Гэхдээ миний сонирхлыг хамгийн их татсан зүйл нь тэдний Сүм Есүс Христийн нэрээр нэрлэгдсэн явдал байв. Надад илүү ихийг мэдэж авах сонирхол төрсөн юм.

Нэгэн өдөр би залбирч байхдаа Мормоны Сүмийг судлах хэрэгтэй гэж сүнслэгээр мэдэрсэн билээ. Би тус Сүмийн удирдах газар Ютагийн Солт Лэйк хотод байдгийг олж мэдэн, захидал бичихээр шийдэж, захидлаа “АНУ-ын Юта мужийн Солт Лэйк хот дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг хариуцсан удирдагчид” хэмээн хаяглав.

Төлөөлөгчөөс суралцсан нь

1959 онд захидлын хариу болгон, Сүмийн Номлогчийн Албаны Ламар Уиллиамс ах над руу Иосеф Смитийн гэрчлэл, Итгэлийн тунхаг, Мормоны Ном зэргийг илгээсэн юм. Би бүгдийг нь судалсан бөгөөд үнэн гэдэгт бүрэн итгэсэн. Харин тухайн үед Энэтхэгт надад заах номлогч болон гишүүд байсангүй.

Хожим нь 1961 оны 1-р сард Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) Делид айлчлан ирэв. Би гурав хоногийн турш түүнтэй хамт Агра дахь Таж Махал болон Дарамсала руу аялсан юм. Би түүний заасан сайн мэдээний бүх хичээлийг ус шингээдэг цаас шиг л хүлээн авав. Түүний айлчлалын сүүлийн өдөр би баптисм хүртэхэд бэлэн болсон байлаа. 1961 оны 1-р сарын 7-нд хэдийгээр тэнд олон хүн гайхан харж байсан ч ахлагч Кимбалл надад Ямуна голд баптисм хүртэж, Кимбалл эгч албан ёсны гэрч болов. Би тэр орой Сүмийн гишүүнээр батлагдсан юм.

Их Эзэний төлөөлөгч надад тасралтгүй зааж сургасан тэр гурван өдөр амьдралын минь хамгийн сайхан өдрүүд байж билээ. Тэр миний онцгой мормон найз болсон учраас түүнтэй салах ёс гүйцэтгэхэд гунигтай байлаа.

Гэгээнтнүүдтэй хамт байхыг хүссэн нь

Ахлагч Кимбаллыг явсны дараа найз нөхөдтэйгөө хэрхэн хөрвөгдсөнөө хуваалцахад тэд намайг шоолдог байлаа. Харин би сайн мэдээ үнэн гэдгийг мэдэж байсан бөгөөд үүнийг үгүйсгэж чадахгүй учраас өөр ажилд анхаарлаа төвлөрүүлэхээр шийдсэн юм. Би аавынхаа эрхэлдэг байсан хувцасны бизнесийг эхлүүлэв. Яваандаа би илүү сайн боловсрол эзэмшихгүй бол цаашид өсөж хөгжиж чадахгүй гэдгээ ухаарч билээ. Хорь гарсан хойноо сургуульд эргэж сурах нь амаргүй байсан ч би амьдралынхаа дараагийн есөн жилийг боловсролтой болоход зарцуулсан. Өглөөгүүр бизнесээ эрхлэн, оройгоор суралцаж, олсон бүх мөнгөө боловсролдоо зарцуулдаг байлаа. Би эрс шийдэмгий байж, тэнгэрлэг тусламжийг хүлээн авахын тулд залбирдаг байв. Аграгийн Их Сургуульд сэтгэл зүй, нийгэм, урлаг судлалаар бакалаврын зэрэг хамгаалсан. Эцэст нь би хуулийн мэргэжлээр суралцахаар Мийрутын Их Сургуульд элсэн орсон билээ.

Энэхүү есөн жилийн эхэн үед Делид хожмын үеийн гэгээнтэн ганцхан гэр бүл байдаг байсан бөгөөд тэд АНУ-ын элчин сайдын яаманд ажилладаг Шортлэфтсийнхэн байв. Би тэднийд очиж, ариун ёслол хүртэхээр Дели рүү явдаг байлаа. 1962 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Л.Эванс (1906–1971), харин 1964 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Гордон Б.Хинкли (1910–2008) бидэн дээр айлчлан ирсэн юм. Би ахлагч Хинклигийн хүзүүнд цэцгэн хэлхээ зүүж өгөн, олон жилийн турш хуримтлуулж, хадгалсан аравны нэгийнхээ өргөлийг гардуулан өгч байснаа санаж байна.

Харамсалтай нь, найзалж нөхөрлөсөн энэхүү мөч надад тус болдог байсан ч байнгын биш байсан учраас би Энэтхэгт байх хугацаандаа бусад гэгээнтэнтэй нөхөрлөх боломжгүй хол байдаг байв. Энэ байдал миний сэтгэлийг ихэд зовоодог байлаа. Он жилүүд урсан өнгөрөхийн хэрээр би ганцаардсаар байсан бөгөөд Энэтхэгт ирээдүйгээ огтхон ч олж харахгүй байсан юм. Би санваар хүлээн авч, гэгээнтнүүдийн дунд амьдрахыг хүсэж байлаа.

Анхдагч болсон нь

Би гэгээнтнүүдтэй илүү ойртох цаг болсон гэж үзээд, хуулийн сургуулиа орхин, Канад руу цагаачлав. Би Албертагийн Эдмонтонд буусныхаа дараа хамгийн ойр байрлах тойрогт очив. Бишоп Харри Смиттэй уулзаад, тэр тойрогт байх ёстой гэдгээ тэр даруй мэдэрсэн юм. Хувийн хишгээ хүртэх арай болоогүй байсан ч би Кардстон Албертагийн ариун сүмд очиж билээ.

Мөн Солт Лэйк хотод очиж, сайн найз болох ахлагч Кимбалл, Ламар Уиллиамс ах нарт гэнэтийн бэлэг барихыг хүсэж байв. Эцэст





Дээд талд: Дипти ах Энэтхэгт оюутан байхдаа. Доод талд: Дипти ах (зүүн гар талд) Энэтхэгийн Сүмийн өөр нэгэн анхдагч гишүүн Паул Тритувадасстай хамт Солт Лэйк хотын Ариун сүмийн талбайд. Зүүн гар талд: Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл Дипти ахын анхдагчийн аян замд чухал үүрэг гүйцэтгэсэн.



нь би 1969 оны хавар буюу баптисм хүртсэнээсээ хойш найман жилийн дараа Солт Лэйк хотод очиж, ахлагч Кимбаллтай уулзсан юм. Тэр намайг баярлан угтаж, өдрийн үлдсэн цагийг надтай хамт өнгөрүүлж билээ.

Би Солт Лэйк хотод байхдаа үсчинд оров. Тэнд би гэрчлэлээ Сүмд хөрвөгдсөн нэг үсчинтэй хуваалцсан юм. Ээлжээ хүлээж байсан нэгэн эрхэм миний яриаг санаандгүй сонсож, Энэтхэг рүү аялсан тухайгаа яриу. Тэр миний үсээ засуулсан төлбөрийг төлөн, намайг оройн хоолонд урьж, машинаараа Бригам Янгийн Их Сургууль руу авч явсан юм. Оюутны хотхоныг хараад миний сэтгэл ихэд хөдлөв. Би энд үргэлжлүүлэн сурахыг хүсэж байгаа ч төлбөрөө төлж чадахгүй гэдгээ хэлэхэд, тэр миний сургалтын төлбөрт 1000 доллар төлөхийг санал болгосон. Би гайхахын зэрэгцээ үнэхээр их талархаж билээ.

Би БЯИС-ийн олон нийтийн ажлын хөтөлбөрт хамрагдаж, 1972 онд БЯИС-ийг төгссөнийхөө дараа Ютагийн Их Сургуульд магистрын зэрэг хамгаалахаар Солт Лэйк хот руу шилжин суурьшив. Дараа нь, би АНУ-ын Калифорни муж руу нүүж, тэндээ сэтгэл зүйн эмгэг судлалаар докторын зэрэг хамгаалан, гэр бүлийн хүчирхийллийг хэрхэн зогсоох талаар хичээл зааж, нэг ном бичиж хэвлүүлсэн.

Одоо би тэтгэвэрт гарч, АНУ-ын Невада мужид эхнэр Вэндитэйгээ хамт амьдарч байна.

Надад хувийн зөрчил, сорилт бэрхшээл, зовлон зүдгүүрийг туулж байсан үе байсан. Сайн мэдээ, ариун сүмийн адислалуудад анхаарлаа төвлөрүүлсэн нь надад амьдралын олон сорилт бэрхшээлийг даван гарахад тусалж байсан юм.

Түүний төлөвлөгөө гайхалтай

Би Энэтхэгийн хөдөөний “ширэнгэн ойн хүү” байсан үеэс

эхлээд өнөөдрийг хүртэлх өөрийн туулсан аян замыг байнга дурсан санадаг бөгөөд амьдрал, итгэл маань үнэн хэрэгтээ гайхамшиг байсан гэдгийг олж хардаг. Амьдралд минь зориулан хатгасан Их Эзэний хатгамал миний төсөөлж байснаас ч илүү үзэсгэлэнтэй сайхан байсан билээ. Их Эзэний тослогдсон бошиглогч Спэнсэр В.Кимбаллаар заалган, амьдралынхаа аян замын чухал цаг мөчүүдэд түүнтэй хамт байх боломжтой байсан маань хэчнээн гайхамшигтай байсан гээч.

Би ерөнхийлөгч Кимбаллтай хамт өнгөрүүлсэн цаг хормоо үргэлж дурсан санадаг. Тэр гэр бүлийн аялал, зугаалга, Талархлын болон Христийн мэндэлсний баярын оройн зоогондоо намайг урьдаг байсан. Тэр үед ч гэсэн түүнийг үнэхээр Их Эзэн Есүс Христийн төлөөлөгч, бошиглогч байсан гэдгийг би мэддэг байсан.

Ерөнхийлөгч Кимбаллын биеийг маш муу байх үед түүнтэй сүүлчийн удаа уулзахад ч гэсэн тэр над руу инээмсэглэн, намайг тэвэрсэн билээ. Тэр миний холбоо барьсан хамгийн анхны ХҮГ байсан бөгөөд хэзээ ч намайг орхихгүй гэдгийг нь би мэддэг байсан юм.

Би бошиглогчдыг өгсөнд мөн сэргээгдсэн сайн мэдээг өгсөнд Бурхандаа талархаж явдаг. Манай Сүм өнөө үед дэлхийд хэрэгтэй байгаа тэрхүү тэнгэрлэг загвар мөн. Сүмийн ачаар би боловсролтой болж, хувь хүнийхээ хувьд өсөж хөгжсөн. Би тэр өдөр залбирал бодитой гэдгийг мэдэж авсандаа мөн намуухан, зөөлөн дуу хоолойг сонсож, Сүмийг судлах хүсэлтэй байсандаа талархаж явдаг. Их Эзэнд өөрийн амьдралыг төлөвлөх боломж олгосондоо би талархдаг. Хэрэв бид Түүний хаант улсыг эрэлхийлбэл бүх зүйл бидэнд нэмэгдэн өгөгдөнө гэдгийг би мэднэ (Матай 6:33-ыг үзнэ үү). ■

Зохиогч нь Энэтхэгийн Тэланганад амьдардаг.



ЗАРЕФАТЫН БЭЛЭВСЭН
ЭМЭГТЭЙН АДИЛ:

Мацгийн өргөлийн гайхамшиг

*Бид мацгийн өргөлөө илүү өгөөмөр
өгөх тухай бодож байхдаа хүн Их
Эзэнээс бүтэн талх авалгүйгээр
зүсэм ч талх эргүүлэн өгч чадахгүй
юм байна гэдгийг ойлгосон.*

По Ниэн (Филиппин) Чоу, Петра Чоу нар

Дэлхий даяар олон гэр бүл, ялангуяа эдийн засгийн хямралын үед санхүүгийн хүнд байдалд ороод байгаа билээ.¹ Хэдэн жилийн өмнө бид орон нутгийнхаа тойргийн хэдэн гэр бүлд тусламж хэрэгтэй байгааг олж харахдаа ийм хямралын нөлөөг мэдэрсэн юм. Тэр жилийн эхээр бишоп гачигдагсад туслахын тулд мацгийн өргөлөө өгөөмрөөр өгнө үү гэсэн гадасны ерөнхийлөгчийн урилгыг бидэнтэй хуваалцаж билээ.

Хэдийгээр удирдагчид өөрсдийн нөхцөл байдлыг харж, мацгийн өргөлөө илүү өгөөмрөөр өгөх боломжтой эсэхээ бодож үзэхийг хүссэн ч хэр ихийг өгөх хэрэгтэй гэдгийг тодорхой хэлсэнгүй. Гэхдээ Сүнс Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Марион Ж.Ромнигийн (1897–1988) олон жилийн өмнө хуваалцаж байсан зөвлөгөөг бидэнд сануулсан билээ. Тэрээр “Та нар Сүмд болон Бурханы хаант улсыг барьж байгуулахад өргөл өгснөөрөө санхүүгийн хувьд одоо байгаагаасаа дордохгүй гэдэгт би баттай итгэдэг нэгэн. . . . Хүн Их Эзэнээс бүтэн талх авалгүйгээр зүсэм ч талхыг эргүүлэн өгч чадахгүй. Энэ бол миний амьдралын туршлага юм. Хэрэв Сүмийн гишүүд мацгийн өргөлийн хандиваа хоёр дахин нэмэгдүүлэх юм бол Сүм дэх сүнслэг байдал нь хоёр дахин өсөх болно. Бид үүнийг оюун санаандаа марталгүй хадгалан, хандивлахдаа өгөөмөр байх ёстой”² хэмээн хэлжээ.

Мацгийн өргөлөө нэмэгдүүлэх нь гэр бүлийн хувьд золиослол гэдгийг бид мэдэж байсан ч ерөнхийлөгч Ромнигийн сургаал, амлалтыг анхааралтай авч үзсэн юм. Бид гэр бүлээрээ асар их адислагдсан бөгөөд мацгийн өргөлөө нэмэгдүүлэх хүсэлтэй байгаагаа хүчтэй мэдэрсэн билээ.

Түүнээс гадна бид гэр бүлээрээ хувиа хичээх хандлагаа ялан дийлэхийг хүсэж байв. Бид аливаа зүйлийг олж авах, хүслээ гүйцэлдүүлэхэд төвлөрсөн нийгэмд амьдарч байгаа учраас хүүхдүүд минь хувиа хичээсэн хүмүүс болж өсөх вий гэж санаа зовж байлаа. Гэхдээ бид ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын (1895–1985) “Мацгийн хуулийг дагаснаар хүн өөрийгөө өөгшүүлэх, аминч үзлээ ялан дийлэх хүч чадлынхаа ундаргыг олж авдаг”³ хэмээн хэлсэн үгэнд итгэж байв.

Мацгийн өргөлөө илүү өгөөмрөөр өгч эхэлсэн эхний гурван сард бид олон адислалыг олж харсан. Бид хүнсэндээ бага мөнгө зарцуулж мөн манай хийн түлшний сав илүү удаан хэрэглэгдэж байх шиг санагдаж байв. Хүүхдүүдийн хэрэгцээ багасаж, гэр оронд хувиа хичээсэн байдал бараг алга болсон байлаа.

Жишээлбэл, бид орон нутгийнхаа хүнс хандивлах үйл ажиллагаанд оролцох үед хүүхдүүд илүү их өгөхөд биднийг урамшуулж байв. Бид жилийн хүнсний нөөцийнхөө тооллогыг хийгээд, үнэндээ хоёр жилийн хоол хүнсний нөөцтэй болсноо мэдсэн. Үүнээс гадна, өмнө нь бид сард 22.7 кг жинтэй нэг уут будаа хэрэглэдэг байв. Одоо яг ийм хэмжээтэй будааг 2 сарын турш хэрэглэдэг болсон. Манай хүнсний нөөц өсөн үржиж байгаа мэт санагдаж байлаа.

Энэ нь бидэнд Зарефатын бэлэвсэн эмэгтэйн түүхийг санагдуулсан юм. Өлсгөлөнгийн үеэр бошиглогч Елиа өөрийг нь хооллох боломжгүй нэгэн бэлэвсэн эмэгтэйдгээс ус, талх авчрахыг хүсдэг. Харин тэр эмэгтэй хариуд нь, “Таны Бурхан Эзэний амьд буйгаар тангараглая. Надад талх байхгүй. Зөвхөн миний хул аяганд минь атгын төдий гурил, вааранд минь жаахан тос үлдсэн. Харатгун, би гэртээ харьж, өөртөө болон хүүдээ зориулан хоол хийхийн тулд одоо түлээ түүж байна. Дараа нь бид үхэх байх даа гэв” (1 Хаадын Дээд 17:12).

Бошиглогч түүнд “аяган дахь гурил ч дуусахгүй, тостой ваар ч хоосрохгүй хэмээн амласан байдаг. . . .

Тэр эмэгтэй яван, Елиагийн үгээр үйлдсэн бөгөөд тэр эмэгтэй, Елиа болон эмэгтэйн гэрийнхэн олон өдрийн туршид хоол ундтай байв” (1 Хаадын Дээд 17:14–15). Гэр бүлээ сүүлчийн удаа хооллоход л хүрэх хул аяган

дахь гурил нь өсөж үржин, түүний гэр бүлийг болон бусдыг олон өдрийн турш хооллох боломжтой болсон юм. Мацгийн өргөл дээр үндэслэсэн үүнтэй адил гайхамшиг манай гэр бүлд ч бас тохиолдож байлаа.

Санхүүгийн хүнд нөхцөлд байхад ялангуяа Зарефатын бэлэвсэн эмэгтэйн адил гачигдагсдад мацгийн өргөлөө өгөөмрөөр өгч, тусламж үзүүлэх нь хэцүү байж болно. Хэмжээнээс үл хамааран мацгийн өргөлөө өгөөмрөөр өгөх нь Их Эзэнд болон Түүний анхаарал тавин халамжилна гэсэн амлалтад итгэхийг шаарддаг. Гэхдээ Их Эзэн амлалтаа биелүүлдэг бөгөөд бид хэчнээн их хуваалцах хүсэлтэй байна, төчнөөн их адислагдах болно гэдгийг гэр бүлийн минь туршлага зааж өгсөн билээ.

Ерөнхийлөгч Ромни: “Зөвхөн ядуусын тусын тулд өгөх бус, харин өөрийн сайн сайхны төлөө өг. Өөрийн биеийг Бурханы хаант улсад өгөхийн тулд эд баялаг, цаг заваа хангалттай өргөл болгон барь”⁴ хэмээн хэлсэн. Мацгийн өргөлөө өгөөмрөөр өгсөн нь манай гэр бүлд ядуусыг халамжилснаар ирэх баяр баяслыг мөн өөрсдийн сүнслэг байдалд хүч чадлыг олж авахад тусалсан юм.

Бид зүсэм талх өгөх хүслийнхээ хариуд олон бүтэн талх авсан билээ. Мацгийн өргөлөө илүү өгөөмөр өгөх хүсэл маань бидний хүнсний нөөцийг хоёр дахин өсгөн нэмэгдүүлсэн. Үнэхээр Их Эзэний таван талх, хоёр загасыг авч, эмэгтэйчүүд, хүүхдүүдээс гадна таван мянга орчим эрчүүдийг хооллон, 12 сагсыг дүүргэсэн тэрхүү өсгөн үржүүлэх хүч нь (Матай 14:16–21-ийг үзнэ үү) үнэн хэрэгтээ, Зарефатын бэлэвсэн эмэгтэйн хул аягыг дүүргэж, бидний хүнсний нөөцийг үржүүлэн нэмэгдүүлсэн хүч мөн билээ. Гэхдээ бидний олж авсан хамгаас агуу ашиг тус хоол хүнсийг үржүүлэн өсгөснөөр ирээгүй, харин гэр бүл доторх аминч үзлийг багасгаж, сүнслэг байдлыг нэмэгдүүлснээр ирсэн.

Сүмийн мацгийн санд хэцүү байгаа үедээ ч өгөөмрөөр хандивлавал Их Эзэн бидний хичээл зүтгэлийг үнэлж, өөрсдийн маань төсөөлж чадахаас ч илүү ихээр адислах болно гэдгийг бид гэрчилж байна. ■

Зохиогчид нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Жишээ нь, Хэнри Б.Айринг, “Үүний тулд мацаг барилтыг Би сонгосон бус уу?” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 3-7.
2. Марион Ж.Ромни, Нийгмийн халамж, хөдөө аж ахуйн уулзалал, 1971 оны 4-р сарын 3, 1.
3. Спэнсэр В.Кимбалл, “Becoming the Pure in Heart,” *Ensign*, 1978 оны 5-р сар, 80.
4. Марион Ж.Ромни, “The Blessings of the Fast,” *Ensign*, 1982 оны 7-р сар, 4.



МАЦАГ БАРИХ: АРИУН НАНДИН БОЛОМЖИЙГ ЭРХЭМЛЭН ДАГА

“Би мацгийн хуулийг дагадаг хүмүүст ирдэг материаллаг болон сүнслэг гайхамшгуудын талаар гэрчилмээр байна. Би өөрт тохиолдсон гайхамшгуудын талаар гэрчилье. Исаиагийн цэдэглэснээр би мацаг барин залбирсан бөгөөд Бурхан үнэхээр “Би энд байна” (Исаиа 58:9) гэж хариулсныг гэрчилмээр байна. Та энэхүү ариун нандин боломжийг хамгийн багадаа сард нэг удаа эрхэмлэн дагаж; нөхцөл байдал, боломжийнхоо хэрээр мацгийн болон бусад өргөлөө хүмүүнлэгийн, боловсролын, номлолын санд хандивлаж байгаарай. Бурхан таныг өгөөмрөөр адислах болно гэдгийг мөн танаас тусламж авсан хүмүүс таныг адислагдсан нэгэн хэмээн дурсах болно гэдгийг би амлаж байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Бид бүгд гуйлгачид бус уу? 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 48.

ЗААЖ БАЙГАА ӨСВӨР ҮЕИЙНХНЭЭ ОЙЛГОХ НЬ

*Зааж байгаа өсвөр үеийнхнийхээ талаар мэдэж
авахын тулд хичээж чармайх нь тэднийг
хөрвүүлэх үүд хаалгыг нээж өгч чадна.*

Олон залууд зааж, зөвлөх үйл явцыг баяр хөөртэй болгож чадах урам зориг, эрч хүч бий. Харин зарим нь өсөж торнихын хэрээр бие махбод нь өөрчлөгдөхөөс эхлэн сургууль дээрх ачаалал, сайн мэдээний дагуу амьдрахгүй байхыг ятгах соёлын дарамтад дасан зохицох гэх мэт саад бэрхшээлтэй тулгарч байж болно. Өсвөр үеийнхэнд өөрсдийг нь ойлгож, анхаарал тавин халамжилдаг багш нар хэрэгтэй. Тэдэнд суралцах мөн мэдэж авсан зүйлийнхээ дагуу үйлдэх аюулгүй орчныг бүрдүүлдэг зөвлөхүүд хэрэгтэй.

Таныг өсвөр үеийнхэнд Аврагчийн арга барилаар төлөвлөн, бэлтгэж, заах үед тэдний тухай мэдэж байхад тустай хэдэн зүйлийг доор дурдав. Үүнд:

1. *Өсвөр үеийнхэн сургаалаас суралцахыг хүсдэг бөгөөд суралцах ч хэрэгтэй.* Сайн мэдээний жишгээс улам бүр холдож байгаа дэлхийд өсвөр үеийнхэн мөнхийн үнэнээр өлсөж, цангаж байна. Тэд “тэдгээр зүйлүүдийг байгаагаар нь, мөн тэдгээр зүйлүүдийг үнэхээр байхаар нь” (Иаков 4:13) заалгахыг хүсдэг. Сайн мэдээний сургаалаас дараах зүйлийг олж болно. Та зааж байхдаа судруудаас олж болох сургаал, амьд бошиглогч, төлөөлөгчдийн үгс болон Сүмийн албан ёсны бусад материал дээр анхаарлаа төвлөрүүл. Өсвөр үеийнхнийг эдгээр суралцах материалыг бие дааж судлахад урамшуулан дэмж. Сургаал хүчтэй нөлөө үзүүлдэг (Алма 31:5-ыг үзнэ үү).

2. *Өсвөр үеийнхэн хэн болохоо тодорхойлж байгаа хүмүүс юм.* Тэд хэн гэдгээ, юу болохыг хүсэж байгаагаа ойлгохыг хичээж байгаа. Тэд ирээдүйн үүрэг хариуцлагаа үүрэхэд бэлтгэгдэж байхдаа Их Эзэн өөрсдөд нь юу төлөвлөсөн байгааг мөн тэднээс хүлээж байгаа бүх зүйлийг хийж чадах эсэхээ мэдэхийг хүсэж байж болох юм. Та эцэг эх, багшийн хувьд тэдэнд ирээдүйдээ итгэх итгэлийг өгч, бэлтгэгдэхэд нь удирдан чиглүүлж чадна.

Тэднийг Бурханд илүү ойртож, амьдралаа сайн мэдээний жишгийн дагуу босгоход тусал. Тэдэнд ариун сүмийн ач холбогдол, Бурханы хаант улсыг барьж байгуулахад гүйцэтгэх үүргийг нь заа.

3. *Өсвөр үеийнхэн таны анхаарал халамжийг мэддэг.* Өсвөр үеийнхнийг сайн мэдээнээс суралцах үйл явцад идэвхтэй оролцуулахын тулд эхлээд та



өөрсдийг нь хайрладгаа мөн хувь хүнийх нь хувьд сонирхдог гэдгээ тэдэнд мэдүүлэх хэрэгтэй. Тэднийг сонс. Тэдний эерэг талыг олж харан, үүн дээр суурилж ажилла. Тэдэнд итгэдгээ илэрхийлэхийн зэрэгцээ үнэлдэг гэдгээ мөн хэрэгтэй хүмүүс гэдгийг нь хэлж бай.

4. *Өсвөр үеийнхэн олон зүйл сонирхдог.* Залуу хүн бүр өөр өөрийн гэсэн онцлогтой. Тэдний хувийн сонирхол, хэрэгцээ, сорилт бэрхшээлийн талаар олж мэд. Тэдэнд хуваарьт цуглаан, хичээл, үйл ажиллагаануудаас гадна хүрч очин туслах хэрэг гарч болно. Та тэднийг таньж мэдсэнээр, Сүнсээр дамжуулан тэдэнд хэрхэн заах арга барилд тань нөлөөлж болох хэрэгцээний талаарх ойлголт, сүнслэг удирдамжийг хүлээн авах болно. Өсвөр үеийнхэн өөрсдийнх нь амьдралыг үнэхээр сонирхож байгааг олж мэдэрвэл зүрх сэтгэл нь таны заах хичээл, гэрчлэлд илүү нээлттэй болдог.

5. *Өсвөр үеийнхэн асуултынхаа хариултыг өөрсдөө олж авч чадна.* Бүх насны суралцагчид сайн мэдээний ойлголтыг нээн илрүүлэх дуртай байдаг ч энэ нь өсвөр үеийнхэнд үнэт зүйлс, итгэл үнэмшлээ хөгжүүлэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Сайн мэдээний сургамжийг өөрийн биеэр мэдэж авч, сурсан зүйлийнхээ дагуу амьдрахад үр нөлөө нь урт удаан хугацаанд үлддэг



билээ. Та өсвөр үеийнхэнд хариултыг нь өгөхийн оронд тэднийг хариултаа өөрсдөө олж мэдэхэд урьж, урамшуулан дэмжсэн заах арга барилыг ашиглах нь зүйтэй. Энэ нь тэднийг сайн мэдээг заах гол зорилго болох хөрвөлтөд хүргэх болно.

6. *Өсвөр үеийнхэн бие биедээ зааж чадна.* Өсвөр үеийнхэн зааж байгаа зүйлд хувь нэмрээ оруулах мөн мэддэг зүйлсээ хуваалцах сонирхолтой байдаг. Та үлгэр жишээ, заавраараа дамжуулан тэдэнд Аврагчийн арга барилаар заахаар суралцахад нь тусалж чадна. Тэд эхлээд таны удирдлага дор хичээлийн нэг хэсгийг зааж эсвэл богино хэмжээний хэлэлцүүлэг удирдан явуулж болно. Туршлага сууж, өөртөө итгэх итгэлээ хөгжүүлснээр тэдэнд бүтэн хичээлийг бие дааж заах боломж гарч болох юм. Өсвөр үеийнхэн бие биеэсээ суралцсанаар үнэ цэнтэй зүйлсийг нь хуваалцадаггүй хүмүүсээс ирэх дарамт шахалтын эсрэг нэг нэгнээ хүчирхэгжүүлэхэд тусална.

7. *Өсвөр үеийнхэн удирдах чадварт суралцана.* Ангийн болон чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлийнхөнд үеийнхнээ удирдах ариун дуудлага оногдсон байдаг. Тэд удирдах туршлагатай байсан ч гэлээ, тэдэнд цуглааныг хэрхэн удирдах, бусдад хэрхэн суралцаж, үйлчлэхэд нь туслах зэрэгт таны удирдамж хэрэгтэй. Өсвөр үеийнхэн гэр орондоо утга учир бүхий үүрэг хариуцлага авсан үед тэдэнд өөр бусад удирдах боломж ч гарч ирэх боломжтой.

8. *Өсвөр үеийнхэн эцэг эх, бусад насанд хүрсэн хүнээс үлгэр дуурайл авч суралцдаг.* Багшийн хувьд таны гүйцэтгэдэг үүргийн нэгэн чухал хэсэг бол өсвөр үеийнхэн, тэдний удирдагчдын болон эцэг эхийн хоорондын харилцааг хүчирхэгжүүлэхэд туслах явдал юм. Та өсвөр үеийнхэнд олон асуултынхаа хариултыг олж авахад нь тусалж болох ч тэдний зарим асуултад эцэг эх эсвэл удирдагчид нь хариулбал илүү зөв зүйтэй байж болох юм. Залуучуудыг эцэг эх рүү нь хандуулж, гэр бүлийн харилцаа холбоогоо хүчирхэгжүүлэхэд урамшуулан дэмж. Та эцэг эхтэй нь тогтмол холбогдож, ангид судалж байгаа зүйлийнхээ талаар мөн тэдний охид, хөвгүүдээс олж харсан авьяас чадвар, өсөлт хөгжил, эерэг зүйлсийг хуваалцаж бай. Хүүхдүүддээ зааж сургахад хэрхэн тусалж болох талаар тэднээс асуу.

Өсвөр үеийнхнийг хөрвөгдөхөд эцэг эх, багш, удирдагч, зөвлөгч, институтийн багш нар хамтдаа хичээл зүтгэл гаргах шаардлагатай. Та нар хамтран ажилласнаар тус тусдаа гүйцэтгэж чадахаас хавьгүй хүчирхэг суралцах туршлагыг өсвөр үеийнхэнд зориулан бий болгож чадна. ■

Илүү ихийг мэдэхийг хүсвэл, "Аврагчийн арга барилаар заах нь" шинэ гарын авлага дахь "Өсвөр үеийнхэнд заах нь" сэдвийг үзнэ үү (заах нь.lds.org).

“Бяцхан үрсээ болгоогтун”

ХҮҮХДҮҮДЭД ЗААХАД СУРАЛЦАХ НЬ

“[Есүс] тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав. . . . Мөн тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв” (3 Нифай 17:21, 23).

Хэрэв та эцэг эх бол эсвэл хүүхдүүдэд заахаар дуудагдсан бол танд агуу бэлэг өгөгдсөн гэсэн үг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард “Бурхан өнөөгийн хүүхдүүдийг хайраар болон итгэлийн гал дөлөөр, тэд хэн бэ гэдгээ мэдэх ойлголтоор хүрээлүүлэхээр [та] биднийг томилсон юм” хэмээн заасан.¹

Хүүхдүүд танд баяр баясгаланг авчран, сайн үлгэр жишээ байх хүслийг төрүүлдэг. Та хүүхдүүдийн итгэлтэй байдал, хайр, итгэл, найдварыг ойлгож эхэлснээр Их Эзэнд илүү ойртож, “бяцхан хүүхдүүдтэй адил бол” (Матай 18:3) гэсэн Түүний зарлигийг илүү сайн ойлгох болно.

Хүүхдүүдийг Аврагчийн адил хайрлаж, Түүний арга барилаар заахыг хичээх үедээ тэдний тухай санавал зохих найман зүйлийг доор оруулав. Үүнд:

1. Хүүхдүүд *итгэмтгий байдаг*. Тэд үнэнийг хүлээн авахад бэлэн байдаг. Тэдэнд зөв сургаалыг ойлгомжтой үг хэллэг, үлгэр жишээгээр энгийн бөгөөд тодорхой заа.

2. Хүүхдүүд *Сүнсний нөлөөг таньж мэддэг*. Тэдэнд Есүс Христийн болон Түүний сайн мэдээний тухай ярьж, дуулах үед мэдрэгддэг амар амгалан, хайр энэрэл, баяр баясгалангийн мэдрэмж Ариун Сүнснээс ирдэг гэдгийг заа. Тэдэнд эдгээр мэдрэмж нь гэрчлэлийн нэг хэсэг гэдгийг ойлгоход тусал.

3. Хүүхдүүд *санааг шууд утгаар нь ойлгодог*. Ойлгоход хэцүү сургаалт зүйрлэл тэднийг төөрөгдүүлж болзошгүй. Та зааж байхдаа гэр орон, гэр бүл, хүрээлэн буй орчин гэх мэт тэдний мэддэг үйл явдал, үйл ажиллагааг эш тат.

4. Хүүхдүүд *сурах илүү их хүсэлтэй байдаг*. Тэд олон янзын туршлага, төрөл бүрийн мэдрэхүйгээ ашиглан суралцах дуртай. Ялангуяа

тэд хичээлд үзүүлэн таниулах материал, оролцон тоглох үйл ажиллагааг ашиглахад гойд сайн хүлээн авдаг. Тэдэнд хөдлөх, судлах, шинэ зүйлсийг оролдож үзэх боломж олго.

5. Хүүхдүүд *хуваалцаж, туслах хүсэлтэй байдаг*. Тэдэнд бие биедээ болон танд зааж чадах зүйлс бий. Тэднийг мэдэж авсан зүйлээ хуваалцахад урь. Тэдэнд судар унших, зураг барих, асуулгад хариулах, самбар дээр бичих боломж олго.

6. Хүүхдүүд *хайраар дүүрэн байдаг бөгөөд бусдаар хайрлуулахыг хүсдэг*. Тэдний төрөлхийн сайхан сэтгэл, хайраар дүүрэн зан чанарыг бэхжүүлэх боломжийг эрэлхийл. Тэдэнд хайр, талархлаа илэрхийлэн, хэлж байгаа зүйлийг нь анхааралтай сонссоноор өөрөө өөртөө итгэх итгэлийг нь хөгжүүл.

7. Хүүхдүүд *таны үлгэр жишээг дагадаг*. Та нар өөрсдөө мэдээгүй үедээ ч гэсэн тэдэнд үргэлж зааж байдаг. Хүүхдүүд таныг зааж буй зарчмынхаа дагуу хэрхэн амьдарч байгааг ажиглаж байх болно. Таны зөв шударга үлгэр жишээ тэдний бүрэлдэж буй гэрчлэлд хүчтэй нөлөөлнө.

8. *Бага насны хүүхдүүд богино хугацаанд нэг зүйл дээр анхаарлаа хандуулах чадвартай байдаг*. Анхаарлаа хандуулахгүй байгаа нь тэд ядарч, өлссөн, таны хэлсэн ямар нэг зүйлийг ойлгохгүй, хөдөлгөөн хэрэгтэй эсвэл уйтгартай байгааг илэрхийлж байж болох юм. Тэд давталт, өргөн сонголт, энгийн түүх, дуу, үйл ажиллагаагаар дамжуулан сурах дуртай байдаг. Тэднийг хичээлд оролцоход урамшуулан дэмжиж бай. ■

ХИЧЭЭЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Хүүхдийн хэсэгт болон гэр бүлийн үдшээр заах хичээлийг баяжуулах түүх, үзүүлэн таниулах материал эсвэл видео бичлэг хэрэгтэй байгаа ч хэрхэн олж авахаа мэдэхгүй байна уу? Тэгвэл lessonhelps.lds.org вэбсайтаар зочилно уу.

Илүү ихийг мэдэхийг хүсвэл, “Аврагчийн арга барилаар заах нь” шинэ гарын авлага дахь “Хүүхдүүдэд заах нь” сэдвийг үзэн үү (заах нь.lds.org).

ЭШЛЭЛ

1. М.Рассэлл Баллард, “Great Shall Be the Peace of Thy Children,” *Ensign*, 1994 оны 4-р сар, 60.



“Хүүхдүүдийн инээд зүрх сэтгэлийг маань баясган, Хүүхдүүдийн итгэл бодгалийг маань тайтгаруулж, Хүүхдүүдийн хайр үйл хэрэгт маань нөлөөлөх болтугай.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Precious Children—A Gift from God,” *Ensign*, 1991 оны 11-р сар, 70.



Тэрээр 1953–
1992 онд Далын
гишүүнээр үйл-
чилж байсан

**Ахлагч Марион
Д.Хэнкс
(1921–2011)**

Ариун сүмд шүтэн бишрэх нь Бурханыг таньж мэдэх түлхүүр

Ариун сүмд бид Христийн дэлхий дээр амьдарч байсны адил мөн одоо Түүнтэй болон Эцэгтэй адил амьдрахын тулд хэрхэн бэлтгэгдэхэд суралцаж чадна.

Би Солт Лэйкийн ариун сүмийн ерөнхийлөгчөөр үйлчилж эхэлснийхээ дараахан, ариун сүмд ирсэн нэгэн хүнтэй анхны сэтгэл түгшим, нухацтай ярилцлага хийснээ одоо ч гэсэн тод санадаг. Аливаа зүйлийг сайтар тунгаан боддог нэгэн залуу эмэгтэй ариун сүмийн суралцахын өргөөний болон зааврын өргөөний хувьд гүйцэтгэдэг үүргийн талаар зохих шүлгээс олж уншсан байв. Тэрээр “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх” нь “мөнхийн амь мөн” (Иохан 17:3) гэдгийг олж харсан хангалттай ажигч гярхай нэгэн байсан юм. Түүнээс гадна бид зөвхөн Христээр дамжуулан өөрсдийн Эцэгийн талаар суралцан, эцэст нь Түүнд эргэн очно гэдгийг мэдэж байв.

Би ариун сүм доторх бүх зүйл эцсийн эцэст Христ рүү болон бидний Эцэг рүү чиглүүлдэг гэсэн гэрчлэлээ түүнтэй хуваалцсан. Ёслол, гэрээнүүдийн үр нөлөө нь Түүний гэтэлгэгч хайранд болон “Бурханы Хүүгийн жаягийн нэрээр Ариун санваар хэмээн нэрлэгддэг” (С ба Г 107:3) итгэмжлэн хүлээлгэсэн эрх мэдэлд байдаг. Гэхдээ тэр эмэгтэй ариун сүм хэрхэн Их Эзэнийг таньж мэдэхэд туслах чухал түлхүүр болж чадах талаар тодорхой холбоосыг оюун ухаан, зүрх сэтгэлдээ хараахан бий болгож чадаагүй байв. . . .

Христ, судар, ариун сүм, гэр орон

Ариун сүм нь бидэнд өөрийн биеийг цэвэршүүлж, ариусгах орчинг үүсгэхэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг

бөгөөд Христийн тухай суралцахын хэрээр энэ нь биднийг амьдралын хамгаас үнэ цэнтэй бэлгүүд рүү хөтөлж, Түүний талаар хувийн мэдлэг, гэрчлэлтэй болоход чиглүүлдэг юм.

Ариун сүмд суралцах, шүтэн бишрэх үйл явц нь Есүс Христээр дамжуулан суралцах мөнх амьдралын их сургууль болж чадна. Көртландын ариун сүмийг онцгойлон адислах залбирлын үеэр Их Эзэнд: “Мөн Ариун Эцэг минь, энэ өргөөнд шүтэн бишрэх тэд бүгд мэргэн ухааны үгсээр заагдаж болохын тулд . . . ;

“Мөн тэд танд өсөхийн тулд, мөн Ариун Сүнсний бүрэн байдлыг хүлээн авч болохын тулд буюу” хэмээх хүсэлтийг өргөн барьсан байна (С ба Г 109:14–15).

Үүнийг ёслол, зан үйлээр гүйцэлдүүлдэг үү? Хэрэв бид зорилго, бэлгэдлийг Адам, Ева хоёр мөнх бус амьдралынхаа эхэн үед ойлгосны адил ойлгож чадвал энэ нь зарим талаараа тийм байж болох юм. Гэхдээ бид мөнх амьдралын захиасын агуулга, мөнхийн өсөлт хөгжлийн зарчмаар дамжуулан суралцдаг. Энэ нь бидний Их Эзэнтэй гэрээнд орсон цөөхөн энгийн зарчмын хүрээнд хийгддэг. Бид Христийн үхлээр Бурхантай эвлэрүүлэгдэж, “Түүний амиар” (Ром 5:10) аврагддаг хэмээн Паулын ромчуудад хандан хэлсэн мэдэгдлийг санагтун. Миний хувьд Түүний ариун амьдралын зарчмууд биднийг өргөмжлөл хэмээн нэрлэгддэг авралын бүрэн дүүрэн байдал руу буюу хайртай хүмүүстэйгээ болон Эцэг, Хүүтэй хамт Бурханы түвшинд хайрлан,



суралцаж, үйлчилж, өсөж хөгжин, бүтээлч амьдрал руу хөтөлдөг болохыг илэрхийлдэг юм. Ариун сүмд бид Христийн дэлхий дээр амьдарч байсны адил мөн Түүний болон Эцэгийн адил хэрхэн амьдарч болоход суралцаж чадна.

Христийн амьдралын үндсэн зарчмууд

Түүний амьдралд чухал байр суурь эзэлдэг бөгөөд ариун сүмд заагддаг, бидний Их Эзэнтэй хийдэг гэрээ-нүүдтэй холбоотой ямар ямар зарчим байдаг вэ? . . .

Тэрээр магадгүй зөвхөн Эцэг Тэр хоёрын л ойлгож чадах арга замаар хайрласан юм. Гэхдээ бид үүнийг мэдэж авахын тулд, хангалттай өгч, хайрлаж сурахын тулд энд байгаа билээ. Би дайны талбараас болон эмнэлгийн өрөөнөөс мөн эцэг эхийн үр хүүхдийнхээ төлөөх амь биеэ үл хайрлам баатарлаг үйлдлээс Аврагчийн арга замаар хайрлаж, золиосолж сурсан хүмүүсийг харж байсан.

Бид бусдад өгч, анхаарал халамж тавьж, нигүүлсэнгүй, сайхан сэтгэлээр хандах замыг сонгож, дагахын хэрээр энэ бүхнийг хийх нь сайн мэдээний хувьд сонголт биш, харин ч амин чухал хэсэг нь гэдгийг ойлгож эхэлдэг. Биднээс ёс журамтай, үнэнч, аминч бус үзэлтэй, боловсон харьцаатай, сайн мэдрэмжтэй байхыг хүсдэг. Эцсийн эцэст бидний ямар хүн байх, юугаа өгөхөд бэлэн байх нь хамгийн чухал. . . . Энэ нь бидний Их Эзэний удирдамжийг судлан, хүлээн авахдаа өдөр бүр, цаг тутам гаргаж байдаг шийдвэр юм.

Аврагчийг цовдлуулан, амилж, тэнгэр өөд аваачигдсаны дараа Түүний итгэлийг хөсөрдүүлж байсан Петрээр удирдуулан үлдсэн шавь нарт нь нэгэн зүйл тохиолдсон билээ. Пентекостын буюу Сүнс ирсэн өдөр итгэлдээ эргэлзэж байсан хүмүүс хүчирхэг гэрчлэлтэй болж, гэрчлэн зогсож байсан. Үйлс номын 1–5-р бүлэгт энэ түүхийг өгүүлдэг. 5-р бүлгийн сүүлийн шүлгүүд хүчтэй нөлөө үзүүлдэг юм. Гамалиел шавь нарт дахин нэг боломж олгож, хугацаа өгөхийг зөвлөлийнхнөөсөө хүссэн байв. Тиймээс тэдэнд Христийн тухай зааж, номлохоо зогсоохыг тушааж, дахин нэг удаа ташуурдаад, сулласан гэнэ. Тэд Христийн нэрийн төлөө доромжлогдон зовох нь зохистой гэж үзэгдэх болсондоо баярлалдан зөвлөлөөс гарч явав. Дараа нь, “өдөр бүр сүм дотор, бас айлаас айлд, Есүс бол Христ гэдгийг сургаж тунхагласаар байв” (Үйлс 5:42) хэмээн цэдэглэсэн байдаг.

Үүний адил 3 Нифай 17:3-т “Тиймийн тул, та нар гэр гэртээ харьцгаа, мөн миний хэлсэн зүйлсийг эргэцүүлж, мөн, та нар ойлгож, мөн би та нарт дахин ирэх маргаашийн төлөө оюун санаагаа бэлтгэж болохын тулд миний нэрээр Эцэгээс асуу” гэж цэдэглэсэн шиг бид

сүнсээрээ ариун сүмээс гарч явах үед ямар нэгэн зүйл тохиолдох ёстой.

Ариун сүм дэх шүтлэг бишрэлийн цэвэршүүлэгч хүч

Цэвэршүүлэгч сүнс нь биднийг Их Эзэний алхалж, гэрэлтүүлсэн замыг онцгой байдлаар таньж мэдэн, Түүнийг хайрлаж мөн хайр, ах дүүгийн барилдлагыг үзүүлдэг, Их Эзэний хүслийн дагуу бусдад үйлчилж, хуваалцаж, хайрлаж, зөв жишгүүдэд үнэнч байж, Бурханы хаант улсыг бүхнээс өмнө эрэлхийлдэг шинэ хүн болоход нөлөөлдөг билээ.

Бид гэр бүлийнхээ амьдралыг цэвэршүүлэн, гэр орноо өдөр бүр Есүс Христийн тухай “зааж мөн номлодог,” Түүнийг үргэлж дагадаг газар болгох хэрэгтэй. Бид суралцаж, амин хувиа хичээлгүйгээр үйлчлэлийг гэр орон, гэр бүл, хувийн амьдралынхаа төв болгох хэрэгтэй. Рүфүс Жонсын хэлснээр “Гэгээнтнүүдийг зөвхөн тэнгэр элчийн гэрэлт цагариг өгөхийн тулд мөн дотоод сэтгэл хөдлөлийг мэдрэхийн тулд бий болгодоггүй. Тэднийг гэрэл, хүч төвлөрүүлсэн оргил болгохын тулд бий болгодог. Жинхэнэ гэгээнтэн бол сайн эх, сайн хөрш, нийгэм дэх бүтээлч хүч, таатай уур амьсгал, адислал байдаг юм. Жинхэнэ гэгээнтэн бол тэнгэрт бүрэн хэрэгжих амьдралыг зарим байдлаар тодорхой харуулдаг, эрч хүчтэй Христэд итгэгчийг хэлнэ.”¹

Миний хувьд юу ариун сүмийн болон ариун сүмд шүтэн бишрэхийн тодорхой бөгөөд чухал түлхүүр



болохыг бодож үзэцгээе. 1836 онд Их Эзэн бошиглогч Иосеф Смитэд Көртландын ариун сүмийг онцгойлон адислах залбирлаар илчлэлт өгсөн билээ. Энэ залбирал дараа нь Сургаал ба Гэрээний 109-р хэсэг болсон. Ариун сүмийн үндсэн ач холбогдлыг ойлгохыг чин сэтгэлээсээ хүссэн хүн үүнийг, ялангуяа эхний сэтгэл хөдлөм 24 шүлгийг дахин дахин сайтар унших хэрэгтэй. 5-р шүлэг бол гүн гүнзгий судлах шаардлагатай гайхалтай мэдэгдэл юм. “Учир нь агуу их гай зовлон үзэж байж энэ ажлыг хийснийг та мэдэх билээ, Хүний Хүү өөрийнхөө хүмүүст өөрийгөө үзүүлж болох газартай байж болохын тулд бид ядуу зүдүү байдлаасаа өөрсдийн эд хөрөнгийг таны нэрэнд өргөө барихад өргөсөн билээ” (С ба Г 109:5; тодотгол нэмэгдсэн).

Тэр ариун сүмд байх хүмүүстээ Өөрийгөө хэрхэн үзүүлэх вэ?

Голдуу энэ нь ариун сүмийн зарчим, ёслол, гэрээнүүдийн сэтгэл татам, маргашгүй үнэн байдал, ариун сүмийн шүтлэг бишрэл, оюун бодол, зүрх сэтгэлээ нийцүүлсэн байдал, суралцаж Христийнхтэй адил үзэл баримтлал руу амьдралаа хөтлөх тэвчээр, хүсэл эрмэлзэлтэй хүмүүс хүртэх боломжтой илчлэлт, Сүнсний бусад адислал зэргээр дамжуулан боломжтой гэдэгт би итгэдэг (3 Нифай 27:21, 27-г үзнэ үү).

Миний хэлэх нэг жишээ Их Эзэний ариун сүмд тууштай үйлчилдэг хүмүүст ирдэг сүнслэг хүч чадлыг хангалттай харуулах юм. Би нэгэн өглөө гэрээсээ гарч, ариун сүмд очих замдаа зузаан гэгч орсон цасан дундуур зам гарган явах боломжтой байсандаа талархсаар 4:30-ын үед ариун сүмд ирэв. Нэгэн тусгаар өрөөнд таягаа налан, бодлогошронгуй суух, гүнээ хүндэлдэг, нэгэн настай найзтайгаа санаандгүй тааралдав. Тэр миний өмссөнтэй адил цагаан өнгийн, ариун сүмийн ажилтнуудын хувцсыг өмссөн байлаа. Би түүнтэй баярлан мэндэлж, өглөө үүрээр юу хийж байгааг нь асуув.


Тэр “Ерөнхийлөгч Хэнкс, та намайг энд юу хийж байгааг мэдэж байгаа шүү дээ. Би энд үүргээ биелүүлэхээр ирсэн ариун сүмийн ажилтан” гэв.

“Би мэдэж байна л даа. Гэхдээ таныг энэ цасан шуурганаар энд яаж ирсэн гэдэгт л гайхаж байна. Би сая радиогоор Парлигийн хавцлыг хааж, бүх хөдөлгөөнийг зогсоосон гэж сонссон” гэж хэллээ.

Тэр “Надад мод руу ч мацаж чадах дөрвөн дугуйт байгаа шүү” гэв.

“Надад ч бас байгаа, байгаагүй бол би энд ирж чадахгүй байх байсан. Гэхдээ би эндээс хэдхэн километрийн зайд амьдардаг” гэж би хэлэв.

Тэгээд би түүнээс мэдээгээр хаагдсан гэж зарласан энэ хавцлаар хэрхэн гарч ирснийг асуув. Түүний хариулт



анх удаа гадасны чуулганы хурлын өмнө нэгэн оройг хамт өнгөрүүлэх боломж олдох үед мориндоо мордож байхыг нь харж буй мэт эрүүл чийрэг, хүчтэй фермийн эзэн, гадасны ерөнхийлөгчийн амнаас гарах ердийн хариулт биш байлаа. Өндөр нас, үе мөчний өвчин нь түүнийг бөгтийлгөн жижгэрүүлж, амийг нь авч одоход тун ойртсон байв. Түүний хувьд хөдлөх нь маш зовиуртай байлаа. Тэрээр “Ерөнхийлөгч Хэнкс ээ, би тэр замын цагдаа нарын ихэнхийг төрсөн цагаас нь эхлэн мэднэ. Тэд намайг гарч явах ёстойг, шаардлагатай бол дээгүүр нь дайраад ч хамаагүй гарна гэдгийг мэдэж байгаа. Тэд миний машиныг мөн намайг ямар туршлагатайг мэдэж байгаа болохоор явуулах шаардлагатай гэж үзээд, хаалтаа зүгээр л холдуулсан даа” гэж хариулав.

Тэр өглөө эрт, яг цагтаа өөрийн ариун үүрэгт ажлыг эхлүүлэхээр итгэл төгс, үнэнч зогсож байсан. Яг ийм итгэлтэй, шүтлэг бишрэлтэй хүмүүсийг бий болгон хөгжүүлэхэд ариун сүм тусалдаг юм. ■

1993 оны 2-р сард Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн үгсээс авав. Бүрэн эх нь Доналд В.Парригийн (1994) бичсэн “Temples of the Ancient World,” номд хэвлэгдсэн.

ЭШЛЭЛ

1. Rufus Jones *Speaks to Our Time* (1961), 199.



Далын ахлагч
Ахлагч
Жозеф В.Ситати

ГЭРЭЭНДЭЭ ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДСАНДАР БУРХАНЫГ ДЭЭДЛЭХ НЬ

*Бурханд итгэх итгэлээс ирдэг хамгийн агуу адислал гэрээгээ
сахих замаар Түүнийг дээдлэн хүндлэх үед ирдэг.*

1985 онд Ситати эгч бид хоёр Кенийн Найробид Рожер Ховард гэдэг хүнтэй танилцсан юм. Тэр эхнэр Эйлийнтэйгээ ахмад хос номлогчоор үйлчилж байлаа. Тэд биднийг гэрт нь хийгддэг байсан жижигхэн цуглаандаа оролцохыг урьсан юм. Бид анх удаа Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн цуглаанд оролцож байсан нь энэ байлаа. Бид анхныхаа цуглаан дээр Сүнснийг мэдэрч, түүнээс хойш сүмд ням гараг бүр явдаг болсон.

Хэдхэн сарын дараа Рожер бидэнд есөн настай хүүтэй минь хамт баптисм хүртээсэн билээ. Удалгүй Рожер, Эйлийн хоёр ч номлолоо дуусгаж, гэртээ харьсан юм. Бид тэдэнтэй дараагийн хэдэн жил холбоотой байлаа.

2010 оны эхээр Ситати эгч бид хоёрыг Рожертой дахин уулзах үед тэр бараг 90 нас хүрч байв. Тэр өндөр насыг зооглон, эрүүл мэнд нь муудсан тул тэргэн дээр тулан явж байгаа харагдав. Олон жилийн дараа бид анх удаа бие биеэ харж зогсохдоо үгээр дүрслэн хэлэхийн аргагүй баяр баясгаланг мэдэрч билээ. Биднийг бие бие нээ зөөлхөн тэврэх үед нулимс минь урсаж байв. Бид нэг нэгнийгээ байгаад мөн сайн мэдээний гайхамшигтай бэлэгт гүнээ талархаж байлаа. Бид Бурханы хаант улсын иргэдийн хувьд итгэлээрээ нэгдмэл байв.

Энэ сайхан мөчийг таашаан эдэлж байх үед оюун бодолд минь: “Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу гэдгийг санагтун; . . .

Мөн, хэрэв та нар энэ хүмүүст наманчлалыг тунхаглахад өөрсдийн бүхий л өдрүүдэд хөдөлмөрлөж мөн зөвхөн нэг бодгалийг надад авчрах аваас, миний Эцэгийн хаант улсад түүнтэй хамт та нарын баяр хөөр хичнээн агуу байх билээ!” (С ба Г 18:10, 15) гэсэн судар орж ирсэн юм.

Бурханы агуу адислалын зарим нь бодгалийг Түүний хаант улсад авчрах хүмүүст амлагдсан байдаг. Аврагч “Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, үр жимс ургуулж та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт өгөх юм” (Иохан 15:16) хэмээн шууд хэлсэн байдаг.

Рожер дараа жил нь өөд болсон. Би түүнийг Бурхантай эвтэй нэгэн байсан гэсэн тод томруун мэдэрэмж хүлээн авсан билээ. Тэр сайн мэдээг хуваалцсанаар бидний амьдралд гүн гүнзгий нөлөөлсөн юм. Түүний бусдад бүхнээ зориулсан үйлчлэлийн үлгэр жишээ Сүмд үйлчилж байгаа залуу болон ахмад номлогчдын агуу армитай хамт бидний Бурханаа дээдэлдэг нэг арга замыг харуулдаг болно.



Бурхантай хийсэн бидний гэрээт харилцаа

Бид Есүс Христийн сэргээгдсэн Сүмийн гишүүнийг хээ ачаар гэрээгээр дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ хувийн харилцаа холбоотой болдог. Гэрээ бүр ёслолоор баталгааждаг ба үүгээр бид гэрээг өөрийн хүслээр хүлээн авч, сахина хэмээн амладаг. Есүс Христ Цагаатгалаараа дамжуулан Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэхийн хэрээр гэрээ бүрд хүлээсэн үүргээ биелүүлэх боломжийг бидэнд олгодог.

Бид авралын бүх гэрээ, ёслолыг хийж, сахих замаар Түүнтэй харилцах харилцаагаа улам бүр гүнзгийрүүлэхийн хэрээр Тэнгэрлэг Эцэгээ дээдэлж байдаг билээ. Тэрээр гэрээгээ сахидаг хүмүүсийг Өөрийн Сүнсээр удирдаж мөн хүчирхэгжүүлэн адисалдаг. Дараах зүйлс нь Тэнгэрлэг Эцэгтэй үүсгэж болох хамгийн чухал гэрээт харилцаа болно.

Баптисмын гэрээ

Баптисм нь биднийг Бурхантай хийх хамгийн анхны гэрээт харилцаанд оруулдаг. Бид Бурханы өмнө “[өөрсдийгөө] даруусгах, . . . харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр . . . мөн үнэхээр бүх нүглүүдээс наманчилснаа сүмийн өмнө гэрчлэгсэд, . . . мөн нүглүүдээсээ ангижрахын тулд Христийн Сүнсийг хүлээн авснаа өөрсдийн ажлуудаар үнэнхүү тунхагладаг . . .” (С ба Г 20:37) үед уг ёслолыг хүлээн эрхтэй болдог билээ.

Бид үйлдлээрээ “эцсээ хүртэл түүнд үйлчлэх шийдвэр төгс, Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авахад бэлэн” (С ба Г 20:37) гэдгээ харуулан, “нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд, мөн гашуудах тэдний хамт гашуудахад, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлэн” (Мозая 18:8–9) гэдгээ харуулснаар гэрээгээ сахидаг.

Үүний хариуд Бурхан бидэнд Ариун Сүнсний бэлгийг өгдөг бөгөөд үүгээр дамжуулан бид бүх үйлийг удирдан чиглүүлэн, мөнх амьдрал руу хөтлөгч Ариун Сүнсний байнгын нөхөрлөлийг хүлээн авдаг (Мозая 18:9–10-ыг үзнэ үү).

Би баптисм хүртсэнийхээ дараа баяр баясгалан, Сүнсээр дүүрсэн гэдгээ мэдэрсэн бөгөөд үүнийг ялангуяа Бурхантай ойртох бүр дахин дахин мэдэрдэг билээ.

Санваарын тангараг, гэрээ

Баптисмын гэрээгээ сахидаг ах нар санваарын тангараг ба гэрээнд орох эрхтэй болдог. Бид үүнийг толгой

дээр гар тавих ёслолоор дамжуулан хүлээн авдаг. Санваарын гэрээ нь Бурханы хүүхдүүдийн авралын төлөө үйлчилнэ гэсэн гэрээ юм. Бид дуудлагаа эрхэмлэн биелүүлж (С ба Г 84:33-ыг үзнэ үү), “бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун хийгээд чадлаараа” (С ба Г 4:2) мөн “итгэл, найдвар, энэрлээр” (С ба Г 4:5) үйлчилснээр Бурханыг дээдэлдэг.


Итгэлтэй санваартнуудад ирдэг Их Эзэний адислалд “биеэ шинэчлэхийн тулд Сүнсээр” (С ба Г 84:33) ариусгагдах нь ордог. Тэд Мосегийн хийгээд Абрахамын адислалын өв залгамжлагч болдог (С ба Г 84:34-ийг үзнэ үү). Хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчид бол санваараа эрхэмлэн дээдэлдэг хүмүүсийн сайн үлгэр жишээ мөн. Тэдний амьдрал Их Эзэн тэднийг дээдлэн хүндэлдэг гэдгийг гэрчилдэг.

Ариун сүмийн ёслол, гэрээ

Дээд санваарыг атгадаг зохистой ах болон зохистой эгч нар ариун сүмд ариун нандин ёслолыг хүлээн авч, ариун гэрээнүүд хийх боломжтой. Бид ариун сүмийн ёслол, гэрээгээр дамжуулан энэ амьдралын зорилгыг ойлгож, мөнх амьдралд хэрхэн бэлтгэгдэж болохыг сурдаг. Бид ёслолыг хүлээн авч, мөнхийн гэрлэлтийн болон гэр бүлтэйгээ лацдан холбогдох гэрээнд ордог. Бид Бурханд болон Түүний бүх хүүхдийн төлөө авралын ажилд өөрсдийгөө зориулах болно хэмээн амладаг. Эдгээр гэрээг итгэлтэй сахих нь бидэнд мөнх бус амьдралын зовлон зүдгүүрийг даван туулах сүнслэг удирдамж, хүч чадлыг хүлээн авч, Бурханы хүүхдүүд дээ өгч чадах хамгийн агуу адислал болох өргөмжлөлөөс хүртэх эрхийг олгодог (С ба Г 14:7-г үзнэ үү). Өргөмжлөл эсвээс мөнх амьдрал гэдэг нь Тэнгэрлэг Эцэгийнхээ амьдарч буй амьдралаар гэр бүлээрээ амьдрахыг хэлнэ.

Ариун ёслол

Сүмийн гишүүдийн хувьд Хүндэтгэлийн өдөр болгон ариун ёслолоос зохистой хүртэх нь нэн чухал зүйл юм. Бид энэ ёслолоор дамжуулан Есүс Христийн нэрийг өөрсөд дээрээ авч, хийсэн бүх гэрээгээ сахина гэсэн амлалтаа шинэчлэх хүсэлтэй байгаагаа батлан харуулдаг. Бид үүгээр дамжуулан зөв шударгаар, эцсээ хүртэл тэвчихэд туслах Есүс Христийн Цагаатгалын хүчийг дуудан авчирдаг. Бид үүнчлэн үйлдсэнээр хийсэн бүх гэрээнийхээ бүхий л адислалаас хүртэх эрхтэй болдог.



*Есүс Христ
Цагаатгалаараа
дамжуулан Өөрт
нь итгэх итгэлийг
хөгжүүлэхийн
хэрээр гэрээ бүрд
хүлээсэн үүргээ бие-
лүүлэх боломжийг
бидэнд олгодог.*

Зөв хүсэл тэмүүлэл

Гэрээгээ зөрчих нь Бурханыг гомдоож, амлагдсан адислалыг хүчингүй болгодог (С ба Г 82:10-ыг үзнэ үү).

Бид 1 Самуел 2:12–17, 22–34-өөс Елигийн тахилч хөвгүүдийн хийсэн хилэнцэт зүйлсийг мэдэж авдаг. Тэд эцгийнхээ байр суурийг ашиглан санваарынхаа гэрээг зөрчдөг. Тэд эмэгтэй шүтэн бишрэгчидтэйгээ ёс бус явдалд орооцолдон, Израилийн хүмүүсийн тахилын махнаас өөрсдөдөө ёс бусаар авснаар шунал хүслээ гүйцэлдүүлэхийг эрэлхийлдэг байв. Их Эзэн Елигийн хөвгүүдэд мөн хөвгүүдээ хориглоогүйн учир Елид хатуу шийтгэл оноосон юм.

Ийм махан бодийн хүслийг Египетийн Иосефын завхай үл итгэгчтэй нуур тулах үедээ харуулсны

адил (Эхлэл 39:9, 12-ыг үзнэ үү) Бурхантай хийсэн гэрээгээ сахих зориг шийдэмгий байдлаар даван туулах боломжтой. Бурхан Иосефыг хүндэлж, түүний эсрэг хийгдсэн бүх хорон муу төлөвлөгөөг даван туулахад тусалсан юм. Тэрээр Египетийн хоёр дахь хамгийн хүчтэй хүн, мөн Израилийн гэр бүлийг авч үлдэхэд зориулагдсан Бурханы мутар дахь зэмсэг болж чадсан (Эхлэл 45:7–8-ыг үзнэ үү).

Хэрэв бид уруу татагдвал Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаагаа сэргээх гэсэн хүсэл маань биднийг чин сэтгэлийн наманчлал руу хөтөнө. Харин Аврагч Есүс Христийн Цагаатгал биднийг дахин зохистой болоход тусална.

Бошиглогчдыг дагах нь

Христ Сүмээ байгуулахдаа төлөөлөгч, бошиглогч, евангелист, пастор болон багш нарыг

“Бид бүгд итгэл хийгээд Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл хүртэл, төлөвшсөн хүн болтол, Христийн дүүрэн байдлын чанарын хэмжээнд хүртэл” “Христийн биеийг байгуулахын тулд” (Ефес 4:12–13 сонгосон юм.

Амьд бошиглогч, төлөөлөгчид

“Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиох зарчмуудыг баримтлан амьдарна” (“Гэр Бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” 2010 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 129) хэмээн заадаг.

Бидний гэр орон, гэр бүл гэрээнд суурилсан Бурхантай харилцах хүчирхэг харилцааг бий болгох үндэс суурийг тавьж өгдөг. Амьд бошиглогчдын сүнс-лэгээр өдөөгдсөн сургаалыг дагах нь бидэнд хүчтэй гэр бүлтэй болж, гэрээгээ сахих хүч чадлыг өгч, итгэлийн хамгийн агуу адислалыг баталгаажуулахад тусална. ■

НАДАД САЙН МЭДЭЭГ ТАНИЛЦУУЛСАНД БАЯРЛАЛАА

Манай гэр бүл 1980-аад оны эхээр Баруун Германд амьдардаг байсан бөгөөд бид Германы Кайзерслаутерны цэргийн албан хаагчдын гадасны гишүүн байв. Тухайн үед манай орон нутгийн удирдагчид номлолын ажилд онцгой анхаарал хандуулж байлаа. Их Эзэн Есүс Христийн сайн мэдээг эрэлхийлж буй сонгогдсон сүнсэн хүүхдүүдийн зарим нь бидний найзуудын дунд байгаа гэж бидэнд хэлдэг байв.

Миний эхнэр Жэнни бид хоёр үүнийг үнэн гэдэгт итгэж байсан. Удирдагчид маань хүн бүрийг сайн мэдээг сонирхон сонсож магадгүй гэж бодож байгаа гишүүн бус найз нөхдөө тодорхойлоход урамшуулан дэмжсэн юм. Бид арваад хүний нэрийн жагсаалт гаргаад, жагсаалт дахь найзуудынхаа талаар мацаг барьж, залбирч, хэнтэй нь эхлээд ажиллах ёстойгоо шийдэх ёстой байв. Бид надтай хамт ажилладаг байсан хоёр эрэгтэйтэй холбоо барихаар шийдсэн. Эхлээд би Крис гэдэг ганц бие залуутай ярилцаж үзсэн ч тухайн үед тэр нэг


их сонирхсонгүй. Дараа нь бид сайн бас сайхан сэтгэлтэй Брүс Хамбигийн залуухан гэр бүлтэй уулзахаар шийдэв.

Хэдэн өдөр өнгөрсөн ч би түүнтэй сайн мэдээний тухай ярина гэхээс тэвдэж байлаа. Эцэст нь, нэг өдөр Жэнни миний ажлын өрөө рүү залгаад, “Чи Брүстэй ярилцсан уу” гэж надаас асуув. Би “Үгүй ээ, гэхдээ удахгүй ярина аа” гэж хариулав. Түүнийг дараа нь Брүс ажлын өрөөндөө байгаа эсэхийг асуухад би түүнийг байна гэж хэлэв. Яг тэр үед эхнэр минь “Скотт, утсаа тавьчих. Би чамайг түүнтэй ярилцтал хүлээж байя!” гэж хэлэв.

Би ч утсаа тавиад, Брүс рүү сандарсхийн дөхөж очоод, “Брүс, та намайг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн гэдгийг мэдэх үү” гэж асуув. Түүнийг тийм ээ гэж хариулахад нь би “Та Сүмийн талаар илүү ихийг мэдмээр байна уу?” гэж асуув. Тэрээр “Тийм ээ, би мэдмээр байна” гэж хариуллаа.

Дараагийн хэдэн долоо хоногийн турш Брүс эхнэр Элла, охин Тая хоёрынхоо хамт манай гэрт оройн хоолонд уригдан ирж, номлогчидтой уулзав. Тэд хичээл заалгаж, сүмийн цуглаануудад бидэнтэй хамт оролцон, сайн мэдээг хүлээн авч, баптисм хүртсэн билээ. Тэр өдөр ер бусын сайхан, аз жаргалтай өдөр байсан. Брүс гэр бүлд нь сайн мэдээг танилцуулсанд бидэнд талархаж байлаа. Хамт ажилладаг Крис хүртэл баптисмд нь оролцож, сэтгэл нь хөдөлсөн байв. Дараа нь Брүс, Элла хоёр Крист сайн мэдээг танилцуулахыг хүссэн билээ. Тэдний тусламжтайгаар Крис номлогчдоос хичээл авч, Сүмд нэгдсэн. ■
Скотт Эдгар, АНУ, Юта

“Скотт, утсаа тавьчих. Би чамайг Брүстэй сайн мэдээний талаар ярилцтал хүлээж байя!” гэж эхнэр минь хэлсэн.





Гайхалтай нь би тайтгарал, тусламж хэрэгтэй байсан нэгэн идэвх султай эгчтэй тэнд санаандгүй тааралдаж билээ.

БИ ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ БАЙГААГАА МЭДЭРСЭН

Би Халамжийн нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр дуудагдах үедээ зав муутай залуухан ээж байлаа. Би Сүмд өсөж, амьдралынхаа турш Сүмийн сургаалын дагуу амьдарсан ч төгс биш гэдгээ мэддэг байсан бөгөөд надад тойргийнхоо зовж зүдэрч байгаа эгч нарт туслах чадвар байгаа эсэхэд эргэлзэж байв.

Нэгэн ням гаргийн өдөр би сүм дээр сэтгэлээр ихэд унаж билээ. Бүхэл өдөржин миний тусламж хэрэгтэй болсон эгч нар над дээр ирж, ярилцав. Заримд нь халамжийн тусламж хэрэгтэй байхад заримд нь зүгээр л сонсох хүн хэрэгтэй байсан юм. Дараа нь Сүнс надад ариун ёслолын цуглаан эхлэхэд орох хэрэггүй гэсэн мэдрэмж өгөв. Гайхалтай нь, би тэнд тайтгарал, тусламж хэрэгтэй төдийгүй ариун ёслолын цуглаан дуустал хүлээх боломжгүй нэгэн идэвх султай эгчтэй санаандгүй тааралдаж билээ.

Би сүмээс гарахдаа маш их ядарсан байв! Би гэртээ харих замынхаа туршид машин дотроо уйллаа. Миний толгойд “Бишоптойгоо яриц!” гэсэн үгс орж ирэв. Бишоп

надад дуудлагаа хэрхэн түүртэхгүй хийх талаар ямар нэг ухаалаг зүйл хэлэх байх гэж би бодсон ч сүм дээр олон цагийг өнгөрүүлсэн түүнд саад болохыг хүссэнгүй. Би түүн рүү утасдахаа хойшлуулахаар шийдэх яг тэр мөчид утас дуугарлаа. Энэ нь манай бишоп байв. Түүнд над руу залга гэсэн мэдрэмж төрсөн байлаа.

Би бишоптоо ийм их зүйлийг нэг дор шийдвэрлэх нь надад ямар хүнд байсныг мөн илүү олон эгчид тусалж чадаагүйдээ сэтгэлээр унаж байгаагаа хэллээ. Тэр намайг тэвчээртэй сонсов. Бас түүнтэй зарим нэгэн халамжийн асуудлуудыг ярилцахад миний сэтгэл санаа арай дээрдсэн байлаа.

Би түүнтэй ярьж дуусахдаа “Танд дуудлагаа хэрхэн түүртэхгүй хийх талаар надад хэлэх ямар нэг ухаалаг зүйл байгаа гэж бодсон” гэдгээ хэлэв. Тэр тэгээд хэлчих зүйл байсан ч болоосой, харамсалтай нь алга даа гэж надад хариулсан юм.

Хэдийгээр тэр миний асуултад хариулаагүй ч би утсаа тавихдаа баяртай байв. Их Эзэн удирдамж, дэмжлэг хэрэгтэй үед маань хариулсан болохыг би мэдэрсэн.

Дараагийн хэдэн долоо хоног би дахиад л өөртөө итгэлгүй байсан бөгөөд Халамжийн нийгэмлэгийн илүү сайн ерөнхийлөгч болохын тулд юу хийх хэрэгтэйгээ мэдэхийн төлөө залбирав. Нэгэн өдөр намайг Ерөнхий чуулганыг сонсож байх үед нэг үг миний анхаарлыг татаж, Сүнс миний зүрх сэтгэлд хүчтэй ярьсан билээ. Би ганцаараа байх үедээ шаардлага хангахгүй байсан учраас шаардлага хангахгүй байна даа гэсэн мэдрэмж надад төрж байсныг ойлгосон юм.

Бишоп үлгэр жишээгээрээ Ариун Сүнсийг сонсох нь ямар чухал болохыг надад харуулсан. Сүмд дуудлагуудаа хийж гүйцэтгэхэд тусалдаг хамгийн гол зүйл бол бидний авьяас, ур чадвар биш харин Сүнс юм. Удаан хугацааны дараа би анх удаа амар амгалан, итгэл найдварыг мэдэрч билээ.

Би туршлага дутмаг, гэр бүлдээ завгүй хэвээр байсан ч дуудлагаа төгс хийх ёстой гэж бодохоо больсон юм. Тэнгэрлэг Эцэг хүслээ гүйцэлдүүлэхийн тулд хэрэгтэй зүйлсээр намайг хангаж, зарлигуудыг нь дагаж байгаа үед бидний хичээл зүтгэлийг өсгөн нэмэгдүүлж чадна. ■

Нэрээ нууцлав, Шведийн Стокгольм

ЭМЭЭГИЙНХЭЭ ТАЛААР МЭДЭЖ АВСАН

Миний харамсаж явдаг нэг зүйл бол би хэзээ ч аавынхаа ээжтэй хамт суун, амьдралынх нь талаар ярилцаж, түүний дурсамжийг хойч үедээ зориулан бичиж авч байгаагүй явдал юм. Түүнийг нас барсны дараа аав, авга ах нар маань эмээ хэрхэн өөрийгөө үнэлдэггүй байсныг, бүр нэг удаа “Миний тухай хэн мэдэхийг хүсэх вэ дээ?” гэж хэлж байсныг нь надад ярьдаг байв.

Санхүүгийн хүндрэлээс болж манай гэр бүл эмээгийн хуучин байшинд нүүж очиход надад аз жаргалаар дүүрэн дурсамжаас гадна харамсах сэтгэл төрж билээ. Нүүж ирээд хэд хоносны дараа нэгэн шөнө би эмээгийнхээ зургийн хэдэн хуучин цомог, бэлэг дурсгалын хайрцгийг үзсэн юм. Тэнд авга ахын бичсэн хуучирсан захидлууд, ариун сүмийн хуучин эрхийн бичгүүд, бүр өвөөгийн оршуулгын хөтөлбөр хүртэл байв. Эдгээр дурсгалтай зүйлийг харсныхаа дараа надад өөр зүйл байгаа болов уу гэсэн бодол төрлөө.

Надад дээврийн өрөөнд орж үзэх хэрэгтэй гэсэн мэдрэмж төрж, би тэр даруй удахгүй хаягдах байх гэмээр нэгэн хуучин цэнхэр хавтастай савруу дөхөж очлоо. Тэр хавтсан дотроос би эмээгийнхээ 30 жилийн өмнөөс бичиж эхэлсэн амьдралынх нь түүхийг олж мэдсэн юм. Дараа нь би гэрийнхнээс маань хэн нь ч үүний тухай мэддэггүй байсныг олж мэдээд ихэд гайхав. Аав, авга ах нарын хэлсэн зүйл үнэн байлаа. Эмээ минь амьдралынхаа түүхийг бичиж эхэлснээ хүртэл хэнд ч хэлж зүрхлээгүй, үнэхээр өөрийгөө үнэлдэггүй хүн байж!

Би тэр орой энэ найман хуудсан дээрх бүх үгийг нэг бүрчлэн уншиж байхдаа түүний амьдрал ахлах сургуульд байхад нь ямар байсныг, тэр

өвөөтэй хэрхэн танилцсаныг мөн өвөөтэй хамт ажиллуудаг байсан кино театрынхаа үүдийг барих түүнд хэчнээн хүнд байсан гээд эмээгийнхээ талаар ихийг мэдэж авсан юм.

Эдгээр хуудсыг уншиж байхад тэрээр миний хажууд зогсоод, өөрийнх нь амнаас түүхийг нь сонсож чадаагүйдээ дахин харамсах хэрэггүй гэж надад хэлэх шиг санагдсан. Эмээгийнхээ амьдралыг өөрийнх нь гараар бичсэн үгсээс унших нь үнэхээр үнэлж баршгүй зүйл байсан бөгөөд удаан хугацаанд мэдэрч байсан харамсах сэтгэлийг багасгасан билээ. Энэ нь Их Эзэний нигүүлсэнгүй сэтгэлийн баталгаа байсан бөгөөд гэр бүлийн түүх нь зөвхөн энэ амьдралдаа таньж мэдэх

боломжгүй өвөг дээдсийнхээ тухай олж мэдэх явдал биш юм гэдгийг гэрчилсэн. Түүнээс гадна гэр бүлийн түүхээс бидний хайрлан хүндэлдэг болон энэ дэлхий дээр байхдаа үнэлэхийн аргагүй цаг мөчийг хамтдаа өнгөрүүлсэн дотны хүмүүсийнхээ тухай илүү ихийг олж мэддэг юм.

Намайг гэр бүлийнхээ бусад гишүүнтэй тэдний түүхийг бичихээр хамт суух үед тэд надаас яагаад хэн нэгэн бидний тухай мэдэхийг хүснэ гэж хэмээн асуудаг. Би тэдний түүх үнэ цэнтэй гэдгийг мөн үнэлж баршгүй түүхээ үлдээсэнд нь эмээдээ талархаж явдгийн адил тэдний хойч үе ч гэсэн талархах болно гэдгийг батлан хэлдэг. ■

Риүбэн Вандсворт, АНУ, Юта



ДЭЛХИЙН НӨГӨӨ ХЯЗГААРТ БАЙРЛАХ АРИУН СҮМ

Би насанд хүрснийхээ дараахан гэр бүлийнхэн маань эсэргүүцэж байсан ч Сүмд нэгдэн орсон билээ. Би аавыгаа өөд болсны дараа, хориод настай байхдаа гэр бүлийн түүх дээрээ ажиллаж эхэлсэн. Удалгүй би бага насны хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлж, завгүй эхнэр, ээж болсон бөгөөд гэр бүлийн түүхийн ажил ч зогссон юм.

Манай гэр бүлд Сүмийн гишүүн байгаагүй учраас надад гэр бүлийн түүхээ судлах маш их хүсэл эрмэлзэл байдаг байв. Би энэ ажилд дуртай байсан бөгөөд үүн дээр ажилаахад илүү их цаг зав гаргахыг үргэлж хүсдэг байлаа.

Намайг 33 настайд биеийн эрүүл мэнд минь муудаж эхлэх

үед амьдрал орвонгоороо эргэв. Гэрийнхэнтэйгээ явган аялдаг байсан надад байшин тойрч алхах хүртэл хэцүү болж билээ. Бямба гарагт хоёр цагийн дотор гэр орноо цэвэрлэдэг байсан нь боломжгүй болж, тоосоо соруулж л чадвал баярлах болов. Өмнө нь найзын хүрээлэл ихтэй байсан бол одоо өмнөх шигээ тэдэнтэй хамт байж чадахгүй болсон учир найз нөхдийн хүрээ хүртэл багасав.

Яг энэ үед би гэр бүлийн түүхийн ажлаа дахин хийж эхэлсэн юм. Охин минь аавынхаа талын судалгааг хийж эхэлсэн бөгөөд надад хийхэд олон жил шаардсан ажлыг ганцхан орой дуусгав. Би өөрийн талын хэд хэдэн үеийг

хийж дуусган, нэрсийг ёслолын ажил хийлгэхээр ариун сүм рүү илгээв. Би гэр бүлийн гишүүдтэйгээ хамт ариун сүм рүү явахыг үргэлж хүсдэг байсан ч эрүүл мэндээс болон ариун сүм хол байдгаас боломжгүй байлаа.

Би нэрсийг илгээснийхээ дараа гэр бүлийн гишүүдтэйгээ ёслол хийлгэх онцгой өдөр нь хамт байж чадаагүйдээ тэднийхээ итгэлийг хөсөрдүүлсэн мэт санагдан, уйлж эхлэв. Долоо хоногийн дараа би ариун сүмийн ажлын явцаа шалгахаар FamilySearch.org вэбсайт руу орохдоо нэгэн гайхалтай зүйлийг олж харсан юм. Ажил хийгдээд зогсохгүй, Ганын Аккра ариун сүмийн гишүүд энэ ажлыг хийж байв! Дэлхийн нөгөө өнцөгт байгаа гишүүд миний жижигхэн гэр бүлийн ариун сүмийн ажлыг хийж байгааг хараад би их гайхаж билээ. Ганын хүмүүсийн миний гэр бүлийн төлөө ариун сүмд очин гаргасан золиослолын тухай бодоод би дахин нулимс унагав. Ариун сүмд орж, гэр бүлд минь ариун сүмийн ёслолын адислалыг хүлээн авах боломжийг олгон, миний хийж чадаагүй зүйлийг хийсэн Ганын Аккра ариун сүмийн дүүргийн тэдгээр гишүүнд би талархаж байгаа билээ. ■

Робэн Эстабрүкс, АНУ, Виржиниа

Надад дээврийн өрөөнд орж үзэх хэрэгтэй гэсэн мэдрэмж төрж, би тэр даруй удахгүй хаягдах байх гэмээр нэгэн хуучин цэнхэр хавтастай сав руу дөхөж очлоо.



ГЭРТЭЭ ХУГАЦААНААДСАА ӨМНӨ ЭРГЭЖ ИРСЭН АСУУДЛАА ШИЙДЭХ НЬ

Жэнни Роллинс

Аав томилолтоор явсан байсан тул намайг онгоцноос доголсоор бууж ирэхэд ээжээс өөр хэн ч тосоогүй юм. Ээж намайг тэврэн, бид хамтдаа уйлав.

Би эрүүл мэндийн олон шинжилгээ хийлгэсэн боловч эмч нар ямар ч асуудал олж илрүүлээгүй. Номлогчийн нэрийн тэмдгээ хугацаанаасаа есөн сарын өмнө авсан нь миний амьдралдаа хийж байсан хамгийн хэцүү зүйл байлаа. Би номлолоо дуусгаж чадаагүй учраас өөрийгөө бүтэлгүй хүн гэж бодох болов.

Номлогч байх утга учир

Би номлогч болохыг үргэлж төлөвлөдөг байсан. Ахыгаа номлолд гарахад нь би гараараа хийсэн номлогчийн нэрийн тэмдгээ зүүж, түүнийг гаргаж өгч байлаа. 2012 онд номлогчийн нас өөрчлөгдсөнийг зарлах үед би дөнгөж 19 нас хүрсэн байсан бөгөөд тэр зарлал миний залбирлын хариулт байсан гэдгийг мэдэж байв. Би өрөөндөө бүжиглэн, тэр өдөртөө номлолынхоо маягыг бөглөж, эрүүл мэндийн үзлэгт орох цаг авч, долоо хоногийн дотор номлолын бичиг баримтаа явуулсан

Эрүүл мэндийн шалтгаанаар номлолын хугацаагаа дуусгалгүй буух нь сэтгэл гонсойлгосон явдал байж болох юм. Миний хувьд тийм л байсан. Гэхдээ та үүнийг ухрах биш, харин урагшлах алхам болгон хувиргаж чадна.

билээ. Хоёр долоо хоногийн дараа би Калифорнийн Анахайм Номлолд үйлчлэх дуудлагаа хүлээн авч, хоёр сарын дараа номлогчийг бэлтгэх төвд очсон.

Би номлолын талбарт ирэхдээ “шинэ номлогчийн” эрч хүчээр дүүрэн байсан бөгөөд хэзээ ч хурдаа сааруулахгүй гэж төлөвлөж байлаа. Сургагч бид хоёр заахдаа маш их баярладаг байсан учраас заримдаа хичээл рүүгээ гүйдэг байсан юм. Миний хувьд бүрэн цагийн номлогч байх нь усанд сэлж байгаа загас адил энгийн зүйл байв. Заримдаа

хүнд хэцүү байсан ч миний хувьд номлогч байхаас илүү гайхалтай зүйл гэж байсангүй.

Номлолдоо ирээд найман сар орчим болж байтал автомашин хүрэлцэхгүй болсон тул хамтрагч бид хоёрт дугуй өгөв. Би дугуй унаагүй их удсан бөгөөд яаж юбкайтай дугуй унахаа сайн мэдэхгүй байсан ч баяртай байлаа. Хэдэн долоо хоногийн дараа миний хажуу талд үе үе өвддөг болж эхлэв. Би тоолгүй, ажилласаар байсан.

Өвчин даамжирсаар улам бүр ойр ойрхон хүчтэй өвддөг болж, нэгэн орой хамтрагч минь намайг яаралтай тусламжийн өрөөнд хүргэв. Би эрүүл мэндийн олон шинжилгээ өгсөн ч эмч нар миний өвчний шалтгааныг тогтоож чадсангүй.

Дараагийн долоо хоногуудад би өвчнөөс салгаж өгөхийг Тэнгэрлэг Эцэгээс залбиран гүйж, хэд хэдэн удаа санваарын адислал хүлээн авсан ч өвчин улам хүндэрсээр, яаж ч эвтэйхэн хөдөлсөн өвдсөөр л байлаа. Гэвч би үүнд дасан зохицохыг хичээн, үргэлжлүүлэн ажилласаар байв.





Нэг өдөр би замын хажуу тал руу муужран унаж, хөдөлж ч чадахгүй болов. Намайг эмнэлэгт хүргэж, шинжилгээ хийсэн ч дахин ямар ч өвчин илэрсэнгүй. Би хөдөлгөөнөө багасгаж, хамтрагчтайгаа автобусны буудлын сандал дээр сууж, хүмүүст автобусаа хүлээж байх хооронд нь заахыг хичээж байлаа. Хичээл заах үед өвдвөл амаа жимийн суудаг байв. Эцэст нь өөрийгөө дэндүү их хүчилснээс дахиад л эмнэлэгт хүргэгдсэн юм. Номлолдоо үлдвэл би өөрийгөө бүрмөсөн үгүй хийх юм байна гэдгээ ухаарав. Ихэд залбирсны эцэст би эрүүл мэндийн асуудлаа шийдвэрлэхийн тулд гэртээ харих нь зүйтэй гэсэн хариулт хүлээн авлаа.

Урагшлах алхам

Гэртээ бүрмөсөн ирсэн гэдгээ ухаарах нь миний хувьд сэтгэл зүйн хүнд цохилт болсон юм. Гэсэн хэдий ч би итгэлээр тордож, судар судлахын тулд хамгийн сайнаараа хичээж байлаа. Манай гэрийнхэн энэ бүхнийг хүндээр тусгаж аваагүй ч эргэн тойрны хүмүүс миний нөхцөл байдалд хэрхэн хандахыг сайн мэдэхгүй байв. Тэд надаас юу болсныг асууж шалгаасаар байсан бөгөөд заримдаа надад сэтгэлийн хөдөлгөөнөө барихад хэцүү байлаа. Гэтэл нэг хүн над руу санаандгүй утасдаж, түүний хүү олон жилийн өмнө номлолоосоо хугацаанаасаа өмнө бууж, гэртээ ирсэн гэж хэлэв. Тэрээр энэ сорилт миний итгэл, аз жаргалыг үгүй хийж болзошгүй бөгөөд хугацаанаасаа өмнө эргэж ирсэн олон номлогчид ийм зүйл тохиолдсон гэдгийг надад хэлж



Та зөв шударга амьдрахын тулд хичээж л байвал үргэлж нэг алхам урагшилж байна гэсэн үг.

билээ. Тэр надад, “Чи зөв шударга амьдрахыг хичээж л байвал юу ч болж байсан үргэлж нэг алхам урагшилна гэдгээ санаж байгаарай” гэж хэлсэн юм.

Энэ үг миний уриа болсон бөгөөд дараа жил нь үүн дээр ихэд төвлөрөн ажилласан билээ. Найман сарын турш би бараг алхаж чадахгүй байсан ч гэртээ хугацаанаасаа өмнө эргэж ирснийг хүмүүс олж мэдээд, намайг шүүсэн хэвээр л байлаа. Тэд эрүүл мэндээрээ надаас муу байсан ч гэсэн номлолоо хийж дуусгасан олон хүн байдаг гэж хэлж байв. Тэд намайг эрүүл мэндийн асуудалтай байсан ч яагаад номлолоо дуусгаж чадаагүй гэдгийг ойлгохгүй байлаа. Би номлолдоо их хайртай байсан тул ийм зүйл сонсох нь хэцүү байсан ч Тэнгэрлэг Эцэг ямар нэгэн зорилгоор ийнхүү зовоож байгаа, энэ нь намайг нэг шат урагшлуулна гэдэгт итгэж байсан юм.

Би сургуульдаа дахин явж, бас болзож эхлэв. Би өөрийнхөө өсөж хөгжиж байгааг харж байсан ч номлол маань гашуун дурсамжтай л байх

нь дээ гэж үргэлж бодогддог байлаа. Тэр үед найз маань надад Аврагчийн Цагаатгал бүх өвчин, хорслыг анагаах чадна гэдгийг сануулсан билээ. Түүний тусалцаатайгаар би номлолынхоо талаар баяр хөөртэй дурсах боломжтой байв.

Би өвдөг сөгдөн, Тэнгэрлэг Эцэгтээ залбирсан. Би өөрийн өвчин зовлон, эдгэрч тайтгарахын тулд гаргаж байгаа хичээл зүтгэлээ хэлж, миний мэдэрч буй хорсол гашуудлыг авч хаяхыг гуйсан юм. Залбирсны дараа Их Эзэн нүдийг минь нээж, надад номлолыг маань Өөрийнхөө нүдээр харуулсан билээ. Миний үйлчлэл, хугацаанаасаа өмнө эргэж ирсэн зэрэг нь Их Эзэний хүсэж буй хүн болоход туслах Түүний төлөвлөгөөний нэг хэсэг байсан. Намайг гэртээ ирснээс хойш Түүний өгсөн гайхамшгуудыг би олж харж чадсан. Энэ нь хэцүү зам байсан ч Бурхан надад хамгийн сайн сайхныг хүсдэг гэдгийг мэдэх учраас би гэртээ хугацаанаасаа өмнө эргэж ирснээ сэтгэл амар дурсаж чаддаг болсон юм.

ЭРГЭЖ ИРСЭН НОМЛОГЧДОД ЗОРИУЛСАН, ГЭРТЭЭ ХУГАЦААНААСАА ӨМНӨ ЭРГЭЖ ИРСЭН АСУУДЛАА ШИЙДЭХ ЗУРГААН АРГА ЗАМ

Гэртээ эргэж ирэх нь хэцүү ч та хичээснээрээ үүнийг нэр төртэй, ач тустай урагшлах алхам болгох боломжтой. Надад тусалсан зүйлсийг доор дурдав. Үүнд:

Христэд ирэгтүн. Юунаас болж гэртээ ирснээс үл хамааран Христ танд уг асуудлаа шийдвэрлэхэд тусалж чадна. Түүний Цагаатгал зөвхөн наманчлахад зориулагдаагүй бөгөөд тайтгарах, ойлгох, эдгэрэхэд зориулагдсан билээ.

Энэ нь урагшлах алхам болж болно гэдгийг сана. Та Сүнснийг хүлээн авахуйц зохистой амьдарч, хамгийн сайн байхыг хичээхийн хэрээр саад тотгор мэт санагдаж байгаа зүйл ч гэсэн өсөж хөгжих суурь болон хувирах боломжтой.

Судар унших дадал хэвшлээ хадгалан үлд. Бурхан бусад ямар ч зүйлээс илүү ихээр судрыг чин сэтгэлээсээ судалж, тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхэд олон арга замаар Ариун Сүнсээр дамжуулан ярьдаг. Бурхан зөвхөн танд амар амгаланг өгөхийн тулд бүтэн бүлгүүдийг зориулан бичсэн байдгийг та олж мэдэж болно.

Завгүй бай. Дэг журамтай, завгүй номлогчийн амьдралын хэв маягаас юу ч хийхгүй хэв маяг руу шилжих нь Сатаны хүсдэг зүйл болох сэтгэл санаагаар унах, дутуу дулимаг гэдгээ мэдрэх, гуныж гутрах цаг зав их байна гэсэн үг. Бурхан таныг сайн үйлсэд “санаа сэтгэлээ бүрэн зориулахыг”

(С ба Г 58:27-ыг үзнэ үү) хүсдэг. Учир нь энэ нь аз жаргалтай болоход туслах зүйл юм.

Тусламж гуйн залбир. Тэнгэрлэг Эцэг тайтгарал, удирдамжийн адислалыг танд өгөхөөр хүлээж байгаа. Таны хийх ёстой зүйл бол зөвхөн гуйх юм. Аливаа зовлон зүдгүүрийг даван туулахад Их Эзэний тусламж хэрэгтэй.

Хүмүүс сайн санаж байгаа гэдэгт бүү эргэлз. Танд үнэхээр анхаарал халамж тавьдаг ч таны нөхцөл байдалд хэрхэн хандахаа мэдэхгүй байгаа хүмүүст гомдох шалтгаан олох амархан. Таныг дэмжиж байгаа хүмүүст анхаарлаа төвлөрүүлж, шүүмжилж буй хүмүүсийг уучил.

ХАЙРТАЙ ХҮМҮҮСТ НЬ ЗОРИУЛСАН, ГЭРТЭЭ ХУГАЦААНААСАА ӨМНӨ ЭРГЭН ИРСЭН НОМЛОГЧДОД ТУСЛАХ ТАВАН АРГА ЗАМ

Намайг гэртээ ирэхэд хүмүүс надад хэрхэн хандахаа сайн мэдэхгүй байгааг би олж мэдсэн. Хүмүүс мэддэг ч байсан болоосой гэж бодогдсон зарим зөвлөгөөг доор дурдав.

Бүү шүү. Гэртээ хугацаанаасаа өмнө эргэн ирж байгаа хүмүүс бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлын эсвэл гэр бүлийнхээ ямар нэгэн зүйлийг анагаах, шийдвэрлэх үйл явцдаа явж байдаг. Хичээж, тэмцэж байгаа тэр хүмүүст сайхан сэтгэлээр ханд.

Асууж шалгаахаа боль. Хүмүүст анхаарал халамж тавих нь сайн ч гэсэн, асууж шалгаах нь хор учруулж болзошгүй. Та сайн санаа агуулж байсан ч гэлээ, хугацаанаасаа өмнө ирсэн номлогчийг битгий байцааж шалгаа. Хайраа өөр арга замаар үзүүл.

Тэдэнд завгүй байхад нь тусал. Номлолын дэг журамтай үйл ажиллагаанаас сул чөлөөтэй цаг, гэр орон дахь шинэ сонголт руу шилжин орж, дасан зохицоход хэцүү байж болно. Тэдэнд үр бүтээлтэй, хөгжилтэй, сайн сайхан зүйлсийг олж хийхэд тусал.

Өөрсдийн гэсэн илчлэлт хүлээн авахад тусал. Номлолдоо буцаж

явах уу, үгүй юу гэсэн сонголт тэдний болон Тэнгэрлэг Эцэгийн хооронд шийдэгдэх асуудал юм. Тэднийг Тэнгэрлэг зөвлөгөөг эрэлхийлэхэд урамшуулан дэмжиж, өөрсдийн гэсэн хариултыг хүлээн авна гэдэгт итгэж найд.

Найз нь бай. Ихэнхдээ энэ нь хугацаанаасаа өмнө эргэж ирсэн номлогчийн амьдралд тохиолдох хамгийн хэцүү сорилт бэрхшээлийн нэг байх болно. Тэдний олонхын итгэл хүнд сорилтод орсон байна. Энэ нь тэд аз жаргалтай байж, өсөн хөгжих боломжгүй гэсэн үг биш бөгөөд харин тэдэнд юу ч болж байсан хайрлаж чадах найз нөхөд хэрэгтэй. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.



Фрэнцад

ХҮЧТЭЙ ХЭВЭЭР ҮЛДЭХ НЬ

Минди Анне Сэлү

Сүмийн сэтгүүл

Нисдэг тэрэгний нисгэгч болохоор суралцах нь олон хүнд олддоод байдаг боломж биш юм. Харин 24 настай О.Пьерт Францын армид элсэхэд нь ийм боломж олджээ. Дөрвөн жилийн сургалтынхаа хоёр дахь жилд суралцаж буй Пьер байгаа орчноосоо үл хамааран итгэгчдийн үлгэр жишээ болж амьдрахын тулд хамгийн сайнаараа хичээж байгаа юм.

Францын баруун өмнөд хэсэг дэх Бордогоос цаг гучин минутын зайд байрлаж байгаа Пьер найз нөхөд, гэр бүл, төрөлх хот Рэннэсээс алс хол байгаа аж. Хамгийн ойр байрлах цуглааны байр нэг цагийн зайд байдаг бөгөөд энэ нь тэрээр долоо хоногийн турш гишүүдтэй харилцаж чаддаггүй гэсэн үг юм. Пьер “Армид Сүмийн гишүүн байна гэдэг амаргүй зүйл. Энд уруу татагдах зүйл их байдаг. Үнэндээ хоёр тэс өөр ертөнцөд л байдаг гэсэн үг. Армид хүнийг хэн гэдгээр нь биш харин хийж байгаа зүйлээр нь шүүдэг” гэж хэлэв. Пьер эргэн тойрных нь хүмүүс түүнийг армид хэвийн үзэгдэл болсон архи

уух, тамхи татах, порнограф үзэх эсвэл үдэшлэгт оролцох гэх мэт үйл ажиллагаанд өөрийн хэн болохоос шалтгаалан, Сүмийн гишүүн учраас оролцдоггүй гэдгийг олж хараасай гэж хүсдэг. Эргэн тойрныхоо хүмүүсийн хүндлэлийг олж авах нь хэцүү ч залбирч, судраас судлах нь гэрчлэлээ хүчтэй хэвээр авч үлдэхэд тусалдаг юм. “Эхлээд би аль болох судраа уншилгүй унтахгүй байхыг хичээдэг бөгөөд боломж олдох бүрд залбирахыг хичээдэг.

Сургуульд байхад судраас уншиж, залбирах нь надад сайн мэдээний бусад хэсгийг сайн ойлгохгүй байсан ч Бурхан байдаг, Тэр үнэхээр оршдог гэдгийг мэдэж авахад тусалсан. Бурхан байдаг учраас л намайг зөв зам дээрээ үлдэхэд тусалсан гэдгийг би мэддэг” гэж Пьер тайлбарлав.

Судар судлах үндэс суурь нь Пьерийг сургуульд сурч байхад нь ч, армийн сургалтад хамрагдаж буй энэ үед ч гэсэн дэмжиж байгаа билээ. Пьер армид элсэхээсээ өмнө Канадын Квебек Монреаль номлолд үйлчилсэн бөгөөд тэнд сайн

Францын армид буй Сүмийн гишүүн Пьер итгэлийнхээ үлгэр жишээ байхын тулд залбирах, судар судлахад тулгуурладаг.

мэдээний талаарх гэрчлэл, ойлголт нь бэхэжсэн аж.

“Судрууд нь Тэнгэрлэг Эцэгийн бидэнд хариулдаг хамгийн бодит арга замын нэг юм” хэмээн тэр хэлэв.

Пьер өдөр бүр залбирч, судраас судалснаар зөвхөн сүнслэг удирдамж хүлээн аваад зогсохгүй ангийнхаа цэргүүдэд үлгэр жишээ болох боломжтой болсон. Пьерт ангийнхантайгаа үндэсний бахархалаас өөр нийтлэг зүйл байхгүй байж болох ч тэрээр судар дээрх сургаалыг дагаснаар өөрийнх нь итгэл үнэмшлээс үл хамааран тэдний хүндлэлийг хүлээсэн хүн болж чадна гэдгээ мэддэг. ■

ПЬЕРИЙН ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Та юу идэх дуртай вэ?

Би бреттон галетт (Баруун Францын вафлитай төстэй хоол) идэх дуртай. Би бас талх, бяслаг, зайдас, патэд дуртай.

Та чөлөөт цагаараа юу хийдэг вэ?

Би найзуудтайгаа гадуур явах дуртай. Заримдаа бид зүгээр гадагшаа гарч, хоол идэж бас ярилцдаг. Би эхнэртэйгээ дэлгүүр явах эсвэл кино үзэх дуртай. Би бас юм уншиж, спортоор хичээллэх дуртай. Ялангуяа гүйх, усанд сэлэх дуртай.

Францад хүмүүс хэрхэн болздог вэ?

Болзох гэж байгаа охин маань Америкийн Нэгдсэн Улсад хүмүүс хэрхэн болздогийг мэдэхгүй бол бие биеэ таньж мэдэх, зүгээр л найзууд болох зорилгоор хамт гадуур явбал их хэцүү байдаг. Сүмийн удирдагчид ганц бие залуучуудын олон үйл ажиллагаа зохион байгуулахыг хичээдэг бөгөөд хүмүүст танилцаж, томоохон бүлгээр болзох боломжийг олгодог. Эхнэр бид хоёр ийм замаар танилцсан.

ФРАНЦ ДАХЬ СҮМ

37812 хожмын үеийн гэгээнтэн

107 тойрог, салбар

67 гэр бүлийн түүхийн төв

2 номлол

1 ариун сүм (барилгын ажил хийгдэж байгаа)

ФРАНЦЫН ТУХАЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

66 сая хүнтэй (2015 оны байдлаар)

40000 орд харштай (дундад зууны

үеийн орд харш, эдлэн газар, ордон)

Жилд 80 сая жуулчин ирдэг бөгөөд

дэлхий дээрх хамгийн их хүн очиж

үздэг орон юм.





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ахлагч
**Ахлагч Роналд
А.Расбанд**

АРИУН СҮМИЙН АДИСЛАЛААС ХЭРХЭН ХҮРТЭХ ВЭ?

Ариун сүм бол Их Эзэний өргөө бөгөөд тэнд Аврагчийн сургаалыг нас барагсдын төлөө хийх баптисм, гэрлэлт зэрэг гэр бүлийг мөнхөд холбодог ариун нандин ёслолоор дамжуулан дахин баталж өгдөг.

Та нар амьдралынхаа бат бөх суурийг тавьж байхдаа мөн хувь хүний болон гэр бүлийнхээ хувьд анхаарал төвлөрүүлэх хэрэгтэй зүйлсээ бодож үзэхдээ ариун сүмийн шүтлэг бишрэл нь хүн бүрийн хүлээн авах ёстой чухал загвар гэдгийг хэлэх гэсэн юм. Та нарын ихэнх нь үүнийг аль хэдийн хийсэн гэдгийг би мэдэж байгаа бөгөөд хийсний тань төлөө та нарт маш их талархаж байгаагаа хэлэх гэсэн юм.

Тэргүүн Зөвлөл “Сүмийн гишүүдийг цаг зав, боломж гарвал **чөлөөт цагаараа хийдэг зарим үйл ажиллагаагаа ариун сүмийн үйлчлэлээр орлуулахад урамшуулан дэмжиж байна**” гэсэн урилгыг Сүмийн бүх гишүүнд хандан гаргасан бөгөөд энэ нь надад ч, та нарт ч хамаатай.

Түүнчлэн бид ариун сүмд тууштай орсноор бошиглогч, үзмэрч, илчлэгчдийн **амласан адислалын тухай бодож үздэг байх** болтугай. Ерөнхийлөгч Томас С.Монсон:

“Ариун сүмд ирж, ачаа дарамтаа Их Эзэний өмнө тавь, ингэснээрээ та шинэ сүнс болон ирээдүйдээ итгэх итгэлээр дүүргэгдэх болно. Их Эзэнд итгэ, хэрэв та итгэж чадвал Тэр таныг тэврэн, өлгийдөж, Бурханы селестиел хаант улс руу хөтлөх замаар алхам алхмаар удирдан залах болно” хэмээх амлалтыг өгсөн.¹

Ариун сүмийн шүтлэг бишрэлийн өөр нэгэн тайтгаруулах адислал бол өнөө үед бидний дээр нүүрлэж байгаа шуурганаас халхлах хамгаалалт, амар амгалангийн баталгаа юм. Тэнгэрлэг Эцэгийн хүмүүсээ цуглуулахаар бэлдсэн хамгийн аюулгүй газруудын нэг нь Их Эзэний ариун сүм дотор байдаг.

Бүх ариун сүмийн гадна талд “Их Эзэнд зориулсан ариун газар / Их Эзэний өргөө” гэж бичсэн нэгэн тунхаг байдаг. Их Эзэний бүх ариун сүм дэлхий дээрх Түүний ариун газар гэдгийг би гэрчилж байна. Би та бүхнийг боломж гарах бүрд **илүү ойр ойрхон орж, Бурханы бошиглогчдоор амлагдсан адислал, хамгаалалтаас хүртэхэд** урьж байна. ■

2009 оны 2-р сарын 10-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн үгээс Англи хэл дээрх бүрэн эхийг үзэх бол speeches.byu.edu хаягаар орно уу.



ТА ҮҮНИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН БЭ?

Ариун Сүм бол Их Эзэний өргөө гэдгийг миний оюун санаанд гүн гүнзгий суулгаж өгсөн нэг зүйл бол ариун сүм рүү явах тоолонд мэдэрдэг тэрхүү амар амгалан юм. Манайх цэргийн албан хаагчийн гэр бүл байсан болохоор би дэлхийн хэд хэдэн ариун сүмд очиж үзсэн бөгөөд амар амгалан, тайтгарал, Сүнсний мэдрэмж нь яг адилхан байсан. Ариун сүмээс ирдэг амар амгалан нь надад энэ амьдралд гүйцэтгэх үүргээ болон хэрхэн өөрийгөө илүү сайжруулахыг бүрэн ойлгоход тусалсан юм. Энэ нь өдөр тутмын амьдрал дахь дарамтаа шийдвэрлэх чадварыг маань өсгөн нэмэгдүүлсэн.

Жэнэсий В., АНУ, Юта

ЭШЛЭЛ

1. Dell Van Orden дээрх Томас С.Монсоны “San Diego Temple: 45th House of the Lord Dedicated in ‘Season for Temple Building’” хэлсэн үгээс эш татав, *Church News*, 1993 оны 5-р сарын 8, 12.

НҮДЭЭ ОЛСОН ХАРИУЛТ

**Бурхан яагаад бидэнд
ийм эрт, гэрлэх
тохиромжтой
нас болоогүй
байхад романтик
мэдрэмж өгдөг вэ?**

Сэтгэл татагдах нь мэдээж муу зүйл биш бөгөөд эцсийн дүндээ гэрлэлтийн тэнгэрлэг зорилго руу хөтөлдөг. Харин яагаад бидэнд энэ мэдрэмж олон жилийн өмнө, зохистой ашиглах болоогүй байхад өгөгддөг вэ?

Тэгэхээр энэ амьдрал дуулгавартай байдлын сорилтын үе бөгөөд ариун явдлын хууль бол дуулгавартай дагах ёстой хамгийн чухал хуулийн нэг юм. Энэ сорилт нь бэлгийн бойжилт явагдаж эхэлсний дараа, дааврууд (мөн бүхнийг зөвшөөрөгч соёл) бидэнд “Хий, хий, хий” гэж байхад, Христийн гэрэл болон Ариун Сүнс (судар, бошиглогч, эцэг эх, удирдагчид) “Хүлээ, хүлээ, хүлээ” гэх үед илүү хүнд болдог билээ. Бид сүүлийн захиасыг анхааран сонссоноор, зохистой байдлаа баталж, өсөж том болсон, ёс суртахууны сахилга баттай байдлаа харуулж байгаа бөгөөд энэ нь “хэцүү байсан ч зөв учраас зөвийг сонгох эрхээ үргэлжлүүлэн ашиглаж байгаа хэрэг юм” (Д.Тодд Кристоффэрсон, “Ёс суртахууны сахилга,” 2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 120).

Амьдралын олон сорилтын адил энэ сорилт нь бидэнд өөрсдөдөө ирээдүйд ирэх, тухайлбал ариун сүмд үүрд мөнхөд лацдан холбогдох адислалаас хүртэх зохистой гэдгээ батлах боломжийг олгодог. ■



**Яагаад Христийн үед
тохиолдож байсан гайхамшгууд
өнөө үед тохиолддоггүй вэ?**

Аврагчийн гайхамшгууд “тэнгэрлэг үйлдэл” бөгөөд “тэнгэрлэг сургаалын нэг хэсэг” (Bible Dictionary, “Miracles”) байсан юм. Эдгээх болон бусад гайхамшиг одоо ч Сүмд тохиолдсоор байдаг ч эдгээр нь үргэлж нүдэнд тусахуйц байдаггүй бөгөөд гайхамшигийг хүлээн авсан хүмүүс үүнийг ариун нандин гэж үздэг учраас олон нийтэд үргэлж яриад байдаггүй. Та гайхамшгуудыг өөрийнхөө болон гэр бүлийн гишүүд, өвөг дээдсийнхээ амьдралаас хайж болох юм. Хэдийгээр бид гайхамшигийг хүсдэг ч Тэнгэрлэг Эцэг Өөрийн цаг хугацаанд, Өөрийн арга замаар хариулдаг гэдгийг санах хэрэгтэй.

Гайхамшгууд Есүс Христийн сайн мэдээний нэг хэсэг мөн. Гайхамшиг нь дэлхий дээр итгэл байдгийн тэмдэг бөгөөд (Ифер 12:12-ыг үзнэ үү) Сүнсний бэлэг юм (С ба Г 46:21-ийг үзнэ үү). ■

Үе тэнгийнхний шахалт ба писто

Эцэст нь би бүх найзтайгаа үдэшлэг дээр
хамт байсан бөгөөд хүн бүр ууж байв.





САЙН НАЙЗУУД ЧУХАЛ

“Хамгийн чухалд тооцдог зүйлс нь, бүр мөнхийн зорилгууд нь таныхтай адил тийм хүмүүстэй нийл.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Decisions Determine Destiny” (Brigham Young University devotional, Nov. 6, 2005), 4, speeches.byu.edu.

Киара Бланко

Намайг 12 настай байхад шинэ сургуулийн маань зарим охид төрсөн өдрийн үдэшлэгт урив. Энэ бол намайг урьсан мөн сургуулийнхаа найзуудтай явсан анхны үдэшлэг байлаа. Эцэг эхээсээ явах зөвшөөрөл хүсэхэд тэд үдэшлэг хэтэрхий орой эхэлж байгаа учир зөвшөөрсөнгүй.

Хэсэг хугацааны дараа би бас нэг урилга хүлээн авлаа. Эцэг эхээсээ дахин асуутал тэд бас л зөвшөөрсөнгүй тул би галзууртлаа уурлав. Би хөгжилтэй байж болохгүй гэж үү?

Дараа нь нэгэн дотны найз минь үдэшлэг зохиохоор төлөвлөв. Тэр намайг хамгийн түрүүнд урьсан юм. Тэр үдэшлэг бусдаасаа арай эрт эхлэх байв. Энэ албан бус үдэшлэг байсан бөгөөд манай гэрийн ойролцоо зохиогдсон юм. Намайг эцэг эхээсээ явах зөвшөөрөл гуйхад тэд зөвшөөрөв! Би маш их баяртай байлаа.

Тэр өдөр ч боллоо. Аав, ээж 2 маань намайг тэнд хүргэж өгөхдөө орой 22.00 цагт ирж авна гэж хэлэв. Би үдэшлэг рүү орж, найз охидоо олов. Би тэнд 20 минут болоход төрсөн өдрийн эзнийг олж хараагүй л байлаа.

Хэдэн минутын дараа нэг залуу эрэгтэй бидэн дээр ирж, “Биднийг *пистонд* хандивлах мөнгө авчирсан эсэхийг асуув.” Тэр надад “писто” гэдэг нь шар айраг болохыг

дохиогоор харуулав. Миний найз охид ч хүссэн мөнгийг нь өгөв. Би ямар ч мөнгө авчраагүй тул охидыг мөнгөө хураалгах үеэр тэднээс зайтай зогсохоор шийдлээ.

Эцэст нь төрсөн өдрийн эзэн охин нэг цагийн дараа ирэв. Би түүнд баяр хүргэж, хамт ярилцаж байх хооронд нэг том ачааны машин ирж, таван эрэгтэй бууж ирэн, хоёр авдар шар айраг буулгалаа. Хүн бүр шахалдан, шар айргаас авч эхлэв. Найз охид маань ч шар айраг авахаар явж, би шар айраг уухаар тэмцэлдэж байгаа залуучуудыг харсаар ганцаараа хоцорлоо.

Тэд эргэж ирээд, надад шар айраг уухыг санал болгов. Би “Үгүй ээ, баярлалаа” гэв. Тэд дахиад л намайг шахлаа. Би дахин үгүй гэв. Зүрх минь хурдан хурдан цохилж эхлэн, надад гол дүрд нь тоглож, гарах гарцгүй болж баригдсан аймшигийн кино шиг сонин мэдрэмж төрж байлаа. Дараа нь би машин сигналагдахыг сонсов. Аав, ээж хоёр минь байв! Би баяртай гэж хэлээд үдэшлэгээс гарч, машин руугаа гүйлээ.

Би амьсгаадсаар машиндаа суугаад, миний байсан орчин ямар аймшигтай байсныг бодож эхлэв. Ээж намайг зүгээр эсэхийг асуув. “Тийм ээ, гэхдээ би нэг зүйлийг их гайхлаа” гэхэд

“Чамайг юу гайхшируулав?” гэж аав асуув.

“Найзууд маань бүгд ууж байсан. Би ямар нэг сайхан юм болохыг хүлээгээд яахаа ч мэдэхгүй зогсож байсан. Би та хоёрыг ирээсэй гэж ямар их хүссэн гээч, тэгээд л гараад ирлээ” гэж би хэлэв. Би машины цагийг харахад 22.00 цаг арай болоогүй байв.

“Дэлхийн үдэшлэгүүд ийм л болдог юм. Ийм учраас бид чамайг өмнөх үдэшлэгүүдэд очихыг зөвшөөрөхгүй байсан юм шүү дээ” гэж ээж хэлэв.

Тэр орой би залбирахдаа эцэг эх минь эрт ирсэнд Тэнгэрлэг Эцэгтээ талархсан.

Сүмийн гишүүд бид дэлхий дээр байдаг ч дэлхийнх биш. Хэрэв би энэ үдэшлэгүүдэд оролцсоор байсан бол мэргэн ухааны үгийг, эцэстээ ариун явдлын хуулийг зөрчиж, унаж болох байснаа ойлгосон. Миний танилуудын олон нь үүнд бүдэрсэн, тэдний ихэнх нь Сүмийн гишүүд байгаагүй ч Сүмийн гишүүд ч гэсэн хэрэв тууштай байхгүй бол унахад хүрч болно.

Би уухгүй байх шийдвэр гаргасандаа баяртай байдаг. Би дараа нь шоолуулж магадгүй гэж бодож байсан ч найзууд маань миний жишгүүдийг мэддэг учраас намайг илүү хүндэлдэг болсон байв. Би үүний дараа намайг хордуулна гэж мэддэг зүйлдээ үгүй гэж хэлэхдээ айдаггүй болсон. ■

Энэ өгүүллийг бичигч Мексикийн Салтиллад амьдардаг.



ШИНЖЛЭХ УХААН

БОЛОН БИДНИЙ

ҮНЭНИЙ

ЭРЭЛ ХАЙГУУЛ



Хэрэв сайн мэдээний тухай ойлголт болон шинжлэх ухаанаар
гамжуулан мэдэж авсан зүйлс тань хоорондоо зөрчилдөж
байх шиг санагдвал та санаа зовох хэрэггүй.

Алисия К.Стантон

Таны арьсан дээр батга гарч арьсны эмч дээр очиход цусыг тань ханаж эмчлэх шаардлагатай гэж хэлж байна хэмээн та төсөөлж чадах уу? Энэ нь танд утгагүй мэт сонсогдож болох ч хоёр зууны өмнө амьдралаас хол зүйл байгаагүй юм. Тэр үед их хэмжээний цус ханах нь бараг ямар ч эрүүл мэндийн асуудалд, тэр дундаа ходоодны хямрал, галзуурал, бүр батганд хүртэл хэрэглэгддэг жишиг эмчилгээнд тооцогддог байв. Үүнд хэн ч эргэлздэггүй байв. Яалаа гэж эргэлзэх вэ дээ? Эцсийн эцэст цус ханах аргыг олон мянган жилийн турш өөр өөр олон соёл иргэншилд ашиглаж ирсэн байна.

Эмч нар анагаах ухааныг шинжлэх ухааны өнцгөөс харж эхлэхээс өмнө хүмүүс энэ арга барилд эргэлзэж байсангүй. Эцэст нь цус ханахыг илүү нарийн шинжлэн үзсэний дараа эмч нар тодорхой, цөөн тооны өвчнөөс бусад нөхцөлд ашиглахаа больсон юм.¹

Энэ түүхэн жишээнээс бид итгэл үнэмшил нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, удаан хугацааны турш оршин тогтносон учраас заавал үнэн байна гэсэн үг биш гэдгийг харж болно. Түүнээс гадна шинжлэх ухаан жинхэнэ үнэнийг ил гаргахад туслах гайхалтай хэрэгсэл болж чадна гэдгийг бид харж байна.

Хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд энэ бол том асуудал юм. Үнэнийг мэдэх нь бодит шийдвэр гаргахад (“Үгүй ээ, би өнөөдөр цусаа хануулахгүй, баярлалаа”) илүү сайн үндэслэл болоод зогсохгүй сайн мэдээний талаарх ойлголтод маань нэмэр болдог. Ерөнхийлөгч Бригам Янгийн (1801–1877) зааснаар “Сайн мэдээнд хамаардаггүй үнэн гэж үгүй. . . . Хэрэв та тэнгэрт [эсвэл] дэлхий дээр ямар нэгэн үнэнийг олбол . . . энэ нь манай сургаалд хамаатай гэсэн үг.”²

Яагаад, хэрхэн хоёрыг харьцуулж үзвэл

Мэдээж, бид шинжлэх ухаан бидний мэддэг үнэнд хэрхэн хувь нэмэр оруулдаг талаар ярихдаа ямар төрлийн үнэнийг шинжлэх ухаан нээн илрүүлж, ямыг нь нээн илрүүлж чадахгүйг ойлгодог байх ёстой. Үүнийг олж мэдэх нэг арга бол шинжлэх ухаан ямар төрлийн асуултад хариулж эсвэл хариулж чадахгүй гэдгийг асуух арга юм.

АНУ-ын Нью Йоркийн Ренсселиер Политехникийн Дээд Сургуулийн химийн инженерийн ангид суралцаж

байсан Элэн Мангрум эгч: “Шинжлэх ухаан яаж гэдгийг тайлбарладаг. Гэхдээ яагаад гэдгийг тайлбарлаж чаддаггүй” гэж хэлсэн. Тэрээр цааш хэлэхдээ, шашин бол дэлхий яагаад бүтээгдсэн, бид яагаад энд ирсэн гэх мэт учир шалтгааныг тайлбарладаг гэж хэлэв.

Алдарт физикч Альбэрт Эйнштэйн ч гэсэн шашин, шинжлэх ухаан хоёр бие биеэ харилцан нөхөхийн зэрэгцээ өөр өөр зорилготой гэдэгт итгэдэг байв.

“Шинжлэх ухаан зөвхөн юу гэдгийг нь олж тодорхойлодог ч, юу байх ёстой вэ гэдгийн учир шалтгааныг олж тодорхойлж чаддаггүй.” [Шинжлэх ухааны] хүрэнээс гадуур бүх төрлийн үнэлж цэгнэдэг сэтгэлгээ шаардлагатай хэвээр байдаг”³ гэж тэр бичжээ.

Энэ нь хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд юу гэсэн үг вэ? Бид юун түрүүнд шинжлэх ухааны ойлголт хувьсан өөрчлөгдөнө гэдгийг мэднэ. Эцсийн эцэст шинжлэх ухаан бидэнд эргэн тойрныхоо дэлхий ертөнцийн “хэрхэн” хэмээх зүй тогтлыг илүү сайн ойлгоход туслах арга замыг олохыг хичээхийг хэлдэг билээ. Үүнийг мэдсэнээр бид амьдралын “яагаад”-ыг эсвэл “байх ёстой” гэсэн зүйлсийг ойлгохын тулд сүүлийн үеийн судалгааг судлах шаардлагагүй юм. Бид зөв, буруугийн хооронд шийдвэр гаргахдаа Есүс Христийн





өөрчлөгдөшгүй сайн мэдээнд итгэж, тусалцаа авч болно.

Бүх зүйл зохицолддог

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч, нэрд гарсан зүрхний мэс засалч Рассэлл М.Нэлсон шашин, шинжлэх ухаан хоёр хэрхэн хамтдаа зохицолддог тухай ярьсан юм.

Тэрээр “Шинжлэх ухаан, шашин хоёр хоорондоо зөрчилддөггүй” гэж хэлэв. “Зөрчилдөөн нь шинжлэх ухаан, шашин хоёрын аль нэгнийх нь эсвэл хоёулангийнх нь талаар бүрэн дүүрэн мэдлэггүйгээс болж үүсдэг. . . Үнэн шинжлэх ухааны лабораториос эсвэл Их Эзэний илчлэлтээр ирэхээс үл хамааран хоорондоо авцалддаг”⁴ гэж хэлсэн.

Тиймээс, хэрэв танд дэлхийн насжилт, динозавр, эволюци эсвэл таны шинжлэх ухааны хичээлээс мэдэж авсан ямар нэгэн зүйл сайн мэдээтэй хэрхэн нийцдэг талаар асуултууд гарч ирвэл энэ нь сайн хэрэг юм. Бүх зүйл хоорондоо зохицолддог ч бидэнд сурч мэдэх ёстой олон зүйл байгаа тул олон асуулт байсаар байна. Канадын Квебекийн эм зүй судлаач эрдэмтэн, Брайн Даун ах бидэнд бүх зүйл илчлэгдэх тэр цаг мөчийг би тэсэн ядан хүлээдэг (С ба Г 101:32–34-ийг үзнэ үү) гэж хэлээд, тэр цаг болтол “шинжлэх ухааны оролдлогоор эргэн тойрныхоо дэлхий ертөнцийн бүх нууцыг ойлгох чадвар хязгаарлагдмал хэвээр байна. “Үүнтэй адил бид Бурханы нууцуудыг болон хүүхдүүдээ зориулсан агуу төлөвлөгөөг ойлгох чадвар маань хязгаарлагдмал байдаг” гэжээ.

Хэрэв сайн мэдээний тухай ойлголт, шинжлэх ухаанаар дамжуулан мэдэж авсан зүйлс тань хоорондоо зөрчилдөж байгаа мэт санагдвал санаа зовох хэрэггүй. Үнэндээ, шинжлэх ухааны батлан нотолсон ямар ч зүйл таны итгэл үнэмшлийг няцааж чадахгүй юм.

Тиймээс, хэрэв та шинжлэх ухаанд дуртай бол сонирхдог салбарынхаа талаар боломжтой бүхнийг судал. Тэр бүү хэл таны итгэл танд давуу тал олгож

болох юм. Өмнөд Виржинийн Их Сургуулийн биологийн тэнхимийн профессор Ричард Гарднэр ах Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэл нь түүнд их тус болдог талаар хэлсэн.

“Заримдаа судалгаа түвэгтэй болж, юу ч болохгүй байгаа мэт санагдах үед, ер нь судалгааны ажилд ийм зүйл тохиолддог ч сайн мэдээний адислалуудын тухай ойлголттой байх нь үүнийг даван гарахад надад тусалдаг” хэмээн тэр хэлжээ.

Даун ах ч гэсэн өөрийн итгэлийг шинжлэх ухааны ажлаа хийхэд нь тусалдаг гэж боддог.

“Би бүх зүйл уялдаа холбоо, дэс дараатай бөгөөд хэрэв ямар нэг асуултыг удаан хугацаанд, хангалттай шаргуу судлах юм бол Тэнгэрлэг Эцэг эцэст нь миний оюун ухааныг хариулт олоход нээж өгнө гэдэгт үргэлж итгэн ажилладаг” гэж тэр хэлсэн юм.

Шинжлэх ухааны нээлтэд баясах нь

Бидний Христэд болон Түүний сайн мэдээнд итгэх итгэл даруу байж, шинжлэх ухаанч эсвэл сүнслэг байхаас үл хамааран эрэлхийлж байгаа үнэнээ нээж илрүүлэхэд тусалдаг.

“Бидэнд шинжлэх ухааны талаар мэдэхгүй зүйл их байдаг. Мөн Бурхан Өөрийнхөө тухай бидэнд харахан илчлээгүй зүйл ч олон бий” гэж профессор Гарднэр хэлээд, “Тиймээс бидэнд илүү их мэдээлэл ирэх үед хүлээн авахад оюун ухаанаа нээлттэй байгаж, харин энэ хугацаанд санаагаа чилээхгүй байх нь чухал юм” гэжээ.

Жишээ нь, зарим хүн дэлхийн талаарх ажиглалтуудаа ямар нэгэн тайлбар олж хардаггүй учраас Бурханд зүгээр л итгэдэг. Үүнийг “Бурханд хоосон” итгэх гэж нэрлэдэг бөгөөд энэ нь хүмүүсийг шинжлэх ухааны ололт амжилтаас айхад хүргэж болно. Профессор Гарднэр энэ талаар нэг жишээ дурдсан юм.

“Зарим хүн чулуужсан үлдэгдлийн баримт мэдээлэлд хоосон зай байдаг учраас (эволюци бидний хэрхэн энд ирснийг тайлбарлаж чаддаггүй гэсэн утгаар) Бурханд итгэсэн байдаг. Харин энэ хоосон зай шинэ чулуужсан үлдэгдлийн нээлтээр нөхөгдвөл бидний итгэлд юу тохиолдох вэ? Харин үүний оронд бид Бурханы талаар баттай нотолгоог Ариун Сүнсээр дамжуулан олж авах хэрэгтэй бөгөөд тэгж чадвал шинжлэх ухааны ямар ч нээлт байлаа гэсэн санаа зовохын оронд баясах болно.

Бид ийм хандлагатай байвал шинжлэх ухаан, шашин хоёулаа үнэнийг хайх бидний эрэлд тусалж чадах бөгөөд эцэст нь бүх үнэн нэг эх сурвалж болох Бурханаас ирдэг гэдгийг сануулна.

Профессор Гарднэр “Бурхан хүсвэл бүх зүйлийг, тухайлбал шинжлэх ухааны баримтуудыг ч гэсэн илчилж чадна” хэмээн хэлээд, “Мөн Түүнд Өөрийн


гэсэн сүнсээр өдөөгдсөн эрдэмтэн, зохион бүтээгч, инженерүүд байгаа ч тэдэндээ бүх зүйлийг зүгээр өгчихдөггүй нь лавтай. Тэр тэднээс болон биднээс тархиа ажиллуулахыг хүсдэг учраас бидэнд шинжлэх ухааныг судлах боломж олгож, харин Бурханы Сүмд өгдөг илчлэлт нь Сүмийг хэрхэн зохион байгуулах, ялангуяа хэрхэн Христэд ирж мөн аврагдах тухай хэлсэн байдаг.

“Түүний бидэнд өгдөг хувийн илчлэлт ямар ч сэдвээр байж болох ч ялангуяа Тэр амьд бөгөөд бидэнд хайртай, Христ авралын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн, бидэнд өнөө үед амьд бошиглогч байгаа, бид Бурхан төлөвлөгөөг дагаж чадах бөгөөд ийнхүү хийх нь зөв гэдгийг мэдүүлэхэд чиглэгддэг.” ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Жишээг К.Кодэлл Картэр ба Барбара Р.Картэр, *Childbed Fever: A Scientific Biography of Ignaz Semmelweis* (1994)-аас үзнэ үү.
2. *Teachings of Presidents of the Church: Brigham Young* (1997), 16.
3. Кэн Уилбэрийн бичсэн *Quantum Questions: Mystical Writings of the World's Greatest Physicists* (1984) номон дээрх Альбэрт Эйнштэйний “Science and Religion” хэсгээс эш татав.
4. Рассэлл М.Нэлсон, Марианнэ Холман Прэскоттын бичсэн “Church Leaders Gather at BYU’s Life Sciences Building for Dedication,” *Church News*, 2015 оны 4-р сарын 17, LDS.org.



Молекул ба эсийн биологи судлаач

РИЧАРД ГАРДНЭР ЭМЧТЭЙ ХИЙСЭН

АСУУЛТ, ХАРИУЛТ

Та шинжлэх ухааныг хэрхэн сонирхдог болсон бэ?

Ургамал судлаач аав минь намайг шинжлэх ухаанд сонирхолтой болгосон. Би багадаа микроскоп, бусад лабораторийн хэрэгслээр тоглож, ургамал, мөөгний талаар ярихыг сонсож өссөн. Түүнийг есөн настай байхад генетик судалдаг байсан аав нь жимсний талаарх хавтсуудыг судал гэж өгчээ. Би ахлах сургуулиас боломжтой бүхий л шинжлэх ухааны мэдлэгээ олж авсан бөгөөд тэдний дунд шавжны цуглуулга хийх даалгавар надад их таалагддаг байсан. Би аливаа зүйлийн хэрхэн ажилладаг болохыг мэдэх, сурах дуртай учраас бага байхдаа л шинжлэх ухааны докторын зэрэг хамгаална гэсэн шийдвэрийг гаргасан байлаа.

Таны шинжлэх ухааны эрэл хайгуул итгэлийг тань хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?

Би ганц эсийн доторх тогтолцоо хэчнээн нарийн түвэгтэй болохыг мэдэж авахын хэрээр гайхан биширдэг. Надад ердийн эсийн химийн ихэнх харилцан үйлчлэлийг жижиг үсгээр схемчлэн үзүүлсэн хоёр том зурагт хуудас байдаг. Тэдгээр бүх харилцан үйлчлэл сайн хяналтан дотор явагддаг. Нэг удаа би үүнийг санваарынхаа ангид үзүүлж билээ. Би тэдэнд Ариун сүмийн талбай болон ХҮГ бусад зочдын төвд байдаг Христийн хөшөөний талаар сануулав. Хөшөөний ард орчлон ертөнцийн зураг байдаг бөгөөд энэ нь “Энэ бүхнийг бүтээсэн Бүтээгч энд байна” гэсэн утгыг харуулдаг. Харин би тэдэнд “эдгээр зурагт хуудсыг хөшөөний ард байрлуулъя” гэж санал болгов. Эдгээр нь орчлон ертөнцийн зураг шиг сайхан биш ч гэлээ, эсийн химийн харилцан үйлчлэлийг ч гэсэн Бурхан бүтээсэн бөгөөд энэ бүхний нарийн ширийн хэсгийг хүртэл нэг бүрчлэн сайн ойлгодог юм!

Таны итгэл шинжлэх ухааны эрэл хайгуулд тань хэрхэн тусалж байсан бэ?

Би судалгаа хийж байхдаа болон одоо шинжлэх ухааныг зааж байгаа энэ үед ч гэсэн итгэлгүйгээр бүрэн дүүрэн зургийг харж чадахгүй тул итгэл бол миний хувьд маш чухал зүйл юм. Эс хэрхэн ажиллагдийг, яагаад эдгээр нь оршин тогтнодгийг эсвэл яагаад бид энэ дэлхий дээр байгааг олж мэдэлгүй судалбал миний хувьд хангалтгүй байх байсан.





Далын ахлагч
Ахлагч Хьюго
И.Мартинэз

БЭЛТГЭ, ТЭГЭЭД ХИЙ

Өөрийгөө бэлдэж мөн Их Эзэний ажлыг хийх нь та нарын амьдралыг өөрчлөх болно.

Би 6 жилийн турш семинарын багшаар үйлчилсэн. Бид Пуэрто Рико дахь манай гэрт өглөө бүр 6:00 цагт хичээллэдэг байв. Даваагаас Баасан гараг хүртэл өдөр бүр хичээлдээ бэлдэх нь

СУРАХ ХҮСЭЛТЭЙ ИРЭГТҮН

их ажил боддог байв. Гэхдээ би үүнд дуртай байлаа. Энэ нь надад Сүмийн өсвөр үеийнхнийг илүү их хайрлаж сурахад тусалсан.

Суралцагчдын семинараас олж авдаг зүйлсийн ихэнх нь тэдний бэлтгэлээс шалтгаалдаг болохыг би олж мэдсэн юм. Тиймээс хэрэв та нар семинарын хичээлээс илүү ихийг олж авахыг хүсвэл би та нарыг хичээлээ урьдчилан судалж, зохих ёсоор тунгаан боддог байгаасай хэмээн урьж байна. Мэдлэгээр цангаж хичээлдээ ир. Үргэлж суралцах хүсэлтэй байдаг бяцхан хүүхдийн адил ир. Бие биедээ заахын тулд хичээлд оролцоход бэлтгэ. Асуух зүйлтэй ир. Өөр нэг өсвөр насны хүүхэд болон уншсан судрын хэсэг эсвэл багшийн хэлсэн тайлбар асуултын таны хариулт болж болох юм.

Таныг бэлтгэлтэй байгаа үед ямар ч хичээл, Сүмийн цуглааны үеэр хамгийн сайн заавар ирдэг бөгөөд та бодлоороо дамжуулан сүнслэг өдөөлт хүлээн авдаг. Тэдгээрийг бичиж тэмдэглээд, дараа нь тэдгээрийн дагуу үйлд. Илүү олон судар, Ерөнхий чуулганы үгс, Сүмийн сэтгүүл зэргээс эдгээр санаа бодолтой холбоотой өгүүлүүдийг хайж ол. Та нар эдгээр үнэнийг зүрх сэтгэлдээ мэдэрсэн бол Их Эзэн та нарыг бусдад туслахад ашиглах учраас оюун бодол, зүрх сэтгэлдээ тэдгээрийг тунгаан бодож, үйлчлэхэд бэлэн бай.

Дараа нь би номлолын ерөнхийлөгчөөр эхнэртэйгээ хамт үйлчилж байхдаа семинар нь номлолын үйлчлэлд агуу бэлтгэл болдгийг ойлгосон. Олон жилийн турш би сайн мэдээний гайхамшигт хүч нь семинартаа итгэлтэй суралцдаг суралцагчдыг адисалдаг болохыг харсан

ДАДЛАГА ХИЙХИЙН ТУЛД БЭЛТГЭГТҮН

билээ. Тэд амьдралд нь тохиолдсон хүнд сорилтод хичээл дээр заалгасан зүйлээ хэрэгжүүлж, даван туулж, зарим нь хэсэг хугацаанд идэвхгүй байсан ч Сүмдээ эргэн ирдэг.

Их Эзэнд та маш чухал. Тийм ээ, та үнэхээр чухал. Өсвөр үеийнхний үүрэг бол номлолын ажилд бэлтгэж, дараа нь номлолын ажлаа хийх явдал юм. Одоо та номлогчийн ажлыг үргэлжлүүлэн хийж, бэлдсэнээр Их Эзэний номлогчийн хувьд цаашид өсөж хөгжихөд удирдуулан чиглүүлэгдэх болно гэдгээ ойлгох ёстой. Та гэрээнүүд хийснээр зүрх сэтгэлд тань бичсэн Есүс Христийн нэрийг өөртөө авч явдаг учраас номлогчийн ажил хийхэд номлогчийн нэрийн тэмдэг заавал байх шаардлагагүй юм.

ТА НАР ҮҮНИЙГ ХИЙЖ ЧАДНА


Гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил зэрэгт ч ийм байдаг. Жишээ нь миний үйлчилдэг Карибын бүсэд өсвөр үеийнхнээ гэр бүлийн түүхийн зөвлөхүүд болгон ажиллуулдаг гадаснууд ариун сүмийн ажлын нэрс олох, ариун сүмийн ажил хийх гишүүдийнхээ тоогоор илүү өндөр хувьтай байдаг. Нэг гадсанд нэг жилд 20 өсвөр үеийнхэн номлолдоо гартал гэр бүлийн түүхийн зөвлөхөөр үйлчлэхээр дуудагддаг. Тэд гишүүдэд гэр бүлийн түүхээ

хэрхэн хийхийг үзүүлэхийн тулд гэр оронд нь айлчлан очиж, арга замыг нь хүмүүстэй ярилцаж, гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн тухай тэдэнд ярьж өгдөг. Энэ чинь л номлолын ажил шүү дээ!

ТЭР ТА НАРЫН
АМЬДРАЛЫГ АДИСАЛЖ,
ӨӨРЧЛӨХ БОЛНО

Тэд номлолд үйлчлэх үедээ гэр орондоо хүчирхэг арга замаар Сүнснийг мэдэрсэн байдаг гэдэгт би итгэдэг. Хэрэв үгүй бол тэд номлол, гэр бүлийн түүх, ариун сүмийн ажил зэргийг хийж байхдаа мэдрэх нь тодорхой билээ. Тэгээд номлогчийг бэлтгэх төвд орохдоо тэдний хэн нь ч “Би амьдралдаа өмнө нь Сүнснийг хэзээ ч ийм хүчтэй мэдэрч байсангүй” гэж хэлэхгүй гэдэгт би итгэж байна. Тэд Түүний нөлөөг үүнээс өмнө хүчтэй мэдэрсэн байх ёстой.

Их Эзэн та нарт хайртай. Түүний зорилго бол гэр бүлийн түүх, ариун сүмийн болон номлогчийн ажлыг та нараар хийлгүүлэхэд оршдог. Та нарт чадвар, мэдлэг бий. Та нар сайн бэлдсэнээр энэ ажлыг хийж чадна. Энэ таны амьдралыг адисалж мөн өөрчилнө. ■



АВРАГЧИЙГ ДУРСАН САНАХ НЬ

Эрик Б.Мердок

Сүмийн сэтгүүл

Бид долоо хоног бүр сүмд очихдоо ариун ёслолоос хүртэх боломжоор адислагддаг. Үнэндээ, энэ бол бидний ням гарагт сүмд очдог гол шалтгааны нэг юм. Харин та яагаад ариун ёслол ийм чухал болохыг мэдэх үү? Бид нэг зүйлийг хийхээр амладаг бөгөөд энэ нь Сүмийн хамгийн чухал, ариун нандин ёслолуудын нэг болох Есүс Христийг дурсан санах явдал юм.

Аврагчийг дурсан санах нь ариун ёслолын залбирлын гол хэсэг мөн талаар бодож үз. Эдгээр залбирлаар бид “түүнийг үргэлж санах болно” (С ба Г 20:77, 79) гэж

зөвхөн ням гарагт бус харин *үргэлж* амладаг. Бид Аврагчийг үргэлж санаж байвал бидний амьдрал Түүний жишиг, сургаалыг харуулахын зэрэгцээ амьдралдаа хүчирхэг бөгөөд цааш үргэлжлэх нөлөөг олж авах болно.

Дурсан санах нь нэгэн залууд хэрхэн тусалсан бэ?

Жишээ нь, Бурханы тэнгэр элч залуу Алмаг наманчлалд дуудах үед тэрээр газарт унаж, хэдэн өдрийн турш ярьж бас хөдөлж ч чадаагүй. Энэ үед тэрээр гэм нүглээ санан тарчилж байсан ч дараа нь “дэлхийн нүглүүдийг цагаатгахаар, Бурханы Хүү, Есүс Христ гэгч нэгний ирэлтийн талаар хүмүүст эцгийнхээ бошиглохыг дуулснаа санав.” Мөн тэр цааш нь: “Эдүгээ, миний оюун энэ бодол дээр тогтож тунгаах зуур, би зүрх сэтгэлдээ хашгирч: Ай Есүс, Бурханы Хүү та, шаналлын гүнд буй, мөн үүрдийн үхлийн гинжээр ороогдсон намайг нигүүлсээч гэв. Мөн эдүгээ, болгоогтун, би үүнийг бодмогц, би өвчнөө цаашид санаж чадсангүй” (Алма 36:17–19).

Зөвхөн Христийн тухай бодол нь Алмаг нигүүлслийн төлөө залбирахад хүргэж, энэ нь түүний гэмшлийн мэдэрэмжийг арилган, өвчин шаналлыг хөнгөвчилж, наманчлахад тусалсан билээ. Бид Алмагийн адил Христэд амьдралаа хандуулж, сайн мэдээний дагуу амьдарснаар ирдэг баяр баясгаланг мэдэрч чадна. Энэ бүхэн Есүс Христийг болон Түүний Цагаатгалын хүчийг санах бидний сонголтоор эхэлдэг.



Бид ариун ёслолоос хүртэх замаар Есүс Христийг дурсан санах үед агуу адислал ирдэг.

АВРАГЧИЙГ ҮРГЭЛЖ САНАХ АМЛАЛТАА САХИСНААР ИРДЭГ ӨӨР ТАВАН АДИСЛАЛЫГ ДООР ДУРДАВ.

1. Түүний Сүнс бидэнтэй хамт байх болно

Та нар ням гарагт ариун ёслолоос хүртэх үедээ Христийг санаж, зарлигуудыг дагаж мөн өөрсөд дээрээ Түүний нэрийг авбал Түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгах амлалтыг танд санууддаг. Сорилт бэрхшээлээр дүүрэн дэлхий дээр буруу замд хөтлөгдөхөд амархан. Хэрэв та нар Ариун Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгавал “Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” (Моронай 10:5). Их Эзэний Сүнс та нарын хөтөч байж, та нарыг удирдамж, заавар, хамгаалалтаар адислах болно.

2. Тэр бидэнд уруу таталтыг эсэргүүцэх хүч чадлыг өгнө

Уруу татагдахын эсрэг хамгийн шилдэг, найдвартай хамгаалалт бол бидний Есүс Христэд итгэх итгэл юм (Алма 37:33-ыг үзнэ үү). Бид оюун ухаанаа Христ дээр төвлөрүүлснээр Сатаны худал хуурмагийг ялган таньж, биднийг хуурч мэхлэх гэсэн оролдлогуудыг олж мэдэж чадна. Есүс уруу татагдсан ч хэзээ ч автаагүй учир, бид уруу татагдах үедээ Түүнд найдаж болно. Нифай “[Бурханы үгээс] зууран барих хэн боловч эрсдэх нь үгүй; бас хортны уруу таталтууд хийгээд галт сумнууд, тэднийг устгал уруу удирдахаар тэднийг харалган болгож давамгайлах нь ч үгүй” (1 Нифай 15:24) хэмээн заасан. Бид Аврагчийг мөн Түүний сургаалыг санах үед Тэр биднийг өргөж, уруу таталтын эсрэг хүчирхэгжүүлнэ.

3. Түүний үлгэр жишээ биднийг удирдан чиглүүлнэ

Есүс бидэнд зөвхөн мөнх амьдралд очихын тулд хаашаа явахыг хэлээд зогсохгүй, замыг удирддаг. Тэр “Би бол зам, үнэн, амь мөн” (Иохан 14:6) гэж хэлсэн. Христ бидний төгс жишээ юм. Тэрээр мөнх бус амьдрал дахь тохинууллынхаа үеэр хайр, номхон дөлгөөн байдал, даруу зан, нигүүлслийг зааж, үлгэр жишээ үзүүлсэн. Тэр цагаа бусдад зааж, үйлчилж, хайрлаж өнгөрүүлсэн.



АРИУН ЁСЛОЛЫН ТАЛААР ИЛҮҮ ИХИЙГ МЭДЭХИЙГ ХҮСВЭЛ

Аврагчийн болон ариун ёслолын талаар илүү ихийг мэдэж авахыг хүсвэл та дараах материалыг уншиж болно.

- Жэффри Р.Холланд, “This Do in Remembrance of Me,” Ensign, 1995 оны 11-р сар, 67.
- Чэрил А.Эсплин, “The Sacrament— a Renewal for the Soul,” Liahona, 2014 оны 11-р сар, 12.



Тэр хийсэн бүх зүйлдээ Эцэгийнхээ хүсэлд дуулгавартай байсан билээ (Иохан 5:30-ыг үзнэ үү). Аврагч бүх зүйлд бидний дагаж амьдрах загварыг үзүүлсэн бөгөөд биднийг Өөрийнх нь үлгэр жишээг дагахад урьдаг.

Хэрэв танд хаашаа явахаа эсвэл юу хийхээ мэдэхгүй үе гарвал Аврагчийг сана. Тэр “Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно” (Иохан 8:12) хэмээн хэлсэн.

4. Тэр бидэнд бусдад үйлчлэхэд тусална

Есүс үргэлж бусдыг хэрэгцээг Өөрийнхөөсөө дээгүүр тавьдаг байсан. Тэр “сайныг үйлдэж явсан” (Үйлс 10:38). Тэр өвчтэй хүмүүсийг эдгээж, эргэн тойрныхоо хүмүүст тусалдаг байсан. Бид Есүсийг дурсан санахдаа Түүний амьдралыг тодорхойлдог амь бие үл хайрлан хийсэн үйлчлэлийг нь санадаг. Түүнчлэн Тэр бусдад үйлчилж Өөрт нь үйлчлэхийг биднээс хүссэн гэдгийг бид дурсан санадаг. “Та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа” (Мозая 2:17) билээ.

Их Эзэн тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг олж харахад танд тусалж, нүдийг тань нээх болно. Тэр бас танд хэрхэн хамгийн сайнаараа үйлчилж болох арга замыг зааж өгөх болно. Нинжин сэтгэлийн үйлчлэлийн жижиг, энгийн үйлдлүүдийг хийснээр таны амьдрал илүү аз жаргалтай, үр өгөөжтэй байх болно. Бусдад үйлчлэх нь таны амьдралд амар амгалан, баяр баясгаланг авчирна.

5. Бид наманчилж чадна

Бид чин сэтгэлээсээ хичээсэн ч зарлигуудыг төгс дагаж чаддаггүй боловч Есүс Христийн амьдрал, зорилгын ачаар буцах зам байгаа.

Есүс Христийг санах нь бидэнд Түүний Цагаатгалаар дамжуулан боломжтой болсон наманчлалын бэлгийг сануулдаг. Есүс биднийг наманчлахад урьдаг бөгөөд бид гэм нүглээсээ салж, Түүнд хандсанаар баяр баясгаланг мэдэрдэг. Хэрэв бид өөрчлөгдөж, зарлигуудыг дагах чин сэтгэлийн хүсэлтэй байх юм бол Их Эзэн “нүглүүдээ наманчилсан тэрээр, мөнхүү тэр нь өршөөгддөг ажгуу, мөн Их Эзэн, бибээр тэдгээрийг цаашид санах нь үгүй” [С ба Г 58:42] хэмээн амласан байдаг.

Та нар ариун ёслолоос хүртсэнээр Аврагчийг үргэлж санана гэж амладаг. Та нар оюун бодолдоо Христийг байлгах тусам Тэрээр таны амьдралын төвд байж, бүрэн чадавхдаа хүрэхэд таныг улам бүр удирдан чиглүүлнэ. Аврагчийг үргэлж санах нь амьдралыг тань байнга адислах болно. ■



ХҮНДЭТГЭЛИЙН ӨДРИЙГ САХИХ НЬ

Маккэнзи Браун

Би хоцорч байлаа! Би гоёлын даашинзаа хурдхан өмсөөд, үсний хавчаараа зүүж, Сүм дээр очин, машинаа зогсоол дээр тавиад, дотогш яаран оров. Ёох! Бишопыг ариун ёслолын цуглаанаа эхлэхээр босох үед би индэр дээр очиж суудлаа эзлэв.

Би тэр ням гарагт үг хэлэх байсан учраас ямар нэгэн зүйл мартсан эсэхээ шалган, тэмдэглэлийн дэвтрээ гүйлгэн харав. Ариун ёслолын цуглаан нэг мэдэхэд дуусаж, би Ням гаргийн анги руугаа явж байлаа. Ариун ёслолыг дахин амжилттай өнгөрүүлчихлээ.

Гэхдээ үнэхээр амжилттай байсан болов уу?

Дараагийн долоо хоногийн турш би бодолд автав. Дараагийн ням гараг ч болж, ариун ёслолын цуглааны үеэр уг ёслол миний хувьд ямар

утга учиртай болохыг бодож суутал нэгэн бодол зурсхийн орж ирэв. Би Есүс Христийг үргэлж дурсан санах болно гэж долоо хоног бүр амладаг ч үүнийгээ хэр нухацтай хийж байгаа вэ?

Би өөрчлөгдөхийг хүсэж байсан учраас долоо хоногийн төлөвлөгөө гаргахаар шийдлээ.

- Би долоо хоногийн турш биеэ хэрхэн авч яваагаа дүгнэж, нүглийнхээ өршөөлийг гуйх хэрэгтэй байв. Түүнчлэн би оршил хөгжим сонсож, Сүнсний мэдрэхийн тулд сүмд эрт ирж байхаар болов.
- Ариун ёслолын турш би Есүс Христийг болон Түүний Цагаатгалыг санах ёстой. Би юуг зөв, юуг буруу хийснээ залбирч дүгнэх ёстой байв. Би өөрөөсөө “Их Эзэн минь, надад юу дутагдаж

байна вэ?” гэж асуух хэрэгтэй байлаа. (Матай 19:20-ийг үзнэ үү).

- Би ариун ёслолоос хойш өдөр бүр, сайжрахын төлөө мөн Христийг санахын төлөө тусламж хүсэн залбирах ёстой байв.

Би төлөвлөгөөгөө дагаж байхдаа ариун ёслолыг үнэхээр хайрлаж сурсан билээ. Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч, амьдралынхаа тухай Түүнтэй ярилцах дуртай болсон. Өнгөрсөн долоо хоногт би биеэ хэрхэн авч явснаас үл хамааран Есүс Христийн Цагаатгалд мөн өөрчлөгдөж, илүү сайн хүн болох боломжтой байгаадаа үргэлж талархдаг болов. Би одоо ариун ёслол зөвхөн ням гарагт биш, харин өдөр *тутмын* амьдралд зориулагдсан гэдгийг мэдэж авсан.

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

АНХААРЛАА ДУТУУ ХАНДУУЛЖ БАЙНА УУ?

“Танаас ариун ёслолыг бэлтгэж, адисалж, түгээхийг эсвэл хүртэхийг хүссэн учраас л та Аврагчийн болон Түүний цагаатгагч золиослолын талаар нухацтай боддог уу?”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэлл Баллард,
("Залуучуудын хамгийн агуу үеийнхэн," 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 55.)



ДЭЛХИЙД ГЭРЭЛ нь байхад суралцах

Виктор Де Хэсүс Крүз Варгас

Би Бүгд Найрамдах Доминикан улсад төрж, Сүмд өссөн. Би зөв замыг дагахад надад туслахыг хичээдэг сайн удирдагчдын дунд өсөж том болсон юм. Би номлолд үйлчилж, хүмүүст тусална гэж мөрөөддөг байлаа.

Аав биднийг илүү сайхан амьдруулахын тулд Америкийн Нэгдсэн Улс руу явсан тул ээж намайг эгч нарын хамт ганцаараа өсгөсөн. Хааяа би ганцаарддаг ч Сүмийн удирдагчидтайгаа амьдралынхаа асуудлыг ярилцаж болдог байсан учраас үргэлж ганцаардаад байдаггүй байлаа.

Биднийг Америкийн Нэгдсэн Улс руу нүүсний дараа томоохон сорилт бэрхшээл тохиолдож эхлэв. Бид жижиг салбарт явдаг байсан бөгөөд надад туслахыг хүсдэг сайн удирдагчид байсан ч сургуулийн найзууд намайг сайн мэдээний замаас холдуулахыг хүсдэг байлаа. Харамсалтай нь би ээжтэйгээ уцаарлан ярьдаг болж, түүний зөвлөгөөг бараг сонсохоо болив.

Би ням гараг бүр сүмд явдаг байсан ч үнэндээ надад явах хүсэл төрдөггүй болж, номлолд явахыг хүсэж байгаа эсэхээ ч мэдэхээ больсон байлаа.

Нэг өглөө би Мормоны Номоо нээтэл яг миний дуртай судрын хэсэг болох 3 Нифай 12:14–16 нээгдэв.

“Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ хүмүүсийн гэрэл байх үүргийг би та нарт өгнө. Толгойд дээр байрласан хот нууцлагдах аргагүй билээ.

“Болгоогтун, хүмүүс лаа асаагаад, мөн үүнийгээ тогоон дор нуудаг бил үү? Үгүй ээ, харин лааны тавиур дээр тавьж, мөн энэ нь гэрт байгаа бүгдэд гэрэл өгдөг;

“Тиймийн тул, тэд та нарын сайн ажлуудыг харж, тэгээд тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулж болохын тулд гэрэл тань энэ хүмүүсийн өмнө тийн туяаран гийг.”

Үүнийг уншиж байхдаа би агуу их баяр баяслыг мэдэрч, энэ нь семинарт сурсан зүйлсээ болон бидний Эцэгийн төлөвлөгөө хэчнээн гайхамшигтай болохыг санахад тусалсан. Тиймээс би дэлхийн гэрэл нь байхын тулд хичээхээр шийдсэн юм.

Би хоёр үеэлээ Сүмд ирэхийг урив. Идэвх султай байсан нэг нь идэвхтэй болов. Нөгөөх нь гишүүн биш байсан ч би түүнд баптисм хүртээх боломжтой болсон юм.

Нэг жилийн дараа би АНУ-ын Калифорнид үйлчлэх дуудлагаа хүлээн авсан билээ. Би үйлчилж байхдаа энэ бол Есүс Христийн жинхэнэ сайн мэдээ гэдгийг ямар ч эргэлзээгүй мэддэг болсон. Хүмүүст туслахын хэрээр гэрчлэл маань илүү их өсөн нэмэгдэж, судраа унших бүрдээ би дэлхийн гэрэл байх тухай өгүүлсэн 3 Нифай дээрх хэсгийг үргэлж чээжээр уншдаг болсон. ■

Энэхүү өгүүллийн зохиогч Бүгд Найрамдах Доминикан улсад амьдардаг.



ЧИ ХЭН Ч БАЙ

“Өө, үгүй ээ. Би гэр бүлтэйгээ лацдан холбогдоогүй болохоор яах болж байна вэ?” гэж Энди бодов.

Линда Дэйвийс

Бодит түүхээс сэдэвлэв



“Би Бурханы хүүхэд тул энэ эх дэлхийд намайг заяав, Тэр” (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 58).

Энди толинд зэрвэсхэн хараад, “Яг болсон байна” гэж бодов. Тэр хамгийн дуртай улаан даашин-заа өмссөн байлаа. Тэр ням гарагт үргэлж хамгийн сайхнаараа харагдахыг хичээдэг байв. Тэр өглөөний ундаа уухаар доошоо гүйлээ.

Түүнийг хамгийн сүүлийн шарсан талхаа идэж дуусах үед Рийдэрийнхний машин зам дээр сигнаалдах нь сонсогдов. “Баяртай, ээж ээ! Баяртай, аав аа!” гэж Энди хэлэн тэднийг үнсээд, хаалгаар гүйн гарлаа.

Эцэг эх нь Сүмийн гишүүд байгаагүй хэдий ч Эндийг долоо хоног бүр сүмд явахад нь дэмждэг байв. Рийдэрийн гэр бүлийнхэн түүнийг баптисм хүртэж, гишүүнээр батлагдсанаас хойш бараг ням гараг бүр ирж авдаг байлаа. Тэд түүнд

үргэлж найрсаг хандаж, хайрладаг нь Эндийд таалагддаг байв.

Ариун ёслолын дараа Хүүхдийн хэсэгтээ орох цаг боллоо. Энди Лонг ах, эгчийн Баатруудын ангид орох дуртай байв. Тэд сайхан сэтгэлтэй бөгөөд үргэлж хамгийн сонирхолтой хичээлийг заадаг байлаа.

“Өнөөдөр бид ариун сүмийн тухай ярилцах болно” гэж Лонг эгч хэлэв. “Бид ариун сүмийн тухай ямар зүйл мэддэг билээ?”

Энди “Би ариун сүмд баптисм хийж болно” гэсэн нэг хариултыг мэдэж байв. Жил бүр тойргийнх нь залуу эмэгтэйчүүд баптисмын ёслол хийхээр ариун сүмийн аялалд явдаг байсан тул тэр үүнийг хэлсэндээ баяртай байлаа. Энди ч бас удахгүй явах болно!

“Сайн байна, Энди. Бид өөр юу мэддэг вэ?”

“Бид ариун сүмд гэрлэж болно” гэж Эндигийн найз Аллисон хэлэв.

“Маш сайн” гэж Лонг эгч хэллээ. “Өөр хэлэх зүйл байна уу?”

“Тэр бүлүүд ариун сүмд лацдан холбогдвол мөнхөд хамтдаа байж чадна” гэж Аллисон нэмж хэллээ.

“Тэхдээ миний гэр бүл чадахгүй. Аав ээж хоёр ариун сүмд лацдан холбогдоогүй шүү дээ!” гэж Энди бодов. Гэнэт түүний нүүр халуу оргиж, нүд нь нулимсаар дүүрэв.

“Чи зүгээр үү, Энди?” гэж Лонг эгч асуулаа.

Энди уйлахгүй байхыг хичээсэн ч “Тийм ээ” гэж хамраа шуухитнуулан хариулав. Гэвч хичээл дуустал



зүрх нь хүчтэй цохилж байгааг тэр мэдэрч байлаа.

Хичээл дуусахад Лонг эгч Эндигийн хажууд сууж, түүнийг тэврэн, “Юу болсон бэ?” гэж асуув.

“Би аав, ээжтэйгээ мөнхөд хамт байхгүй. “Тэд ариун сүмд гэрлээгүй шүү дээ. Би нас барвал хэн дээр очих вэ? Эцэг эх минь гишүүн биш ч гэсэн Тэнгэрлэг Эцэг намайг үргэлжлүүлэн хайрлах уу?” гэж Энди хэлэв.

Лонг эгч Эндигийн нүд рүү эгцэлж хараад, “Чи хэн ч байсан, эцэг эх чинь ариун сүмд орсон ч бай, үгүй ч бай чи Тэнгэрлэг

Эцэгийн гэр бүлийн нэг хэсэг хэвээр байх болно. *Чи* Түүнтэй ойр байж, бусдад үлгэр жишээ болж чадна шүү дээ. Тэр чамайг юу ч болсон үргэлж хайрлаж, удирдаж, хамгаалах болно. Тэр чамайг болон гэр бүлийг чинь адислахыг хүсэж байгаа. Энди, чи бол Бурханы хүүхэд шүү дээ” гэлээ.


Яг тэр үед Эндигийн зүрх хурдан цохилохоо болив. Харин оронд нь зүрх сэтгэлдээ халуун дулааныг мэдэрч байлаа. Тэр багшийнх нь хэлсэн үг үнэн гэдгийг мэдэж байв. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ТА ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Хэрэв эцэг эх чинь эсвэл гэр бүлийн тань хэн нэгэн Сүмд явахыг хүсэхгүй байвал чи юу хийж болох вэ?

- Тэд сонгох эрхтэй бөгөөд Тэнгэрлэг Эцэг тэдэнд хайртай гэдгийг сана.
- Та тэднийг хайрладаг гэдгээ мэдрүүл.
- Сайн мэдээний дагуу амьдарснаар тэдэнд сайн үлгэр жишээ үзүүл.
- Тэдний тухай бүх сайн сайхан зүйлсийг сана.
- Тэнгэрлэг Эцэгээс тэдэнд хайраа мэдрүүлэхэд мөн Сүм рүү удирдан хөтлөхөд туслахыг гуйн залбир.





Кларэнс ба Аварга

Лори Фүллэр

Сүмийн сэтгүүл

Бодит түүхээс сэдэвлэв

Кларэнсийг машины цонхоор Кширтэн сууж байтал далайн боомт харагдаж эхлэв. Өнгө өнгийн байшин, дэлгүүрүүдийн өмнө усан онгоцнууд хөвж харагдана. Данийн Копенгаген орд, харш, цэцэрлэгт хүрээлэнгээр дүүрсэн үзэсгэлэнт хот байв. Энэ нь АНУ-ын Юта мужид байдаг Кларэнсийн төрсөн хоттой бүх талаараа адилгүй байв. Кларэнс хөвгүүн байхдаа гүйдэг байсан тоостой гудамжуудаа төсөөлөн бодлоо. Тэр одоо Америкийн Нэгдсэн Улсын гүйлтийн багийн

гишүүн болсон бөгөөд маргааш Данийн нэртэй гүйгчтэй чухал уралдаанд уралдах гэж байв.

Машин Сүмийн цуглаан аль хэдийн эхэлсэн жижигхэн сүмийн гадна зогслоо.

Кларэнсийг цуглааны арын эгнээнд чимээгүйхэн орж суухад индэр дээр сууж байсан номлогчдын нэг нь маргаашийн уралдааны тухай гарсан сонины нийтлэлээс харсан тул түүнийг танив. Салбарын ерөнхийлөгч Кларэнсийг гарч ирж, үг хэлэхийг хүслээ.

Кларэнсийг яагаад ирснээ хэлсний дараа нэг хүү босож зогсоод, гараа өргөн, “Чи Данийн аваргыг

түрүүлнэ гэж бодож байна уу?” гэж асуув.

Кларэнс юу гэж хэлэхээ сайн мэдэхгүй байлаа. Данийн гүйгчийн тэр улирлын холын зайд гүйсэн хугацаа илүү сайн *байв*.

Номлогчдын нэг нь Кларэнсийг хариулахаас өмнө, “Мэдээж тэр чадна. “Яагаад гэвэл тэр мэргэн ухааны үгийг дагадаг” гэлээ. Тэр судраа нээгээд, Сургаал ба Гэрээ 89:20-ийг гаргаж, мэргэн ухааны үгийг дагадаг хүмүүс “гүйхэд мөн ядрах нь үгүй, мөн алхахад мөн цуцах нь үгүй байх болно” (20-р шүлэг) гэсэн амлалтыг уншлаа.

Кларэнс юу гэж хэлэх байсан бэ? Тэр мэргэн ухааны үг үнэн



КЛАРЭНСИЙН СОНГОЛТ

Кларэнс Ф.Робисон 1948 оны зуны олимпод оролцсон бөгөөд коллежийн холын зайн гүйлтийн агуу дасгалжуулагч болсон юм. Тэр залуу байхдаа мэргэн ухааны үгийг үргэлж дагана гэж амласан байсан. Энэ нь бүх тэмцээнд түрүүлнэ гэсэн үг биш болохыг тэр мэддэг байв. Гэхдээ тэр цэвэр ариун, зохистой, итгэлтэй байгаа үед Тэнгэрлэг Эцэг түүнд хамгийн сайн байхад нь тусална гэдгийг мэддэг байсан.

гэдгийг мэддэг байв. Тэр хүүхэд байхдаа л үүнийг үргэлж дагана гэдгээ амласан байсан. Гэхдээ энэ нь түүнийг уралдаанд түрүүлнэ гэсэн үг биш байв. Үүнээс гадна ялахад бэлтгэл, ур чадвар шаардагдах байлаа. Кларэнс цуглаанаас гарахдаа “сүмээс хэн ч маргаашийн уралдаан дээр ирэхгүй юм чинь” гэж бодов.

Маргааш орой нь Кларэнс уралдаандаа бэлтгэн биеэ халааж байхдаа нөгөө хоёр номлогчийг 17 орчим насны хөвгүүдтэй хамт зогсож байгааг харжээ. Тэд *ирчихсэн* байв.

Тэднийг дөхөж ирэхэд номлогчдын нэг нь Кларэнст “Хэрэв чи амьдралдаа гүйж байсан л бол өнөө орой хамаг хүчээ гарган гүйх хэрэгтэй шүү” гэж шивнэлээ. Хөвгүүдийн ихэнх нь Сүмийн гишүүн биш байсан ч мэргэн ухааны үг үнэхээр үнэн эсэхийг

мэдэхээр найзуудтайгаа цуг ирсэн байлаа.

Кларэнсийн сэтгэл үймрэв. Энэ уралдаанд түүний хамгийн сайн зүйл нь хангалттай сайн байхгүй байж болох байлаа. Гэхдээ тэр Есүс Христийн сайн мэдээний зарчмын төлөө гүйх гэж байлаа. Тэр түрүүлэх *ёстой* байв. Тэр өмнө нь хэзээ ч түрүүлэхийн төлөө гуйн залбирч байгаагүй ч залбирах хоосон өрөө олов.

Тэр “Тэнгэр дэх Эцэг минь, би мэргэн ухааны үг үнэн гэдгийг мэддэг бөгөөд хэзээ ч үүнийг зөрчиж байгаагүй. Энэ уралдаанд түрүүлэхэд намайг адислаач” гэж залбирлаа. Тэр гарааны шугам руу алхаж явахдаа Тэнгэрлэг Эцэг түүний залбирлыг сонссон гэдгийг мэдрэв. Тэр Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд итгэж байлаа.

Тэр орой бороотой, шавартай байв. Кларэнсийг уралдаж

эхлэхэд, өмнө нь гүйж байсан холын зайн бусад уралдаантай адилхан санагдаж байв. Уралдааны хэмнэл их хурдтай явагдаж байсан ба Данийн аварга түрүүлж байв. Харин Кларэнс гуравдугаар тойргоо дуусгах үеэр гэнэт ядрахаа больсон байна. Тэр илүү хурдан гүйж эхлэхэд саадгүй байлаа. Хурдаа жаахан нэмсэн ч яах ч үгүй зүгээр байв. Тэр Данийн аваргыг гүйцэж түрүүлсэн ч хурд *нэмэгдсээр* байлаа.

Кларэнсийг эргэж ирэх үед дасгалжуулагч нь “Хурдаа хас! Чи барианы шугаманд хүрч чадахгүй!” гэж хашгирав. Гэхдээ Кларэнс гүйж чадна гэдгээ мэдэж байлаа. Тэр уралдаанаа дуусахад Данийн гүйгчээс 46 метрийн урд байв. Тэнгэрлэг Эцэг түүний залбиралд хариулсныг мөн мэргэн ухааны үг үнэн учраас түрүүлсэн гэдгээ тэр мэдэж байлаа. ■

Найзууд ба ИТГЭЛ

Мелисса Харт, АНУ, Юта

GIO ALVERNIA

2 PISO

SALA DE PROFESORES PRIMARIA

DISEÑO GRAFICO

FONOAUDIOLOGIA

ASESORIA ESPIRITUAL

PASTORAL

AUDIOVISUALES BACHILLERATO

TEATRO

MUSICA BACHILLERATO

1 PISO

BALÓN MÚLTIPLE PREESCOLAR

SALA DE PROFESORES PRE-ESCOLAR

COORDINACIÓN DE CONVIVENCIA PRIMARIA

PSICOLOGÍA PRIMARIA

ARTES BACHILLERATO

ENFERMERÍA

CAFETERÍA

ARTES PRIMARIA

0 PISO

BIBLIOTECA

LABORATORIO DE CIENCIAS

LABORATORIO DE QUÍMICA

LABORATORIO DE FÍSICA

LABORATORIO DE MATEMÁTICAS

LABORATORIO DE HISTORIA

LABORATORIO DE GEOGRAFÍA

LABORATORIO DE INGLÉS

LABORATORIO DE ESPAÑOL

LABORATORIO DE FRANCÉS

LABORATORIO DE ITALIANO

LABORATORIO DE PORTUGUÉS

LABORATORIO DE RUSO

LABORATORIO DE JAPONÉS

LABORATORIO DE COREANO

LABORATORIO DE CHINO

LABORATORIO DE HAWAIIANO

LABORATORIO DE NEHUALTL

LABORATORIO DE NAVAHO

LABORATORIO DE AZTECA

LABORATORIO DE MAYA

LABORATORIO DE TAUANO

LABORATORIO DE HAWAIIANO

LABORATORIO DE NEHUALTL

LABORATORIO DE NAVAHO

LABORATORIO DE AZTECA

LABORATORIO DE MAYA

LABORATORIO DE TAUANO

LABORATORIO DE HAWAIIANO

LABORATORIO DE NEHUALTL

LABORATORIO DE NAVAHO

LABORATORIO DE AZTECA

LABORATORIO DE MAYA

LABORATORIO DE TAUANO



Сайн уу!
Намайг
Ивана гэдэг.

Би Колумбын
Боготад амьдардаг
ба найзууд, гэр бүлийн-
хэнтэйгээ сайн мэдээг
хуваалцан, нэр төрөө
өндөрт авч явдаг.



Би охидын католик сургуульд
сурдаг. Миний итгэл үнэмшлийн
зарим хэсэг нь манай ангийнхны
болон багш нарынхаас өөр байдаг
ч тэд намайг хүндэлдэг, би ч
тэднийг хүндэлдэг. Тэд манай
шашныг сонирхдог бөгөөд би
ч шашныхаа талаар тэдэнтэй
хуваалцдаг. Би энд найз
Люсатайгаа хамт байна.

Багш биднийг католикуудтай адилхан зүйлд итгэдэг үү гэж надаас асуухад би бид Есүс Христэд итгэдэг гэж хариулсан. Би бас Мормоны Ном, Библи, Сургаал ба Гэрээний тухай ярьсан.

Аав минь Сүмийн гишүүн биш ч үйл ажиллагаануудад байнга оролцдог. Би түүнийг "католик-мормон" гэж шоглон дууддаг.



Бид Ерөнхий чуулган үзэхээр Солт Лэйк хотод очиж, ерөнхийлөгч Монсоны үг хэлэхийг сонссон. Түүний үгс гайхалтай байсан бөгөөд тэр сайн мэдээний тухай зааж байв.



Намайг сургуулийнхаа нэг найзыг баптисм дээрээ ирэхийг урихад тэр ирсэн. Би энэ үйл явдлаа түүнтэй хуваалцах боломжтой байсандаа талархаж явдаг.



НЭР ТӨРӨӨ ХЭРХЭН ӨНДӨРТ ӨРГӨН АВЧ ЯВАХ ТАЛААР ӨГӨХ ИВАНАГИЙН ЗӨВЛӨГӨӨ


Инээмсэглэж, сүмийн болон судрын түүхийг бусадтай хуваалц.

Ням гараг бүр Сүмийн цуглаанууддаа оролц.

Гэр бүлийн үдшийг хий.

Өдөр бүр судраас уншихыг хичээ.

Колумбын Богота ариун сүм үзэсгэлэнтэй харагддаг. Би хэзээ нэгэн цагт сайн мэдээний тухай илүү ихийг сурахын тулд дотор нь орохыг хүсдэг. Манай найз Лаура надтай хамт ирсэн байна.






Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ахлагч
**Ахлагч М.Рассэлл
Баллард**

НОМЛОГЧДЫГ ХЭРХЭН ДУУДДАГ ВЭ?

Эхлээд бишоп, гадасны
ерөнхийлөгч хоёр тантай
ярилцлага хийнэ.



Дараа нь арванхоёр
төлөөлөгчийн нэг нь
компьютерийн дэлгэцээр
таны зургийг болон таны
тухай мэдээллийг харна.



Тэд таны нүд рүү хардаг.

Дараа нь тэд Их Эзэний Сүнсний хүчээр Сүмийн
409 номлолын нэгэнд таныг томилно.

"Залуучуудын хамгийн агуу үеийнхэн," 2015 оны 4-р сарын
Ерөнхий чуулган, 55-аас аваа.



АСУУХ БУЛАН

“Аав, ээж хоёрыгоо маргалдах үед би санаа зовж, гунигладаг. Би юу хийж чадах вэ?”



Та Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч чадна. Энэ нь миний сэтгэлийг үргэлж онгойлгодог.
Хэйдэн Х., 6 настай, Канадын Алберта



Та аав, ээж хоёртоо асуудлаа шийдэхэд нь туслахын тулд залбирч, өөртөө сайхан мэдрэмж төрүүлэхийн тулд Сүмийн дууллыг амандаа аялж болно.
Аддисон С., 10 настай, АНУ-ын Вашингтон



Би тэднийг инээлгэхийн тулд хөгжилтэй түүх болон сургууль дээр ямар байснаа ярьж өгдөг. Тэднийг инээх үед Ариун Сүнс надад зөв зүйл хийсэн гэдгийг хэлж байгааг би мэдэрдэг.
Елена М., 12 настай, АНУ-ын Калифорни



Би ах, эгч, дүү нартайгаа өрөөндөө орж, табернеклын найрал дуут сонсдог. Энэ надад амар амгаланг мэдрэхэд тусалдаг.
Бэн М., 11 настай, Австралийн Брисбэн



Би аав, ээжийгээ маргалдах үед Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, тэдэнд Сүнсийг мэдэрч, асуудлаа шийдэхэд нь туслахыг гуйдаг.
Итан М., 11 настай, АНУ-ын Калифорни



Макс: Би тэднийг тэвэрч, тэдэнд Есүсийн тухай сануулахын тулд Хүүхдийн хэсгийн дуу дуулж өгдөг.



Гэйб: Гэр бүлээ тэнгэрт байгаагаар зурж, эцэг эхийнхээ сэтгэлийг сайхан болго.
Макс, Гэйб С., 6 болон 10 настай, Энэтхэгийн Кочи

ДАРААГИЙН АСУУЛТ

.....
“Мацаг барьж эхлэх насанд хүрснээ хэрхэн мэдэх вэ?”

Танд энэ талаар өгөх зөвлөгөө байна уу? Хариулт болон зургаа 2016 оны 10-р сарын 31-ний дотор бидэнд ирүүлнэ үү. Та хариултаа онлайн аар liahona.lds.org вэбсайтаар илгээж эсвэл бидэнд liahona@ldschurch.org хаягаар э-мэйл бичиж болно. (Гарчган дээр “Асуултын булан” гэж бичээрэй.) Эцэг эхийнхээ зөвшөөрлийг хамт явуулахаа битгий мартаарай!

Ахмад Моронай зоригтой байсан

Ахмад Моронай нифайчуудын армийг удирддаг байсан. Тэр Тэнгэрлэг Эцэгээ дуулгавартай дагах дуртай байв. Тэр нифайчуудын цэргүүдэд леменчүүдээс өөрсдийгөө хамгаалахад тусалж, тэдэнд Тэнгэрлэг Эцэгийн адислалыг сануулдаг байсан. Тэр тэднийг зоригжуулахын тулд эрх чөлөө, гэр бүлийнх нь тухай сануулдаг байв.



Сургууль дээр олон хүүхэд намайг эвгүй байдалд оруулах үг хэлдэг. Ээж бид хоёр зоригтой байж бас хийж болох хамгийн сайн зүйлийг олж мэдэхийн тулд залбирсан.

Маргааш нь би тэднийг нөгөө үгээ хэлэхэд нь “Ийм үг битгий хэл. Надад эвгүй сэтгэгдэл төрүүлж байна” гэж эелдгээр хэлэв. Тэд “За, уучлаарай” гэлээ. Би дотроо баяртай байсан бөгөөд Тэнгэрлэг Эцэг тусламж хүсэх үед надад тусална гэдгийг мэдсэндээ баярласан.

Бэлла Т., 10 настай, АНУ-ын Виржини



Грант Л., 10 настай, АНУ-ын Флорида



Энэ даалгаврын хуудсыг хайчилж, нугалаад хадгал.




Би зоригтой байж чадна!

- Алма 48:11–12-ыг чээжил. 17-р шүлгийг унш.
- Санаа нь зовж байгаа эсвэл зоригтой байхаас айж байгаа хэн нэгэнд тусал. Тэдэнтэй Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэлээ хуваалц.
- Мормоны Номын түүхүүд номын 31–33, 35-р бүлгийг scripturestories.lds.org-оос үзнэ үү.
- Би өөртөө . . . даалгавар өгөв.

Энэ сард унших судрууд

Чи судрын хэсгийг уншаад, эрх чөлөөний тугтай хэсгийг өнгийн харандаагаар буд.

- 1 Алма 43:9–12, 16–23, 47–54
- 2 Алма 44:1–10, 12, 19–20
- 3 Алма 46:10–16, 21–22
- 4 Алма 53:10–21
- 5 Алма 56:2–11, 41–48, 55–56
- 6 Хиламан 5:20–44
- 7 Хиламан 8:1, 4, 10, 25–28
- 8 Хиламан 9:1–5, 19–24, 39–40





Эрх чөлөөний туг


Моронай нифайчуудыг орон гэр, гэр бүлээ хамгаалахаар леменчүүдийн эсрэг дайнд удирджээ. Ахмад Моронай хувцсаараа “эрх чөлөөний туг” хийв. Тэр нифайчуудад юуны төлөө тэмцэж байгааг нь сануулахын тулд: “Бурханы минь, бидний шашин шүтлэгийн, мөн эрх чөлөөний, бидний энх амгалангийн, эхнэр мөн хүүхдийн минь тухай санамж болгоё” гэсэн онцгой захиасыг бичсэн (Алма 46:12). Үүний талаар 76-р хуудаснаас унш. Дараагийн дугаараас бас нэгэн унших даалгаврыг олж аваарай. ■

Ахмад Моронайн тут

Дээр үед нэгэн ёс
бус хаан байжээ. Тэр
Нифайн хүмүүсийн дээр
засаглахыг хүсэж байв.



Моронай нифайчуудын
цэргийн ахмад байсан. Тэр
хүчтэй бас Бурханд хайртай
хүн байсан.



Ахмад Моронай хүмүүсээ ёс бус хааны цэргүүдээс хамгаалахыг хүсэж байсан юм.



Тэр хүмүүстээ зориулж туг хийхээр шийдэв.



Ахмад Моронайн туг түүний хүмүүст Бурханаа дагаж, гэр бүлээ хамгаалах ёстой гэдгийг сануулж байв. Дараа нь тэд амар амгаланг тогтоох байв. ■

Анхдагч хүүхдүүдийн түүхийг сонсоод

Итгэл үнэмшилтэйгээр ♪ = 120-126

Үг, аяыг
Жэнис Кэп Пэрри

C Dm7 C F G

1. Анх - дагч хүүх - дүү - дийн түү - хийг сон - соод _____ Тэд - ний ит - гэл зори - гоос су -
2. Анх - дагч хүүх - дүү - дийн түү - хийг сон - соод _____ А - дил хүч - тэй бай - маар байна

C F Dm C

раад _____ А - юул ирэ - хэд Их Эзэ - ний хү - чинд _____ Тэ -
би _____ Зарли - гуу - дыг бүг - дийг нь да - гаж би _____ Сайн

G D7 G C Dm7

дэн шиг найд - даг бол - моор байна _____ Бо - шиг - логч - дыг тэ - дэн шиг
гэ - гээн - тэн бай - хыг хи - чээнэ _____ Тойр - сон о - лон найз - даа үл -

C F E7 Am

да - гаж _____ Би ч бас Сио - ныг бай - гуул - маар байна _____ Хэ -
гэр - лэж _____ Тод гэ - рэл - тэх жи - шээ нь бол - но _____ Тэн -

F C Dm7 G7 C

цүү хүн - дийг хийх хэ - рэг гар - вал _____ Хэр - сүү ит - гэ - лээр би үйл - чилнэ. _____
гэр - лэг Э - цэг на - дад найд - даг _____ Тий - мээс би анх - дагч - дыг дуу - райна. _____



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын ерөнхийлөгч
**Ерөнхийлөгч Байд
К.Пакэр (1924–2015)**

СҮНСЛЭГ МАТРУУД

“Ойлгосонгүй, Тэнд ямар ч матар харагдахгүй л байна шүү дээ” гэж би хэлэв.

Би үргэлж Африкт очиж, амьтдыг харахыг хүсдэг байсан бөгөөд эцэст нь тийм боломж надад тохиосон юм. . . .

Амьтдын ус уухаар ирэхийг харахаар бид цөөрмийн дэргэд зогсов. Их халууны улирал байсан болохоор ус гэх юм бараг байхгүй, шавар л харагдаж байсан. Заануудыг шавар руу алхан ороход ус шүүрэн гарч, амьтад зааны мөрнөөс ууж байв.

Ялангуяа гөрөөснүүд ихэд сандран үймэлдэж байлаа. Тэд шаварт ойртон ирснээ шууд эргэн, айдаст автан гүйж одов. Би тэр хавьд ямар ч арслан байхгүйг хараад, тэд яагаад уснаас уугаагүй болохыг хөтчөөсөө асуув. Түүний хариулт буюу сургамж өгөх гэсэн зүйл нь ‘матар’ байсан юм.

Хөтчийг тоглож байгаа болов уу гэж бодоод би түүнээс “Тэгээд асуудал нь юунд байгаа юм бэ?” гэж лавлан асуулаа. Тэрээр дахиад л “матар” гэж хариулав.

“Ойлгосонгүй. Тэнд ямар ч матар харагдахгүй л байна шүү дээ” гэж би хэлэв. . . .

Түүнд итгэхгүй байгааг тэр мэдэж байгаа нь илт байсан тул надад сургамж өгөхөөр шийдсэн бололтой. Бид машинаар дэнж өөд явж, шавартай цөөрөм рүү доош харж болох



газарт очив. “Тэр байна, өөрөө хар даа” гэж тэр хэлэв.

Би шавар, багахан ус, хол зогсох айдаст автсан амьтаас өөр юу ч олж харсангүй. Тэгээд гэнэт би бүхнийг харав. Нэгэн аварга том матар шаварт шигдэн, цангасан зэрлэг амьтан ус уух гэж ирэхийг хүлээн хэвтэж байх нь тэр. . . .

Хөтөч санасныг бодвол надад сайхан хандсан байлаа. Түүнийг эхлээд “матар” гэж хэлэхэд “бүгдийг мэднэ” гэсэн байдлаар тоомжиргүй хандахад маань тэр “Өөрөө очоод, үз дээ!” гэж хэлж болох л байв.

Миний харснаар бол тэнд ямар ч матар байхгүй байсан юм. Би өөртөө итгэлтэй байсан болохоор тэнд юу байгааг олж харахын тулд алхаж ороход ч бэлэн байсан. Миний энэ бардам байдал үхэлд хүргэж болох байлаа! Харин тэр надад сургамж өгөх тэвчээртэй нэгэн байв.

Залуу найзууд минь, би та нарыг хөтөчтэйгөө миний тэр үед байснаас

илүү ухаалаг ярилцана гэдэгт итгэж байна. Бүхнийг мэдэгч болох гэсэн тэр санаа үнэндээ надад ч, бас та нарт ч зохихгүй юм. Би үүгээр бахархдаггүй бөгөөд тус болж магадгүй гэж бодоогүй бол үүнийг та нарт хэлэхээс ч ичих байв.

Амьдралд түрүүлж хөл тавьсан хүмүүс усан цөөрмийг бага ч болов судалсан болохоор матрын талаар сэрэмжлүүлж байгаа юм. Зөвхөн та нарыг хоромхон зуур хэдэн хэсэг болгон тасчих том саарал гүрвэл байгаад зогсохгүй, Африкийн тэрхүү сайтар далдлан нуугдсан матраас ч аюултай, илүү зальтай, бараг харагдахгүй *сүнслэг матруудын* талаар сэрэмжлүүлж байна.

Эдгээр сүнслэг матар нь таны бодгалийг устгах эсвэл бэртээх чадвартай. Тэд таны болон таныг хайрладаг хүмүүсийн амар амгалан байдлыг устгаж чадна. Энэ тухай сэрэмжлүүлэх хэрэгтэй бөгөөд өнөөгийн мөнх бус байдалд тэдгээрээр дүүрээгүй ус гэж тун ховор болсон байна. . . .

Аз болоход, бид зөвлөгөөг нь одоо төдийгүй цаашид дахин авах хүсэлтэй байвал тохиолдож болох эдгээр зүйлээс хамгаалах хөтчүүд бидний амьдралд хангалттай бий. ■

“Сүнслэг матрууд,” Ensign, 1976 оны 5-р сар, 30–31.

ОЙЛГОЛТ



Дайсагнасан дэлхийд бид хэрхэн өсөн хөгжиж болох вэ?

“Үймээн дундах дайсагнасан дэлхийд амьдарч байгаа хувь хүмүүс бид Христийн шавийн хувьд Аврагчийг хайрлах хайранд бат суурилж, Түүний сургаалыг даруухнаар дагах юм бол өсөж хөгжин, цэцэглэх боломжтой.”

Мөн энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



44-р
хуудас

ГЭРТЭЭ ХУГАЦААНААСАА ӨМНӨ ЭРГЭЖ ИРСЭН АСУУДЛАА ШИЙДЭХ НЬ

Номлолоосоо хугацаанаасаа өмнө гэртээ эргэж ирэх нь сэтгэл гонсойлгомоор зүйл байж болох ч дараах зургаан зүйл дээр төвлөрөх нь урагшлах алхам болж болно гэдгийг би мэдсэн.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

АВРАГЧИЙГ санах нь

Долоо хоног бүр бид Есүс Христийг үргэлж санах амлалт өгдөг бөгөөд өдөр бүр тэр амлалтаа биелүүлснээр адислал хүлээн авч чадна.



60-р
хуудас

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ



76-р
хуудас

Ахмад Моронайн туг

Ахмад Моронай хүмүүстээ гэр бүл, Бурхан зэрэг хамгийн чухал зүйлсээ санахад туслах туг хийсэн. Та амьдралынхаа хамгийн чухал зүйлсийг хэрхэн санадаг вэ?

Лиэхона сэтгүүлийн талаар санал, хүсэлт өгөх бол liahona@ldschurch.org хаягаар э-мэйл бичнэ үү.

4



5

МОНГОЛАН

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ